АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2026.01.20 Эрдэнэт хот

| д/д | ЗДҮАХ-т тусгагдсан үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, 2025-2028 /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) 2025 он | | | Хэрэгжүүлэх байгууллага | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин | Төсөв /сая.төг/ | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | Үндсэн | Хамтрагч Оролцогч | | |
| **НЭГ. ХОЙД БҮСИЙН ХӨГЖИЛД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО** | | | | | | | | | | | | | | |
| **Аймаг, орон нутгийн хөгжил** | | | | | | | | | | | | | | |
| 1.1 Аймгийн эдийн засгийн чадамж нэмэгдэнэ | | | | | | | | | | | | | | |
| *1.1.1 Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлээ тэлнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 1 | 1.1.1.1Зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэр технологийн парк байгуулна. | 1.1.1.1.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах. | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 132676.2 | Төслийн гүйцэтгэлийн хувь | 50 | 60 | 43000.0 | 43000.0 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | БОНХОБ ТХ | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн ажил дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: Автозам 60 хувь, төмөр зам (1 ээлж) 100 хувь, төмөр зам (2 ээлж) 10 хувь (тендер зарлагдсан), ус хангамж, ариутгах татуургын систем 100 хувь, ҮТП-ийн гадна цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээг барьж, байгуулах ажлын явц 53 хувь, (Багц №1 ажлын явц 70 хувь, Багц №2 ажлын явц 78 хувь, Багц №3 тендер дахин зарлагдсан), Газрыг тойруулан хашаа барих ажил 93 хувьтай байна. Цахилгаан хангамжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа үргэлжилж байгаа ба 2026 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Автозам, төмөр замыг холбосон үерийн уснаас хамгаалах байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын явц 50 хувьтай. Төслийн гүйцэтгэлийн хувь 64.4 хувьтай байна. | 100% |
| 2 | | 1.1.1.1.2. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах. | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ Гадаад, дотоод зээл тусламж | 2639794.6 | Төслийн гүйцэтгэлийн хувь | 5 | 10 | 804774.5 | 804774.5 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | БОНХОБ ТХ | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголыг АҮЭБЯ-ны дэргэдэх зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний эцсийн тайланг АҮЭБЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хурлын тов хүлээгдэж байна. "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын техникийн даалгаврыг батлуулан, сонгон шалгаруулах бэлтгэл хангах үүрэг бүхий" ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2025 оны 60 дугаар захирамжаар холбогдох яам, газруудаас төлөөлөл оролцуулан байгуулсан ба тус ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөнд "Төслийн хэрэгжилтийн явц, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хувилбар болон сонгон шалгаруулалтын үйл | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | явцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийн төслийг хэлэлцүүлэн батлуулах, стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах" үүргийг ЗГХЭГ, АҮЭБЯ, “Эрдэнэс Монгол” ХХК, “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-д даалгасан. Засгийн газрын хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийн урилга болон ерөнхий мэдээллийг ГХЯ, ЭЗХЯ, СЯ, МҮХАҮТ, МУҮҮА зэрэг холбогдох байгууллагуудаар дамжуулан дэлхийн зэс-металлын салбарын тэргүүлэгч 20 улсын 55 компанид, Олон улсын Хөрөнгө оруулалтын 20 санд, Олон улсын байгууллага, Хөгжлийн 20 банкуудад, түүнчлэн өмнөх жилүүдэд төслийн талаар хамтран ажиллах сонирхлоо илэрхийлж байсан хөрөнгө оруулагчдад холбогдох мэдээллийг нээлттэй хүргүүлж, гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр төслийн талаар мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж байна. Мөн олон улсын global.tenders.com төлбөртэй веб сайтад тендерийн урилгыг байрлуулсан. Тухайн жилийн төлөвлөгдсөн ажил 100 хувь хэрэгжсэн байна. | |
| 3 | | 1.1.1.1.3. Молибдены баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах. | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ Гадаад, дотоод зээл тусламж | 135385.9 | Төслийн гүйцэтгэлийн хувь | 5 | 30 | 41700.0 | 41700.0 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Молибдены баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, Техник технологийн түвшний үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. Үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлах тухай дээд шатны удирдлагын шийдвэр хүлээгдэж байна.<br>Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр зарласан. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлсэн.<br>Молибдены баяжмал боловсруулах үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээ хийх ажлыг “ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн”-тэй гэрээ байгуулан ажилласан. АҮЭБЯ-ны Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэж, дэмжигдсэн байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсны дараа 2026 онд барилгын нарийвчилсан зураг, төсөв боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Молибдены баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын явц 5 хувьтай байна. | 0 |
| 4 | 1.1.1.2 “Сургалт-Эрдэм | 1.1.1.2.1. "Сургалт-Эрдэм | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр | 2650.0 | ТЭЗҮ, зураг төсөв | - | 50 | 2650.0 | Эрдэнэт үйлдвэр | Эрдэнэт үйлдвэр | НБХ | “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын ТЭЗҮ | 0 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоныг байгуулан, шинжлэх ухаанд суурилсан оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоны техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төслийг боловсруулах. | | ТӨҮГ | | боловсруулалтын хувь | | | | ТӨҮГ-400.0 | ТӨҮГ | | боловсруулах болон ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын зардалд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 400.0 сая төгрөг баталж 2025 онд 2 удаа зарласан боловч тендер амжилтгүй болсон. Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сургалт эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор"-ын ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаварт тодорхой өөрчлөлт оруулж дахин боловсруулахад тусгах саналыг Боловсролын яам болон Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн үнэлгээний төвд хүргүүлсэн. | |
| 5 | | 1.1.1.2.2. "Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоны барилгын ажлыг эхлүүлэх. | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 176964.0 | Хотхоны барьсан барилгын тоо /тухайн жилээр/ | - | - | - | | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | НБХ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 6 | 1.1.1.3 Шилжин ирж суурьших иргэдэд ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэн хүн амыг нэмэгдүүлнэ. | 1.1.1.3.1. Орон нутгийн онцлог, давуу тал, боломжуудыг олон нийтэд сурталчлах, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод, ТББ-тай хамтран ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 70.0 | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо /Тухайн жилээр/ | - | 5000 | 10.0 | ОНТ-10.0 | БОНХОБТХ | Төрийн байгууллагууд | 2023 оны 04 дүгээр сард аймгийн ИТХ-ын ээлжит 16 дугаар хуралдааны 15/03 дугаар тогтоолоор шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2022-2024 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, 2023, 2024 онд жил бүр орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөг зарцуулан төлөвлөсөн арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан бол 2025 оны төсөвт 30.0 сая төгрөг тусган төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд 2026 оны төсөвт “Welcome to Erdenet” арга хэмжээний зардалд 30.0 сая төгрөгийг тусгасан. "Колорфилм" студитэй гэрээ байгуулан Эрдэнэт хотод амьдрахын давуу тал, орчин нөхцөлийг харуулсан видео бэлтгэн нийтэд сурталчлан давхардсан тоогоор 6120 хандалт авсан байна. Мөн “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” пэйж хуудсаар Орхон аймгийг сурталчилсан постуудыг түгээн ажиллалаа. 2025 оны 5 дугаар сард "Бүтээлч-Ухаалаг-Тогтвортой" уриан дор "Хойд бүс-Эрдэнэт-2025" эдийн засгийн форумыг зохион байгуулж, Эрдэнэт хотыг 2036 он хүртэл хөгжүүлэх бодлогыг танилцуулан, Ухаалаг хот, Эрүүл оюунлаг хот, Цэвэр агаартай хот төслүүд, тэдгээрийн хүрээнд хэрэгжих 60 дэд төслийг танилцуулан сурталчилсан. | 100% |
| 7 | | 1.1.1.3.2. Төрөөс төвлөрлийг сааруулах чиглэлээр | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Хөнгөлөлтөд хамрагдсан иргэд, аж ахуйн | 528 | 500 | 5.0 | ОНТ-5.2 | БОНХОБТХ | ТГ УБХ Банк санхүүги | Орхон аймагт шилжин ирсэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай ойр ажиллах, мэдээлэл, зөвлөгөө өгөх, тэдэнд тулгарсан бэрхшээл, асуудлыг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлж буй бодлого, хуулийн өөрчлөлтүүдийг иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах. | | | | нэгжийн тоо /Тухайн жилээр/ | | | | | | йн байгуул лагууд | шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, төр, иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ойртуулах, мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор шилжин ирэгчдээс иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511 дугаарын утасны 3 дугаар шугам болон биечлэн ирсэн иргэдэд санал хүсэлтийг нь хүлээн авах, зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр ажилласан. "Хойд бүс-Эрдэнэт-2025" эдийн засгийн форумд бизнес эрхлэгч, иргэдэд "Төрөөс бизнесийг дэмжих бодлого", "Хөрөнгө оруулалтын татварын орчин" сэдэвтэй илтгэлүүдийг танилцуулан мэдээлэл хүргэсэн. Мөн 2024-2025 онд Орхон аймагт шилжин ирсэн 98 багш, эмч нарт хүндэтгэл үзүүлэн төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хуулийн өөрчлөлтүүдийг таниулан сурталчилж, зөвлөгөө өгсөн. 2025 онд орон сууцны 3 хувийн хөнгөлөлттэй зээлд 483 иргэн хамрагдаж, 278 иргэн 31.2 тэрбум төгрөгийн зээлд 5.9 тэрбум төгрөгийн батлан даалт авсан байна. | |
| 8 | | 1.1.1.3.3. Орон нутагт дутагдалтай ажил мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг их дээд сургуулиудтай гэрээ байгуулан, оюутнуудтай уулзалт зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 80.0 | Гэрээ байгуулсан сургуулийн тоо<br><br>Зохион байгуулсан уулзалтад хамрагдсан оюутнуудын тоо<br><br>Төгсөгчдөөс шилжин ирж ажилласан боловсон хүчний тоо /тухайн жилээр/ | 1<br><br>6<br><br>3 | 1<br><br>5<br><br>5 | 20.0 | | БОНХОБТХ | БГ<br>ЭМГ | МУБИС-тай 2023-2026 онуудад хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд тус хамтран ажиллах гэрээний хүрээнд багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр МУБИС-ийн магистрын хөтөлбөрийн сургалтад цэцэрлэгийн 38 багш, бага боловсролын 58 багшийг хамрууллаа. Мөн тус сургуулийн СӨБ-ийн "Багшийн туслах"-ыг чадавхжуулах 3 кредитийн цахим сургалтад 303 багшийн туслах, 18 кредитийн танхим, цахим хосолсон сургалтад 81 багшийн туслахыг хамруулсан байна. 2025-2026 оны хичээлийн жилд Орхон аймагт 50 багш шилжин ирснээс шинэ төгсөгч 14 байна. | 100%<br><br>0<br><br>100%<br><br>Дундаж 66.7% |
| 9 | 1.1.1.4 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж "Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв" байгуулна. | 1.1.1.4.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж "Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв"-ийн засвар, тохижилтын ажлыг хийж, тоног төхөөрөмжөөр хангах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 1100.0 | Засвар, тохижилтын ажлын гүйцэтгэл. хувь<br><br>Тоног төхөөрөмжийн хангалт. хувь /өссөн дүнгээр/<br><br>Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо | -<br><br>-<br><br>70 | 100%<br><br>-<br><br>80 | 350.0 | ОНТ- 520.0 | ЭМГ | НБХ<br>БОЭТ | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн орон нутгийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийг 2025 онд өргөжүүлэн нийт 223.4м2 талбайд үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэг, хавдрын амбулаторийн үзлэг, хавдрын бүртгэл, эхо оношилгоо, мэс заслын эмчийн үзлэг, хими бай эмчилгээний өрөөг байгуулж, үйлчлүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлсэн. Тайлант хугацаанд тус төвөөр нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдаж, шинээр 147 хавдар илэрч, идэвхтэй хяналтад 458 иргэнийг аваад байна. Нийт хавдрын 53.7 хувь нь эрт үедээ, 46.3 хувь нь хожуу үедээ оношлогдсон. Хими эмчилгээнд тайлант хугацаанд | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | /Тухайн жилээр/ | | | | | | | 505 хүн, бай эмчилгээнд 161 хүн хамрагдсан байна.<br>Эмгэг судлалын оношилгоо, гистологи, эсийн шинжилгээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор улсын төсвөөс 800.0 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн багц тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлж, суурилуулан ажиллуулснаар эд эсийн түвшний оношилгооны чадавх нэмэгдсэн байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 42 дугаар тогтоолоор Эрдэнэт Медикал эмнэлгийг Хавдар Судлалын Үндэсний төвийн харьяа Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв болгосон. Ингэснээр Хойд бүсийн хэмжээнд хавдрын төрөлжсөн тусламж үйлчилгээг үе шаттай үзүүлэхээр 2026-2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө батлагдан, 98 ортой эмнэлгийн зураг төсөв хийгдээд байна. ХСҮТ-өөс элэг, улаан хоолой, хөх, зөөлөн эд, өндгөвч, бөөр, давсаг, нойр булчирхай, бүдүүн гэдэс, хүзүүний хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр 3 эмч 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн ажиллаж нийт 111 иргэнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна. 2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд 213 иргэнд нийт 120.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон ба шинээр батлагдсан 294 хавдрын тохиолдлын 72.4 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна.<br>Тайлант хугацаанд Орхон аймагт 294 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдож, 10000 хүн амд 27.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 промиллоор буурсан. | |
| 10 | 1.1.1.5 Тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлж, бүсийн импорт, экспортын тээвэрлэлтийн зангилаа хот болон хөгжинө. | 1.1.1.5.1. Хойд бүсийн тээвэр логистикийн төвийн судалгааг хийж, ТЭЗҮ-ийг боловсруулах. | 2025-2028 | Улсын болон Орон нутгийн төсөв | 40.0 | ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэл. хувь | - | - | - | | БОНХОБТХ | ГХБХБГ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 11 | | 1.1.1.5.2. Хойд бүсийн тээвэр логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж эхлүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Ажлын гүйцэтгэл. хувь /өссөн дүнгээр/ | - | - | - | | БОНХОБТХ | ГХБХБГ ААНБ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2027 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | | | | |
| **Гэр бүл, хүн амын бүлгүүд** | | | | | | | | | | | | | | |
| 2.1. Гэр бүлийн гишүүд болон хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоо хангагдана. | | | | | | | | | | | | | | |
| *2.1.1Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйл ажиллагаа тогтмолжиж, гэр бүлд чиглэсэн олон талт үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 12 | 2.1.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг | 2.1.1.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц | 2025-2028 | Улсын болон орон нутгийн | 70.0 | Гэр бүлийн хөгжлийн цогц төв | - | Гэр бүлийн хөгжлийн | Үйл ажиллагаа эхлүүлнэ. | УТ-3.2 ОНТ-38.6 | ХГБХХГ | НБХ Сумдын ЗДТГ | Гэр бүлийн ордныг гэр бүлийн цогц төв болгон өөрчлөх зураг төсвийг боловсруулахад шаардлагатай төсвийг | 10% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулан ажиллуулж, гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | төвийг байгуулж, гэр бүлийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх. | | төсөв | | байгуулагд сан эсэх<br><br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/ | 14515 | цогц төвийг байгуулна<br><br>14950 | 16.0 | | | Төрийн болон ТББ-ууд | 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулж, ажлын даалгаврыг батлуулан зураг төсвийг “Үүлэн прожект” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Гэр бүлийн цогц төв байгуулж ХГБХХГ-ын харьяанд шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>Тайлант онд гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн аян, өдөрлөг, сургалт, уулзалт зэрэг 62 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 15000 иргэн, 5000 гаруй өрх хамрагдсан байна.<br>“Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяны хүрээнд гэр бүлийн өдөрлөг, гэр бүлийн харилцаанд хэвшүүлэх дадал сэдэвт өглөөний уулзалт, залуу гэр бүлийн сэтгэл зүйн өдөрлөг, хүүхэд хүмүүжлийн зэрэг арга зүйн сургалт, цахим нөлөөллийн арга хэмжээ зэрэг 8 төрлийн үйл ажиллагаанд 4114 иргэн, гэр бүлийн гишүүдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх, эерэг харилцааг дэмжих чиглэлээр “Аз жаргалтай гэр бүл”, “Супер аав”, “Зоригтой хайр”, “Ээж охидын болзоо”, “Дурсамж үлдээх болзоо”, “Угийн бичиг–Удмын түүх”, “Чиглүүлэгч ээж” зэрэг 22 төрлийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 10886 иргэнийг хамруулсан байна.<br>Мөн түүврийн аргаар аймгийн нийт өрхийн 1.2 хувь буюу 361 өрхийн дунд гэр бүлийн суурь судалгааг хийж, гэр бүлд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг үнэлж цаашид авах арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөх, учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох, салбар дундын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Бүх хайраа гэр бүлдээ” зорилтот төслийг боловсруулаад байна.<br>2025 онд Гэр бүлийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвөөс 3.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 38.6 сая, нийт 41.8 сая төгрөгийг зарцуулсан байна. | 100%<br><br>Дундаж 55.0% |
| 13 | | 2.1.1.1.2. “Оюунлаг хот-Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 204.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Хөтөлбөр ийг боловсруу лан батлуулна | 300.0 | ОНТ-754.0 | НБХ | Төрийн болон ТББ-ууд | Аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 24-ний 02/16 дугаар тогтоолоор “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан. Хөтөлбөрийг 2025-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилт, 78 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 754.0 сая төгрөг зарцуулан хэрэгжүүлсэн.<br>Эрүүл мэндийн салбарт гадаад дотоодын сургалт, эрэгтэйчүүдийн үзлэг, урьдчилан сэргийлэлт, залуучуудын БЗДХ-ын эрт илрүүлэг, үзлэг, ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | эрүүл мэндийн туршлага судлах, нотолгоонд суурилсан эмчилгээ технологи нэвтрүүлэх судалгаа, ёс зүй харьцаа хандлагын сургалт зэрэг 20 гаруй удаагийн сургалт, арга хэмжээнд 150.0 сая төгрөг, боловсролын салбарт масс сургалтын чанарыг дээшлүүлэх сургалт, ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх урьдчилсан сорил, багш нарын ур чадвар, арга зүйн уралдаан, багш ажилтнуудын эрдэм, шинжилгээ, онол практикийн хурал, сайн хичээл үйл ажиллагаа, туршлага судлах, багш нарын өдрийн арга хэмжээ, чанарын удирдлага тогтолцоо нэвтрүүлэх зэрэг 25 удаагийн арга хэмжээнд 59.9 сая төгрөг, соёлын салбарт албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх 8 удаагийн сургалт, туршлага судлах арга хэмжээ, жужгийн зардал зэрэг 10 гаруй удаагийн арга хэмжээнд 47.0 сая төгрөг, нийгмийн салбарын албан хаагчдыг хөгжүүлэх ментор бэлтгэх, сэтгэл зүйн түвшний судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа, сэтгэл зүйн дархлаатай хамт олон төсөл хэрэгжүүлэх, Удирдлагын академийн богино, дунд, ахлах мэргэшүүлэх багц сургалтад 3 байгууллагын 26 албан хаагчийг сургах, судлаач албан хаагч бэлтгэх академик сургалт, онол практикийн бага хурал зохион байгуулах, сэтгэл зүйн харилцаа сургалт, хэвлэл мэдээллээр сурталчлах зэрэг ажлуудад нийт 116.0 сая төгрөг, залуучууд, эмэгтэйчүүдийн чиглэлээр 18 төрлийн арга хэмжээнд 90.0 сая төгрөг, ахмадын чиглэлээр 18 удаагийн арга хэмжээнд 90.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажилд 5 ТББ, 7 төрийн байгууллагатай хамтарсан 10 гаруй төрлийн үйл ажиллагаанд 30.0 сая төгрөг, нийт 754.0 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулж ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2026 оны 03 дугаар сард аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | |
| 14 | 2.1.1.2. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, багуудад хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, салбар дундын | 2.1.1.2.1. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, “Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” ажиллуулах. | 2025-2028 | Улсын төсөв | 244.0 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо<br><br>Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны тоо | 32000<br><br>- | 35100<br><br>2 | 52.0 | УТ-55.0 | ХГБХХГ | НБХ Сумдын ЗДТГ Төрийн болон ТББ-ууд | Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оноос 2 сум, 29 багт, нийт 24 Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулж, хүүхдийг эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус 22 байгууллагатай хамтран 173 удаагийн сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулан нийт 38324 иргэнийг хамруулсан. (Үүнд: 28125 хүүхэд, 10199 насанд хүрэгч байна.)<br>Цахим орчинд хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг соёл, урлагийн байгууллага болон ерөнхий боловсролын 7 | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болон хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна. | | | | | | | | | | | | сургуулийн нийт 430 хүүхэд залуучууд, багш нарыг хамруулсан.<br>Мөн хорт зуршил, үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", "Үе тэнгийн дээрэлхэлт ба түүний хор уршиг", "Харах өнцөгтэй хайр нэмье" сэдвүүдээр 7 сургуулийн 4190 сурагч, 780 насанд хүрэгчид 35 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 6 төрлийн 1535 ширхэг гарын авлагыг түгээсэн.<br>36 сургууль, цэцэрлэгийн 9321 хүүхдэд "Аврагч мазаалай", "Гүүмби Жүүмби" видео сургалтыг зохион байгуулан "Аюулгүй амьдрах ухаан" хөтөлбөрийн хүрээнд 19 сургуулийн 1521 сурагчийг сургалтад хамруулсан байна.<br>Сум багийн хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 77 удаагийн сургалтыг багийн иргэдэд зохион байгуулж 4288 насанд хүрэгч хамрагдсан байна. Улсын төсвөөс 56.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 15 | | 2.1.1.2.2. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх үйл ажиллагааг эрчимжүүлэн, салбар дундын үйл ажиллагааг сайжруулж, хяналт шалгалтыг зохион байгуулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 140.0 | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийн тоо<br><br>Нээж ажилласан кейс үйлчилгээний тоо | 606<br><br>250 | 620<br><br>280 | 20.0 | | ХГБХХГ | НБХ Сумдын ЗДТГ Төрийн болон ТББ-ууд | Тайлант хугацаанд 630 хүүхдийг эрсдэлийн программд шинээр илрүүлэн бүртгэж, давхардсан тоогоор 2369 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлснээс өндөр эрсдэлтэй 297 хүүхдэд кейс нээн ажилласан байна. "Гэр бүлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх" хөтөлбөрийг 2 сарын хугацаанд хэрэгжүүлж 19 багийн 66 хүүхэд, 40 эцэг эхийг нийт 356 удаагийн сэтгэл заслын үйлчилгээнд хамруулсан. Гэр эргэлтийн хүрээнд 305 өрхийн 915 хүүхдэд эргэн хяналт хийж, эрсдэлийн үнэлгээг шинэчлэн 42 өрхийн 240 хүүхдийн эрсдэлийг бууруулан хамгааллын үйлчилгээ үзүүлсэн.<br>Мөн үер усны эрсдэлтэй бүсэд амьдарч байгаа болон хүчирхийллийн эрсдэлтэй 487 хүүхдийг "Монгол даатгал" ХК-ийн даатгалын үйлчилгээнд хамруулж, 25 багийн 232 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, хөгжлийн хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлсэн.<br>Эрүүл мэндийн чиглэлээр 27 багийн 100 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлж, амралт, хөгжлийн үйлчилгээний хүрээнд 90 хүүхдийг "Янзага" зусланд 5 хоног үнэ төлбөргүй амраасан.<br>Зорилтот өрхийн хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 23 багийн 319 хүүхдэд түлээ, хоол хүнс, эм, хувцас зэрэг нэн шаардлагатай дэмжлэгийг гэр бүлийн орчинд нь үзүүлсэн. Үүнд улсын төсвөөс 101.6 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2025 онд нийт 2369 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлснээс өндөр эрсдэлтэй 297 хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна.<br>Хүүхдийн эрхийг хамгаалах зөрчлөөс урьдчилан сэргийлэх, салбар дундын | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд нийт 108 объектод хяналт шалгалт зохион байгууллаа. Шалгалтаар өдөр өнжүүлэх, амралт, худалдаа үйлчилгээний газар, шашны байгууллага зэрэг нийт 8 байгууллагад илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж, албан шаардлага хүргүүлж,хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллалаа. | |
| 16 | | 2.1.1.2.3. Өсвөр үеийн охид хөвгүүдийн дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 20.0 | Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо<br><br>Нууцлалтай чатбот үйлчилгээг нэвтрүүлсэн эсэх | 150<br><br>- | 200<br><br>- | 3.0<br><br>- | УТ-2.0 | ХГБХХГ БГ | НБХ Сумдын ЗДТГ ЭМГ | ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 9 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 302 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулсан.<br>Өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр “Үе тэнгийн зөвлөгч бэлтгэх” сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 19 сургуулийн 50 хүүхдийг үе тэнгийн зөвлөгчөөр бэлтгэж, 5 цогц цахим арга хэмжээнд 98468 иргэнд мэдээлэл түгээсэн.<br>Үе тэнгийн зөвлөгч сурагчидтай хамтран “Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё” сургалт, хэлэлцүүлгийг ЕБС-ийн 19 сургуулийн дунд, ахлах ангийн 101 бүлгийн 2702 сурагчдад зохион байгуулж, 552 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан. Мөн эдгээр хүүхдүүдэд зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, бэлгийн бойжилт, хувийн ариун цэвэр, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө бүхий 18 төрлийн 3155 гарын авлагыг түгээж, 13 төрлийн постерыг 68219 иргэнд, 4 төрлийн видео шторкийг 23840 иргэдэд цахим хуудсаар түгээсэн байна. Мөн өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл түгээх фэйсбүүк хуудас болон шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах чатбот үйлчилгээг хөгжүүлэн ажиллуулж байна. Улсын төсвөөс 2.0 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 17 | 2.1.1.3.Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ. | 2.1.1.3.1<br>Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэн, эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | 240.0 | Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо /өссөн дүнгээр/ | 15 | 20 | 60.0 | УТ-42.8 | ХГБХХГ БГ | НБХ Сумдын ЗДТГ | Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 иргэнд шинээр хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрлийг олгож, хүүхэд харах үйлчилгээнд 25 хүүхэд, өдөр өнжүүлэх төвд 150 хүүхэд хамрагдаж байна.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 7 хүүхэд харагчийг “Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог” сургалтад хамруулж, мэргэжлийн чадварыг нь нэмэгдүүлсэн. Мөн тэдний сэтгэл зүйн дэмжлэгт чиглэсэн “Сэтгэл нэмье” сургалт, нөлөөллийн ажлыг 5 удаа зохион байгуулж, 40 хүн хамрагдсан. Тайлант хугацаанд хүүхэд харах үйлчилгээнд улсын төсвөөс нийт 42.8 сая төгрөгийн санхүүжилт олгон ажилласнаар хүүхэд харах үйлчилгээг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зохион байгуулснаар эцэг, эхчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож байна. | |
| 18 | | 2.1.1.3.2. Хүүхдийн зуслангийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагаа явуулж буй зуслангуудад мэргэжил, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | 40.0 | Зуслангийн тоо<br><br>Зусланд хамрагдсан хүүхдийн тоо /тухайн жилээр/ | 3<br><br>4200 | 3<br><br>4250 | 10.0 | УТ-32.8<br>ОНТ-277.5 | ХГБХХГ | НБХ<br>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ<br>Хувийн хэвшлийн сургууль | Тайлант онд аймгийн хэмжээнд нийт 4 зуслан үйл ажиллагаа явуулж 3251 хүүхэд хамрагдсан.<br>2025 онд “Янзага” зусланд орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар, шинэчлэлийн ажил хийгдэж, хоолны заал, хүнсний агуулах, талхны цех, захиргааны байрыг засварлаж, шинээр Канад технологийн хүүхдийн амралтын 4 байр ашиглалтад орсноор хүүхдүүдийн амрах орчин нөхцөл сайжирсан. Үүний үр дүнд “Янзага” зусланд 1200 хүүхэд амарсан нь өмнөх онтой харьцуулахад 100 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн зуслангийн цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 400 кВт чадалтай, 6/0.4 кВ-ын хүчдэлийн тохируулгатай трансформатор шинээр суурилуулж, 70.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.<br>2025 онд “Найрамдлын эрдэнэс” зусланд халдварт өвчин гарсантай холбогдуулан зуслангийн 3 дугаар ээлжээс хойш амрагч хүүхдүүдийг аваагүйгээс зусланд амарсан хүүхдийн тоо өмнөх оноос 43 хувиар буурсан байна.<br>Тайлант онд Янзага зусланд зорилтот бүлгийн 360 хүүхдийг амруулах зардлыг төлж амраахад улсын төсвөөс 32.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 27.5 сая төгрөг зарцуулсан байна. | 100%<br><br>0%<br><br>Дундаж 50.0% |
| 19 | 2.1.1.4. Залуучуудын боловсрол, хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах бодлогыг хэрэгжүүлнэ. | 2.1.1.4.1 Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, хувь хүний хөгжил, гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 120.0 | Сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээнд хамрагдсан залуучуудын тоо /тухайн жилээр/ | 10560 | 11616 | 30.0 | ОНТ-110.0 | НБХ<br>СУАЖЗГ | СУАЖЗГ<br>ХГБХХГ | Тайланд онд залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, хувь хүний хөгжил, гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн 30 арга хэмжээг зохион байгуулж 11880 өсвөр үе, залуучуудыг хамруулан, цахим хуудсанд байршуулж 12350 иргэнд мэдээлэл хүргэн ил тод байдлыг хангасан. Тус арга хэмжээнүүдэд орон нутгийн төсвөөс 110.0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд:<br>○ Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран Зэвсэгт хүчний 186, 110 дугаар ангийн ахлагч нарт “Гэр бүл төлөвлөлт”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр танхимын сургалтыг 4 удаа зохион байгуулж 1650 залуучууд хамрагдсан.<br>○ Баян-Өндөр сумын 26 багийн залуучуудын хөгжлийн зөвлөлийн 400 гаруй албан хаагчдад “Ажлын байрны стресс”, “Манлайлагч залуу” сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br>○ Биеийн тамир спортын газартай хамтран эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг өсвөр үе, залуучуудад таниулан эрүүл мэндийн боловсрол | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | олгох сургалт, нөлөөллийн 6 удаагийн ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж цахим нөлөөллийн үйл ажиллагааг сурталчлан таниулж, төрийн болон төрийн бус 25 байгууллага давхардсан тоогоор 2350 ажилтан, албан хаагчид хамрагдсан.<br>○ “Залуучуудын хөгжил-оролцоо-өөрчлөлт” чуулганыг зохион байгуулж, 500 гаруй залуучууд хамрагдаж салбар бүрийн төлөөлөл болсон залуучуудыг хамруулсан.<br>○ Харилцаа хандлага болон хайрын 5 хэл “Гэр бүлийн харилцаа”, “Хосын харилцаа”, “Мансууруулах бодисын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 2550 залуучуудыг хамруулсан.<br>○ “UNCHAINED GUYS” хүлээсгүй, эрх чөлөөтэй залуус цахим нөлөөллийн ажил зохион байгуулж 7350 хүнд мэдээлэл хүргэсэн.<br>○ “Морьтон залуус” арга хэмжээг зохион байгуулж Малчин багийн 120 залуус хамрагдсан.<br>○ “Mongolian try-2025” арга хэмжээнд аймгийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн гишүүд ажлын хэсэг байгуулан 40 залуучуудыг хамруулж сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br>○ Залуучуудын ордны 209 тоот өрөөнд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж нийт 320 залуучуудад ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгсөн.<br>○ Залуучуудын манлайллыг идэвхжүүлэх “ACTIVE YOUTH-2025” залуучуудын сарын аян 2025 оны 09 дүгээр сарын 15-аас 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 15 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж 4150 залуучуудыг хамруулсан. Мөн иргэний андгай өргөх ёслол, Эх оронч залуус арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 20 | | 2.1.1.4.2. Залуучуудын сайн дурын ажилд оролцох идэвх, санаачилгыг дэмжин холбон зуучилж, сайн дурын ажилтанд батламж, урамшуулал олгох. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 26.0 | Сайн дурын ажилтны тоо<br><br>Сайн дурын ажилд оролцсон иргэдийн тоо /Өссөн дүнгээр/ | 57<br><br>2050 | 70<br><br>2200 | 5.0<br><br>- | | НБХ СУАЖЗГ | Залуучуудын салбар зөвлөл | Залуучуудын сайн дурын ажилд оролцох идэвх, санаачилгыг дэмжин холбон зуучлах сайн дурын ажил хийх сонирхолтой 80 залуучуудыг бүртгэж, сайн дурын ажилд 150 залуучуудыг холбон зуучилж ажилласан. Мөн “ACTIVE YOUTH-2025” залуучуудын сарын аяны хүрээнд “Сайн дурын ажил” тугийг 20 төрийн болон төрийн бус байгууллагуудаар аялуулан нийт 43 сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 10580 залуучуудыг хамруулан бүх нийтийн хог цэвэрлэгээ, тоглоомын талбайн засвар, цэвэрлэгээ | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | үйлчилгээ, сургалт нөлөөллийн ажил, витаминжуулалт, албан байгууллагын хүүхдийн өрөөг тохижуулах зэрэг ажлууд зохион байгуулсан. Мөн цахимаар 8 постер бэлтгэн өөрсдийн цахим хуудсанд байршуулан 17076 иргэнд мэдээлэл хүргэсэн. | |
| 21 | 2.1.1.5. Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайлал, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эдийн засгийн чадавхийг дээшлүүлнэ. | 2.1.1.5.1 Гэртээ хүүхдээ хардаг болон хувиараа бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдэд ур чадвар олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагаагаар зохион байгуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 16.0 | Ур чадвар олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо<br><br>Ажлын байраар хангагдсан эмэгтэйчүүд-ийн тоо /өссөн дүнгээр/ | 20<br><br>10 | 100<br><br>15 | 4.0<br><br>- | ОНТ-8.0 | НБХ ХГБХХГ | Сумдын ЗДТГ ТББ-ууд | Гэртээ хүүхдээ хардаг болон хувиараа бизнес эрхэлдэг ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах холбоо” ТББ-тай хамтран оёдол, нэхмэл, эсгий урлал, гар урлалын чиглэлээр ээжүүдэд чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 100 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж, 5 ээж “Хамтдаа урлая” урланд ажилд орж, орлогоо нэмэгдүүлсэн үр дүнтэй байна. Тус холбоонд нийт 70 гаруй ээжүүд хамтран өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр оёдол, нэхмэл, эсгий урлал, гар урлалын 10 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний өрхийн үйлдвэрлэл явуулдаг. Мөн ХХҮГ-тай хамтран ур чадвар олгох сургалтыг 2 мэргэжлээр зохион байгуулж давхардсан тоогоор нийт 80 эмэгтэйг хамруулж, 30 эмэгтэйд ур чадварын гэрчилгээ олгосон. Дээрх арга хэмжээнүүдэд орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулсан байна. | 100% |
| 22 | | 2.1.1.5.2 Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллын чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 184.0 | Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллын чиглэлээр олон талт арга хэмжээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо /өссөн дүнгээр/ | 4500 | 5100 | 46.0 | ОНТ-58.0 | НБХ ХГБХХГ | Сумдын ЗДТГ ТББ-ууд | Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллын чиглэлээр 4 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, нийт 4600 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж, орон нутгийн төсвөөс 58.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр “Эрдэнэсийн ээжүүд” нөлөөллийн арга хэмжээг “Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, дуу хоолой” сэдвийн хүрээнд зөвлөгөөн зохион байгуулж, салбар бүрийн эмэгтэйчүүдийн төлөөлөл 450 эмэгтэй хамрагдсан.<br>Хувь хүний боловсрол судалгааны төв ТББ-тай хамтран Эмэгтэйчүүдийн хөгжил манлайллыг нэмэгдүүлэх, бизнесийн харилцааны ур чадвар олгох сургалтыг үйлчилгээний салбарын 150 эмэгтэйд зохион байгуулсан.<br>Эмэгтэйчүүдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдийн дуу хоолой” уулзалт, хэлэлцүүлэг төрийн болон төрийн бус байгууллагын 450 гаруй эмэгтэйг хамруулж тэдэнд тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлж, нийгмийн оролцоо нэмэгдсэн. Эрдэнэт сороптмист НҮТББ-тай хамтран агаа эгээ төслийг хэрэгжүүлэн үе тэнгийн найзаа суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 сургуульд “агаа эгээ” төслийг хэрэгжүүлж, нийт 60 сурагчийг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | ментороор бэлтгэн амьдрах ухаан, нөлөөллийн сургалт, бүлгийн ярилцлага зэргийг тогтмол зохион байгуулж давхардсан тоогоор 1500 гаруй өсвөр үе залуучуудыг хамруулсан. Мөн хорт зуршил, үе тэнгийн дээрэлхэлтийг эсрэг гарын авлага брошур бэлтгэн 2050 хүүхдэд хүргэж мэдээлэл өгсөн. | |
| 23 | 2.1.1.6.Иргэд, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2.1.1.6.1 Иргэд, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | 140.0 | Сэтгэл зүйн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/ | 1550 | 2180 | 35.0 | УТ-3.5<br>ОНТ-30.0 | ХГБХХГ<br>БГ | НБХ<br>Сумдын ЗДТГ<br>ЭМГ<br>ТББ-ууд | Иргэдийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ, бүлгийн ярилцлага, зөвлөгөөнд давхардсан тоогоор 2334 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас түр саатуулагдаж буй иргэдэд ШШГГ, ЦГ- тай хамтран 10 удаагийн сэтгэлзүйн сургалт, зөвлөгөөнд 100 иргэнийг хамруулсан.<br>Сэтгэл зүйн явуулын үйлчилгээний хүрээнд Жаргалант сум, Политехник коллежийн нийт 65 сурагч, оюутанд бүлгийн ярилцлага, 3 хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөө үзүүллээ.<br>Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдэд зориулсан “Би болон бидний ирээдүй” сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг 8 удаагийн давтамжтайгаар Наран, Уртын гол, Рашаант, Цагаанчулуут багийн 150 иргэнд зохион байгуулж, ганцаарчилсан зөвлөгөөг үзүүлсэн.<br>“Тэмүүлэлтэй өсвөр нас”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн аялал” бүлгийн сургалт, зөвлөгөөнд 950 иргэнийг хамруулсан байна.<br>Шүүхийн тамгын газрын дэргэдэх гэр төслийн хүрээнд гэр бүл цуцлуулах өргөдөл өгсөн 200 гаруй гэр бүлийн гишүүдэд бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөөнд давхардсан тоогоор 1069 иргэнийг хамруулж, 48 гэр бүл эвлэрсэн үр дүнтэй байна.<br>Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулахад улсын төсвөөс 3.5 сая, орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг тус тус зарцуулсан. | 100% |
| *2.1.2.Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжиж нийгмийн оролцоо нэмэгдэнэ* | | | | | | | | | | | | | | |
| 24 | 2.1.2.1.Ахмад настны амьжиргааг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2.1.2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан хөтөлбөрийн хүрээнд ахмадуудыг санхүүгийн дэмжлэгт хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. | 2025-2028 | Улсын төсөв | 365.0 | Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын тоо /тухайн жилээр/ | 17 | 20 | 88.0 | УТ-197.0 | ХХҮГ | НБХ<br>Сумдын ЗДТГ<br>Ахмадын хороо | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд өрхийн хөдөлмөр эрхлэн өөрсдийгөө ажлын байраар хангаж байгаа 21 ахмад настанд нийт 197.0 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй зээлийг 24 сарын хугацаатай олгож санхүүгийн дэмжлэгт хамруулсан. Мөн аймгийн Ахмадын хороо, Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран багууд болон ахмадуудын хөгжил оролцоог хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын гишүүн ахмадуудад 6x20 хэмжээтэй 18 хүлэмжийг хүлээлгэн өгснөөс 9 ахмад хүлэмжийн тариалалт хийж, хавар, зун, намрын улиралд амжилттай ажиллуулж олон төрлийн нарийн ногоог хураан авч өөрсдийн хэрэгцээгээ хангаж, | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хэрэгцээнээс илүү гарсан бүтээгдэхүүнийг зарж борлуулсан байна. | |
| 25 | | 2.1.2.1.2. Ахмад мэргэжилтнүүд ийн зөвлөх үйлчилгээг зохион байгуулах. | 2025-2028 | Улсын төсөв | 196.0 | Хамрагдсан ахмадын тоо | 30 /сүүлийн 5 жилийн дундаж/ | 32 | 48.0 | УТ-42.1 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ Ахмадын хороо | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамргадах хүсэлт ирүүлсэн 17 байгууллагын 39 ахмад настантай гэрээ байгуулан 42.1 сая төгрөгийн урамшууллыг ХЭДС-аас олгосон. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан 7 ТББ-тай хууль эрх зүй, боловсрол, инженер техникийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөхөд нь 197.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 2 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж 3 сарын урамшуулалд 3.8 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. | 100% |
| 26 | 2.1.2.2. Ахмад настны асаргаа сувилгааны хувилбарт үйлчилгээг эрэлт, хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлж, тэдний эрүүл мэндийн болон нийгмийн хөгжлийг дэмжинэ. | 2.1.2.2.1. Ахмад настанг дэмжихэд чиглэсэн олон талт нөлөөллийн ажлууд зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | Батлагд сан төсвийн хүрээнд | Хамрагдсан ахмадын тоо /өссөн дүнгээр/ | 14000 | 14500 | 100.0 | ОНТ-45.0 | НБХ | Аймгийн Ахмадын хороо | Ахмад настанд чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийт 45.0 сая төгрөгийн санхүүжилтийг Ахмадын хороонд олгосон. 2025 онд ахмадуудын дунд 15 удаагийн урлаг соёлын арга хэмжээнд 1739 ахмад, биеийн тамир спортын 7 удаагийн арга хэмжээнд 777 ахмад, 21 удаагийн сургалт мэдээллийн ажил үйлчилгээнд 2111 ахмад, идэвхтэй насжилтыг дэмжих үйл ажиллагаанд 400 ахмад, 3 удаагийн хүндэтгэлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 31021 ахмад тус тус хамрагдсан байна. | 100% |
| 27 | | 2.1.2.2.2. Ахмад настны асрамжийн газар байгуулах санал санаачилгыг дэмжин ажиллаж, асаргаа, сувилгааны мэргэжлийн байгууллагуудтай хамтран ахмад настны асаргаа сувилгааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Асаргаа, сувилгааны хувилбарт үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо /тухайн жилээр/ | - | 80 | Батлагд сан төсвийн хүрээнд | УТ-56.6 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ ТББ-ууд | Ахмад настны тухай хуулийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант суманд "Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ", Жаргалант суманд "Ахмад настныг өдрөөр асрах үйлчилгээ, Гэрээр асрах /явуулын/ үйлчилгээ" үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж Баян-Өндөр, Жаргалант сумдын Ахмадын хороо ТББ-ууд шалгарч дээрх үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэснээр Баян-Өндөр суманд 568, Жаргалант суманд 200 ахмад хамрагдан лавлагаа, мэдээлэл, хууль, эрх зүй, сайн дурын үйлчилгээ, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнүүдийг үзүүлсэн.<br>Аймгийн ИТХ-ын хурлаар батлуулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын жагсаалтад батлагдсаны дагуу аймгийн ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллыг “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа сувилгааны төв” болгон өөрчлөн зохион байгуулж, “Хөвсгөл хамгаалал”ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхээр 2025 оны 12 дугаар сард үйл ажиллагааг эхлүүлээд байна. | 100% |
| *2.1.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, орчны дэд бүтцийн хүртээмж сайжирна.* | | | | | | | | | | | | | | |
| 28 | 2.1.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд | 2.1.3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй | 2025-2028 | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтад хамрагдсан хөгжлийн | 10 | 12 | Батлагдсан төсвийн хүрээнд | УТ-7.8 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ | Сургалтын эрх бүхий байгууллагатай хамтран “Аж ахуй эрхлэлт”-ийн сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан мэргэжлийн сургалт, дадлагажуулалт, хөдөлмөр эрхлэлтэд зуучлах үйлчилгээг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. | иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | | | | бэрхшээлтэй иргэний тоо<br><br>Ажлын байраар хангагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо | 42 | 45 | | | | ААНБ-ууд | 20 иргэн хамрагдаж төсөл бичих, бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлалд суралцан, сургалтын зардалд ХЭДС-аас 1.8 сая төгрөг зарцуулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, сургалтын төвийн захиалгаар чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг “Уран гар” сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр зохион байгуулж 9 иргэнийг хамруулан, сургалтын зардалд нийт 6.0 төгрөгийг зарцуулсан.<br>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн ажлын байранд зуучлагдан, 33 иргэн байнгын шинэ ажлын байранд нийт 58 иргэн ажлын байраар хангагдсан байна. Хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээнд 16, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 23 иргэн хамрагдсан. | |
| 29 | 2.1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад мөрдүүлнэ. | 2.1.3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээ, дэд бүтэц, барилга байгууламжийн стандартыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад мөрдүүлэх | 2025-2028 | Улсын болон Орон нутгийн төсөв | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартын хэрэгжилтийн хувь /өссөн дүнгээр/ | 25% | 26% | Батлагдсан төсвийн хүрээнд | | ХЗА ГХБХБГ | БОНХОБТХ НБХ ААНБ-ууд | "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол", “Хүлэг зах-Авто вокзал-Говил” гэсэн чиглэлүүдэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан 40-45 хүний багтаамжтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн, шат болон тэргэнцэр орох зориулалтын буулгадаг хавтантай дунд оврын 15 ширхэг автобус нийтийн тээврийн үйлчилгээг хүргэж байна.<br>Төрийн бүх шатны 92 объектын 120 байгууллагыг хамруулан Монгол улсын MNS 2055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлага”, MNS: 6808:2019 “Явган хүний зам талбайн төлөвлөлт, техникийн шаардлага” зэрэг стандартыг танилцуулж байгууллагад хэрэгжсэн байх 5 үндсэн үзүүлэлт болох автомашины зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, налуу зам, гадна, дотор хаалганы өргөн, босгоны өндөр, хаалга хоорондын зай, угтах үйлчилгээний лангуу, мэдээллийн самбар, чиглүүлэгч, тэмдэг тэмдэглэгээ, ариун цэврийн өрөө тоноглол, хурал олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах заалны стандарт, зохион байгуулалт, дохиоллын систем зэргийн стандартыг газар дээр нь хэмжилт хийн танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэн хэрэгжүүлж ажиллахыг үүрэг чиглэл болгосон. Зам талбай, гэрлэн дохионы уулзвар, гарцад хүртээмжийн үнэлгээг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны Орхон салбартай хамтран гүйцэтгэснээр дундаж үнэлгээ 48 хувьтай үнэлэгдсэн. Мөн НҮБ-ын дэмжлэгтэйгээр ХБХЭЭХ-ноос хүртээмжийн үнэлгээг төлөөллийн 6 байгууллагад хийхэд | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хэрэгжилт 43.6 хувь үнэлэгдсэн. | |
| 30 | | 2.1.3.2.2. Төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэхэд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | - | Бэлтгэгдэн ажиллаж буй дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн тоо /өссөн дүнгээр/ | 18 | 23 | Батлагдсан төсвийн хүрээнд | | ГХБХБГ | Төрийн байгууллагууд МХС ТӨХК ШУТП | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг төрийн байгууллагууд болон эрүүл мэндийн салбарын байгууллагуудын албан хаагчдыг хамруулсан дохионы хэлний анхан болон дунд шатны 3 удаагийн сургалтыг хийж 57 хүнийг хамруулсан. Дохионы хэлний мэргэжлийн 2 багшийг сургалт, хэлэлцүүлэгт дохионы хэлний орчуулагчаар ажиллуулж байна. Хараагүйчүүдийн үндэсний холбооны Орхон салбартай хамтран “Брайл цонх” төсөл хэрэгжүүлж, брайл үсгийн анхан шатны 14 хоногийн сургалтыг зохион байгуулж харааны бэрхшээлтэй иргэд, Орхон аймгийн боловсрол, эрүүл мэнд, хүчний байгууллагуудын 70 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 31 | | 2.1.3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 1402.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах<br><br>Хамрагдсан иргэд /өссөн дүнгээр/<br><br>Гэрээ байгуулсан ТББ /Тухайн жилээр/ | -<br><br>500<br><br>7 ТББ | -<br><br>550<br><br>7 ТББ | 337.5 | ОНТ-342.5 | НБХ | Төрийн байгууллагууд | 2024 онд 8.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн зураг, төсвийг "ЭМ ЭМ ЭЛ" ХХК-иар гүйцэтгүүлж Барилгын хөгжлийн төвд 2024 оны 07 дугээр сарын 26-ны өдрийн 1272/2024 дугаар магадлалын дүгнэлт гаргуулсан. Барилга барих газрыг Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/36 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Улсын төсөвт тусгуулахаар 2025, 2026 оны төсөвт санал өгсөн хэдий ч хасагдсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуусыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр ажиллаж байгаа ХБХЭЭХ-ны Орхон салбар "Гэрэл" залуучуудын төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын "Найдвар" төв, аутизм, хэл заслын "Пондолдой" төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах "Сорхугтани" төв, “Хүмүүн бие даан амьдрах” төв, Хараагүйчүүдийн үндэсний холбооны Орхон аймгийн салбар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт сургалтын төв” зэрэг нийт 7 ТББ-д орон нутгийн төсвөөс 342.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажиллаж байна. Эдгээр ТББ-уудаас ХБХЭЭХ-ны Орхон салбар "Гэрэл" залуучуудын төв Германы элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр мах махан бүтээгдэхүүн боловсруулах төсөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй “Хамтын оролцоотой орон нутагт-хүртээмжийг үнэлэх нь” төсөл, Хүмүүн бие даан амьдрах төв “Хувийн туслах үйлчилгээ” төсөл, “Хараагүйчүүдийн холбоо “ Брайл үсэг” төслийг тус тус хэрэгжүүлсэн. Гэрээлэн ажиллаж буй 7 ТББ-ууд эцэг эх, асран хамгаалагчдын сургалт, брайл үсгийн сургалт, хуулийн мэдлэг олгох зэрэг сургалт, өдөрлөг уулзалт хэлэлцүүлэг зэрэг 15 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | байгуулж нийт 600 гаруй хүн хамрагдсан. Аймгийн ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, ЭМГ, БТСГ, БГ зэрэг төрийн байгууллагууд хамтран тэгш эрхийн сургалт, асран хамгаалагчдын сургалт, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, дохионы хэлний 3 удаагийн сургалт, багш нарыг чадавхжуулах зэрэг нийт 20 гаруй удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж явуулж 800 гаруй хүнийг хамруулсан. | |
| **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж** | | | | | | | | | | | | | | |
| 2.2.Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин буурна. | | | | | | | | | | | | | | |
| *2.2.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавх дээшилж, тогтвортой, өрсөлдөх чадвартай ажлын байрны хүрээ өргөжсөн байна.* | | | | | | | | | | | | | | |
| 32 | 2.2.1.1. Бүтээмж, технологид суурилсан 400-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгож, нийт 2500-аас доошгүй хүнийг ажлын байранд зуучилна. | 2.2.1.1.1. Бүтээмж, технологид суурилсан 400-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгож хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн чадамж бүхий ажиллах хүчийг ажлын байраар хангах. | 2025-2028 | Улсын төсөв | 19600.0 | Шинээр бий болсон ажлын байр /тухайн жилээр/ | 575 | 590 | 4900.0 | - | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ Статистик ийн хэлтэс ААНБ-ууд | Тайлант хугацаанд 1052 шинэ ажлын байр бий болсны 4.4 хувь нь ХАА, 3.1 хувь нь уул уурхай, 13.3 хувь нь барилга, 1.6 хувь нь боловсруулах, 11.4 хувь нь эрүүл мэнд боловсрол, 6.3 хувь үйлчилгээний салбар, 4.5 хувь нь төрийн байгууллагуудад бий болсон байна. Уул уурхай, боловсруулах салбарт тоног төхөөрөмжийн болон дамжлагын чиглэлээр 29 ажлын байранд шинэ техник, технологи нэвтрүүлсэн ажлын байр бий болсон байна. | 100% |
| 33 | | 2.2.1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил олгогчийн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг ажилд зуучлах. | 2025-2028 | Улсын төсөв | 12.0 | Зуучлагдсан ажлын байр /тухайн жилээр/ | 700 | 625 | 3.0 | - | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ ААНБ-ууд | Тайлант хугацаанд Ejob хөдөлмөр эрхлэлтийн цахим нэгдсэн платформоор дамжуулан 369 иргэнийг ажил хайгчаар, 280 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийг бүртгэлжүүлж, нийт 1927 ажлын байрны захиалга бүртгэж, 1115 иргэнийг ажилд зуучилсан. | 100% |
| 34 | 2.2.1.2.Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 200-аас доошгүй гараан бизнесийг дэмжин хөгжүүлж, тогтвортой хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ. | 2.2.1.2.1. Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гараан бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох үйл ажиллагаа зохион байгуулах. | 2025-2028 | Улсын төсөв | 2735.0 | Шинээр бий болсон гараан бизнес /өссөн дүнгээр/ | 73 | 75 | УТ-879.0 | УТ-879.0 ХЭДС-7.6 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ ХХААГ ШУТП | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа<br>○ Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 21 иргэнд 197.0 сая төгрөг,<br>○ Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 40 иргэнд 400.0 сая төгрөг,<br>○ Залуучуудын "Старт-Апп" аймаг, бүсийн шилдэг гараан бизнесийн дэмжих санхүүгийн дэмжлэгт 5 багт 82.0 сая төгрөг,<br>○ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 20 иргэнд 200.0 сая төгрөг, | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | нийт 86 иргэнд 879.0 сая төгрөгийн 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгосон. Үүний үр дүнд 86 ажлын байр бий болсон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 130, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнийг эрх бүхий сургалтын төвтэй хамтран төсөл бичих, бизнесээ хөгжүүлэх сургалтад хамруулж ХЭДСангаас 7.6 сая төгрөг зарцуулсан. | |
| 35 | 2.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, чадамжид суурилсан ажиллах хүчийг бэлтгэж, олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, бүтээлч санаачилга, хандлага, ур чадварыг хөгжүүлнэ. | 2.2.1.3.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн суурь ур чадвар, мэргэжлийн ур чадварыг иргэнд богино хугацаанд олгох, давтан сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах. | 2025-2028 | Улсын төсөв | 101.0 | Мэргэжлийн сургалтад хамрагдсан хүний тоо | 95 | 98 | 23.5 | ХЭДС-32.2 ОНТ-8.0 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ Мэргэжлийн сургалтын байгууллагууд | Орхон Политехникийн коллежтой хамтран танхимын мэргэжил олгох сургалтыг 5 мэргэжлээр зохион байгуулан 48 иргэнийг хамруулж 26.2 сая төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан. Чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг “Уран гар” сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургалтад хамруулж сургалтын зардалд нийт 6.0 төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан.<br>Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор цахим ур чадварын сургалтыг бүртгэл тооцоо хөтлөл, гар урлалын мэргэжлээр сургалтын байгууллагатай хамтран явуулж 30 эмэгтэйг хамруулан чадамжийн гэрчилгээ олгож сургалтын зардалд орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулсан. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан ур чадварын цахим сургалтад 13 мэргэжлээр нийт 38 иргэн цахимаар хамрагдсан.<br>Мэргэжил олгох танхимын болон цахим ур чадварын сургалтад нийтдээ, 125 иргэн хамрагдаж 33.8 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 36 | 2.2.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Хөдөлмөр зуучлалын төв”-ийг шинээр байгуулан ажиллуулж, зорилтот бүлгийн ажилгүй иргэд, оюутан, залуучууд, ахмадуудыг түр болон цагийн ажлын байранд холбон зуучлах ажлыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар зохион | 2.2.1.4.1. Оюутан болон цагийн ажлын байрны мэдээллийг их, дээд сургууль, коллежийн оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдэд хүргүүлж холбогдох мэдээллээр хангах. | 2025-2028 | Улсын төсөв | - | Түр болон цагийн ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/ | 300 | 310 | - | - | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ Политехник коллеж | Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 3 Самушил төв шинээр байгуулагдан, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Тус төвүүд нь түр болон цагийн ажлын байранд зуучлах, анкет бүртгэх, ажлын байрны захиалга хүлээн авах зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэж байна.<br>○ "Эрдэнэт Самушил" нь Оюут багт байршиж, 2025 оны 4 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулж нийт 125 иргэний анкет хүлээн авч бүртгэн, 118 гаруй иргэнийг түр болон цагийн ажилд зуучилсан.<br>○ “Samushil HR” Эрдэнэт салбар нь Булаг багт байршин 2025 оны 5 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж 150 гаруй иргэний анкет бүртгэж, 110 иргэнийг түр ажилд зуучилсан. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | | | | | | | | | | ○ "Эрдэнэт сайхан уул самушил" нь Шанд багт байршин 2025 оны 5 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж 110 гаруй иргэний анкет хүлээн авч, 98 иргэнийг түр болон цагийн ажилд зуучилсан.<br>Эдгээр төвүүдээр тайлант хугацаанд 385 иргэний анкет бүртгэгдэж, 326 иргэнийг түр болон цагийн ажлын байранд зуучилсан. Ажилд орсон иргэдийн ажлын байрыг салбараар нь авч үзвэл барилгын салбар 85 хувь, газар тариалангийн салбар 18 хувь, бусад салбарууд 15 хувийг эзэлж байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын хөлс нь дунджаар 100.0-120.0 мянган төгрөг бөгөөд зуучлалын хөлсөнд 10 хувийг авч байна. Аймгийн ХХҮГ-аас эдгээр газруудтай хамтран бүртгэл мэдээлэлд хамруулах, хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангах зэрэгт үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр хамтран ажиллаж байна. | |
| 37 | | 2.2.1.4.2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв /Job center/ -ийг шинээр байгуулж, хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийж ажил олгогчдод зориулсан сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, иргэдийг ажилд зуучилж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | - | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийг шинээр байгуулах<br><br>Хөдөлмөр зуучлалын төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо | -<br><br>- | -<br><br>500 | -<br><br>- | - | НБХ ХХҮГ | Сумдын ЗДТГ ААНБ-ууд | Монголын хүний нөөцийн менежментийн холбооны дэргэдэх хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран аймгийн захиргааны 4 дүгээр байранд JOB CENTER төвийг 2025 оны 05 дугаар сарын 05-нд нээж, 09 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус төвөөр дамжуулан ганцаарчилсан зөвлөгөө 65 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 9,11 дүгээр ангийн 70 сурагчдад өгсөн. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 45 иргэнийг хамруулж, хувийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлсэн. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Онто гранд ХХК, Өргөө кино театр, Presting Beauty гоо сайхны дэлгүүр, Тод Өнгө ХХК зэрэг 20 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 23 ажлын байрны захиалгын дагуу мэдээллийг "Ажил зуучлал" нэртэй facebook хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж, захиалгын дагуу 25 иргэнийг ажил олгогчийн ярилцлагад зуучилж, 12 иргэнийг байнгын болон түр ажлын байранд дадлагажуулан ажиллуулж байна. Тус төвөөр нийт 225 иргэн үйлчилгээ авсан. | 100%<br><br>45%<br><br>Дундаж 72.5% |
| 38 | 2.2.1.5. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт тогтолцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн | 2.2.1.5.1. Нийгмийн түншлэгч талууд хамтран хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 80.0 | Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо<br><br>Хөдөлмөрийн харилцааны хууль, тогтоомжийн | 400<br><br>78% | 500<br><br>80% | 20.0 | ОНТ-20.0 | ХХҮГ | ХШҮХ Нийгмийн түншлэлийн 3 талт хороо | Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо төрийн байгууллагаас бүрдсэн нийгмийн түншлэлийн зөвлөл, хороод болох Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж ажиллан, тайлант онд тус зөвлөлийн үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооноос 9 үйл ажиллагаа | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулна. | байгуулж, хуулийн хэрэгжилтэд хамтарсан хяналтыг тавьж ажиллах. | | | | хэрэгжилт.хувь /тухайн жилээр/ | | | | | | | төлөвлөж, 3 төрлийн сургалт зохион байгуулан аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулиар зөвлөмж хүргүүлж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс 5 төрлийн сургалт зохион 195 ажилтан, албан хаагч, 30 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 10 төрлийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 800 хүн, цахим мэдээллийн сувгаар 50 мянга орчим үзэгчдэд мэдээлэл хүргэсэн. Хөдөлмөрийн харилцааны хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хуулийн үзлэг шалгалтыг 2026 онд зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйл болон эдгээртэй нийцүүлэн баталсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 13 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан шалгаж үнэлэхэд дунджаар 87.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| 39 | 2.2.1.6. Зорилтот бүлгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүн төвтэй, үр ашигтай, хүртээмжтэй хүргэнэ. | 2.2.1.6.1. Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо /тухайн жилээр/ | 42500 | 42500 | - | УТ-20100.0 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ | 2025 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд 79.3 мянган иргэн хамрагдаж 67.3 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Нийгмийн халамжийн үечилгээ e-halamj цахим системд 100 хувь шилжиж, үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэж, тайлант хугацаанд гомдол санал гаргалгүй ажилласан. | 100% |
| 40 | | 2.2.1.6.2. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо | 360 | 360 | - | ОНТ-165.1 | ХХҮГ | НБХ Сумдын ЗДТГ | Орон нутгийн төсвөөс 192.5 сая төгрөг батлагдсан. Үүнээс 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны болон гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрх, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон 14, хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй 3, нийт 17 иргэнд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 20.4 сая төгрөг олгосон.<br>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд "Аминчхан яриа" ТББ, Улаан загалмай хороотой хамтран нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах, өдрийн үйлчилгээ зэрэгт 126 иргэнийг хамруулж 50.6 сая төгрөг зарцуулсан.Гэр оронгүй тэнэмэл иргэдийг түр байрлуулах үйлчилгээг 2024, 2025 оны өвлийн улирал зохион байгуулж, давхардсан тоогоор 60 иргэнийг хамруулж 98.5 сая төгрөг зарцуулсан. Ахмадын цогц тусламж, үйлчилгээг Баян-Өндөр сумын "Ахмадын хороо" НҮТББ 568 ахмад настанд 41.6 сая төгрөгийн, Жаргалант сумын "Улаантолгой ахмадын хороо" НҮТББ 200 ахмад настанд 15.0 сая төгрөгийн "Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ"-г үзүүлэн халамжийн сангаас нийт 56.6 сая төгрөгийг олгосон.Онцгой тохиолдлын болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийтдээ 971 иргэн хамрагдаж 225.1 сая төгрөг зарцуулсан. | |
| **Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг** | | | | | | | | | | | | | | |
| 2.3.Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн байна. | | | | | | | | | | | | | | |
| *2.3.1.Нэг хүнд ноогдох спортын заалны талбайн хэмжээ нэмэгдэнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 41 | 2.3.1.1. “Эрдэнэт спорт цогцолбор”-ыг шинээр ашиглалтад оруулан, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг иргэдэд сурталчилж идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлнэ. | 2.3.1.1.1. “Эрдэнэт спорт цогцолбор” болон ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг ашиглалтад оруулж, спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 33500.0 | Барилгын ажлын гүйцэтгэл.хувь<br><br>Шинээр баригдах спорт заалны тоо | - | Зураг, төсөв батлагдсан байна.<br><br>- | 750.0 | | БОНХОБТХ НБХ | БТСГ | Тайлант онд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Эрдэнэт спортын цогцолбор"-ын зураг, төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Зэд прожект" ХХК-иар гүйцэтгүүлж дуусгасан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 11/05 тогтоолоор батлагдсан "Эрдэнэт цэнгэлдэх хүрээлэнгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн баруун талд "Эрдэнэт /arena /спорт цогцолбор "-ыг барьж байгуулахаар төлөвлөөд байна.<br>Мөн Уран эгшиг дунд сургуулийн спорт заал 1, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1 спорт заалыг ашиглалтад оруулж, аймгийн хэмжээнд 1 хүнд ногдох спорт заалны талбайн хэмжээг 0.01м2-аар нэмэгдүүлж, 0.168м2-д хүргэсэн. Аймгийн хэмжээнд спортын 38 зааланд иргэд бие бялдраа чийрэгжүүлэн биеийн тамир, спортоор хичээллэж байна. Мөн 2025 онд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4 спортын заал шинээр баригдаж байна. | 100% |
| 42 | | 2.3.1.1.2. “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-гийн зам талбайг стандартын дагуу шинэчлэн засварлах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Зам талбайн засварын ажлын гүйцэтгэл. хувь | Стандартын бус зам талбай | - | - | | БОНХОБТХ НБХ | БТСГ | 2026 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Тус хүрээлэнд хөнгөн атлетикийн дартаман замын зураг, төсөв хийлгэхээр ХББЗА-д саналаа хүргүүлсэн. Эрдэнэт хотын 50 жилийн ойн хүрээнд 2026 онд Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд их засварыг хэсэгчилсэн байдлаар хийхээр ХББЗА | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зураг, төсөв боловсруулж байна. | |
| 43 | | 2.3.1.1.3. “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 98.4 | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн хувь /3-79 насны хүн амаас тооцсон/ | 24.6% | 25.5% | 23.4 | УТ-12.2<br>ОНТ-23.4 | БТСГ | НБХ | “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны хүрээнд биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортын өдөрлөг, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир чийрэгжүүлэлтийн арга хэмжээг 78 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 49644 иргэнийг хамруулсан. Энэ нь 3-79 насны хүн амын 49.7 хувийг эзэлж байна. Биеийн тамирын чийрэгжүүлэлтийн арга хэмжээнд улсын төсвийн 12.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 23.4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. | 100% |
| 44 | 2.3.1.2. Спортын авьяасыг нээн илрүүлэх, мэргэжлийн болон үндэсний спортоор хичээллэгчдийн оролцоо, амжилтыг нэмэгдүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэн, шинэ тутамд хөгжиж байгаа цахим, хотын (урбан) спортын төрлүүдийг хөгжүүлнэ. | 2.3.1.2.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багт гэрээт дасгалжуулагч ажиллуулж, тамирчдын амжилтыг ахиулан, хэрэглэл материалаар хангах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 404.8 | Гэрээт дасгалжуу лагчдын тоо /өссөн дүнгээр/<br><br>Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүртсэн медалийн тоо | -<br><br>300 | 1<br><br>330 | 77.2<br><br>- | ОНТ-266.2 | БТСГ | НБХ | Өсвөрийн шигшээ 16 багийн 2 төрөлд /хүндийн өргөлт, хөнгөн атлетик/ 2 гэрээт дасгалжуулагчдыг ажиллуулж эхэлсэн. Нийт 280.6 сая төгрөг батлагдсанаас:<br>○ Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд оролцох зардалд 167.5 сая төгрөг;<br>○ Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд оролцох зардалд 35.9 сая төгрөг;<br>○ Өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулах гэрээт дасгалжуулагчдын зардалд 77.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан ба үлдэгдэл 14.4 сая төгрөгийг хүндийн өргөлт, хөнгөн атлетикийн төрлүүдэд дасгалжуулагчаар ажиллаж байгаа 2 гэрээт дасгалжуулагчийн урамшууллыг олгосон.<br>2025 оны байдлаар аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ 16 багт 196 өсвөрийн тамирчид бэлтгэл сургуулилалт хийж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 28 төрлөөр оролцож, 332 медаль авсан амжилтыг үзүүлсэн байна. | 100% |
| 45 | | 2.3.1.2.2. Мэргэжлийн болон үндэсний спортын төрлийг хөгжүүлж, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 1280.0 | Зохион байгуулсан тэмцээний тоо /тухайн жилд/ | 4 | 4 | - | УТ-20.0<br>ОНТ 268.8 | БТСГ | НБХ | 2025 онд Орхон аймагт улс, бүсийн болон олон хотын аварга шалгаруулах тэмцээн 15, үндэсний спортын 5 төрлөөр 51 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, 8965 тамирчдыг хамруулсан байна. Улс, бүсийн чанартай томоохон тэмцээн уралдаанд улс, орон нутгийн төсвөөс 88.8 сая төгрөгийн дэмжлэг, мэргэжлийн спортын сагсан бөмбөгийн дээд лигийн “Эрдэнэт майнерс” багт орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэгийг үзүүлж ажилласан. | 100% |
| 46 | | 2.3.1.2.3. Цахим болон хотын (урбан) | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 26.0 | Зохион байгуулсан тэмцээний | 1 | 2 | 5.0 | ОНТ 18.0 | БТСГ | НБХ<br>Сумдын ЗДТГ | Тайлант онд цахим спортын төрлөөр 3 удаа, хотын спортын төрлөөр 4 удаа тэмцээн зохион байгуулж 990 хүүхэд, | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | спортын төрлүүдийг шинээр хөгжүүлж, тэмцээн уралдаан зохион байгуулах. | | | | тоо /тухайн жилд/ | | | | | | залуучуудыг хамруулж, орон нутгийн төсвийн 18.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. | |
| 47 | 2.3.1.3. Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай материаллаг баазыг бэхжүүлж, мэргэжлийн багш, дасгалжуулагчийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн, “Эрдэнэт мөнгөн өвөл” аяныг жил бүр зохион байгуулж, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 2.3.1.3.1. Өвлийн спортын зам талбайг нэмэгдүүлж, “Эрдэнэт мөнгөн өвөл аян”-ыг жил бүр зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 320.0 | Зохион байгуулсан тэмцээний тоо /тухайн жилээр/ | 4 | 4 | 70.0 | ОНТ 35,0 | БТСГ | НБХ | 2025 онд аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж цанын зам 3, мөсөн талбай 3, нийт 6 зам талбай байгуулж, улсын аварга шалгаруулах болон нээлттэй тэмцээн уралдааныг 9 удаа зохион байгуулж, 849 тамирчдыг оролцуулж, хүүхэд, залуust өвлийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.<br>Өвлийн спортын зам талбайд 3 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, тэшүүр, цана, чарганы түрээсийн үйлчилгээ үзүүлж, 4200 гаруй иргэдэд үйлчлүүлсэн байна.<br>“Эрдэнэт мөнгөн өвөл” аяны хүрээнд мөсөн талбай байгуулах ажил хийгдэж байгаа бөгөөд аяны хүрээнд зохион байгуулагдах тэмцээн уралдаан 2026 оны эхний улиралд хийгдэнэ. | 100% |
| 48 | | 2.3.1.3.2. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэх гэрээт дасгалжуулагчийг ажиллуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 153.8 | Гэрээт дасгалжуулагчийн тоо /өссөн дүнгээр/ | - | - | - | | БТСГ | НБХ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтөөр тус арга хэмжээг 2026 оноос хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. | Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй. |
| **Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол** | | | | | | | | | | | | | |
| 2.4.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ. | | | | | | | | | | | | | |
| *2.4.1.Суралцах таатай орчин бүрдэж, багш хүүхдийн хөгжил хангагдана.* | | | | | | | | | | | | | |
| 49 | 2.4.1.1. “Хамгийн сайн сургууль, цэцэрлэг-Гэрт ойр сургууль, цэцэрлэг”, “Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги” үйл ажиллагааг хэрэгжүүлж, цэцэрлэг, сургуулийн бүлэг дүүргэлтийг багасгана. | 2.4.1.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх. | 2025-2028 | - | - | Анги дүүргэлтийн норм хангасан бүлгийн эзлэх жин | СӨБ 22.2%<br>ЕБС 45.5% | СӨБ 26.2%<br>ЕБС 46.5% | - | - | БГ | ЕБС СӨББ-ууд | 2025-2026 оны хичээлийн жилд нийт 38 хүүхдийн цэцэрлэгт 8591 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 27.9, төрийн өмчийн 31 хүүхдийн цэцэрлэгт 7933 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 28.9 байна. Төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэгүүдээс бүлэг дүүргэлт аймгийн дунджаас доогуур буюу 28.9-өөс доош бүлэг дүүргэлттэй цэцэрлэг 17 байгаа нь нийт төрийн өмчийн цэцэрлэгийн 54.8 хувийг эзэлж байна.<br>Ерөнхий боловсролын 24 сургуулийн 827 бүлэгт 27932 суралцагч суралцаж, бүлэг дүүргэлтийн дундаж 33.7, төрийн өмчийн 17 сургуулийн 697 бүлэгт 24906 суралцагч суралцаж, бүлэг дүүргэлтийн дундаж 35.7 байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудаас бүлэг дүүргэлтийн дундаж аймгийн дунджаас доогуур буюу 35.7-оос доош бүлэг дүүргэлттэй 11 сургууль байгаа нь нийт төрийн өмчийн сургуулийн 64.7 хувийг эзэлж байна.<br>Хамран сургах тойргийг шинээр тогтоосон, аймгийн хэмжээнд 2-5 насны хүүхдийн тоо буурсан зэргээс шалтгаалан хүүхдийн цэцэрлэгийн аймгийн дунджаас доогуур бүлэгтэй цэцэрлэгийн эзлэх хувь 3.2 хувиар өссөн. Хүүхдийн цэцэрлэгт суралцаж буй хүүхдийн тоо өмнөх оныхоос 316- | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | аар буурч, бүлгийн тоо 2 оор нэмэгдсэн. Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан аймгийн дунджаас доогуур бүлэг дүүргэлттэй сургуулийн элэх хувь 12.1 хувиар өссөн. | |
| 50 | | 2.4.1.1.2. Аймгийн хэмжээнд төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | - | - | Хамран сургалтын хувь | СӨБ 97.0%<br><br>ЕБС 99.4% | СӨБ 98.0%<br><br>ЕБС 99.6% | - | - | БГ | ЕБС СӨББ-ууд | Аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/120 тоот тушаалаар хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг шинэчлэн тогтоосон. 2025-2026 оны хичээлийн жилд нийт 38 хүүхдийн цэцэрлэгт 8591 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 27.9, төрийн өмчийн 31 хүүхдийн цэцэрлэгт 7933 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 28.9 байгаа ба хамран сургалт 98.9 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 827 бүлэгт 27932 суралцагч суралцаж хамран сургалт 99.6 хувь, ээлжийн коэффициент 1.6 байна. | 100% |
| 51 | 2.4.1.2. Боловсролын салбарын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, 7-оос доошгүй сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг шинээр ашиглалтад оруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2.4.1.2.1. Боловсролын салбарт 7-оос доошгүй сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг шинээр ашиглалтад оруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 39018.0 | Ашиглалтад орсон барилгын тоо /тухайн жилээр/ | 2 барилга | 1 | 19616.9 | УТ-14505.1 | БГ | БОНХОБТХ НБХ ГХБХБГ | 2025 оны улсын төсөвт 6 барилгын ажилд төсөв батлагдсан. Үүнд:<br>1. Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/-1458.2 сая төгрөг, гүйцэтгэл 40 хувь<br>2. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2а хороолол/-1414.6 сая төгрөг, гүйцэтгэл 30 хувь<br>3. Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 хороолол/-2764.2 сая төгрөг, гүйцэтгэл 30 хувь<br>4. Сургуулийн барилга буулгаж шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-өндөр сум, 3 дугаар сургууль/-8586.1 сая төгрөг, гүйцэтгэл 90 хувь<br>5. Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/-1354.6 сая төгрөг, гүйцэтгэл 40 хувь<br>6. Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/-1357.6 сая төгрөг, гүйцэтгэл 40 хувьтай байна.<br>Тайлант хугацаанд 8 дугаар сургуулийн 320 хүүхдийн суудалтай өргөтгөлийг ашиглалтад оруулж, Политехник коллежийн 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг хүлээн авсан. 3 дугаар сургуулийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгад 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр улсын комисс ажиллаж, 01 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад хүлээн авахаар төлөвлөж байна. Мөн орон нутгийн төсвийн 282.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 дугаар сургуулийн гал тогооны өргөтгөлийн барилга баригдаж ашиглалтад орсон байна. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | | 2.4.1.2.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгад шаардлагатай засвар, үйлчилгээг хийж сургалтын таатай орчин бүрдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 11607.1 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоо /тухайн жилээр/ | 15 байгууллага | 5 цэцэрлэг 6 сургууль | 2607.1 | ОНТ-18341.5 | БГ | БОНХОБТХ НБХ | 2025 онд боловсролын салбарын 12 байгууллагад орон нутгийн төсвийн 2859.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээ хийгдэхээр төлөвлөсөн. Үүнд:<br>1.24 дүгээр цэцэрлэгт хэсэгчилсэн засвар хийх-196.0 сая төгрөг<br>2.“Оюу” цэцэрлэгийн гадна цахилгааны ажил шинээр хийх-26.5 сая төгрөг<br>3. 9 дүгээр цэцэрлэгт засвар хийх-250.0 сая төгрөг<br>4. 1 дүгээр цэцэрлэгийн гадна талд дулаалгатай фасад хийх-450.0 сая төгрөг<br>5. Дэгдээхэй цэцэрлэгийн гадна талбайн тохижилт хийх-350.0 сая төгрөг<br>6. 21 дүгээр цэцэрлэгийн гадна инженерийн шугам сүлжээ шинэчлэх ажил-295.4 сая төгрөг<br>7. 14 дүгээр сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах-300.0 сая төгрөг<br>8. 7 дугаар сургуулийн спорт заалны шалыг засварлах-120.0 сая төгрөг<br>9. 5 дугаар сургуулийн хичээлийн байрны зүүн жигүүрийн халаалтын систем засварлах-284.0 сая төгрөг<br>10. 1 дүгээр сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны цахилгаан, сантехникийн их засвар хийх-300.0 сая төгрөг<br>11. 18 дугаар сургуулийн дээвэр засварлах-131.9 сая төгрөг<br>12. 20 дугаар сургуульд гадна, дотно камержуулалт хийх-155.3 сая төгрөг<br>Дээрх ажлуудаас 1 дүгээр цэцэрлэгийн гадна фасад засварлах, 5 дугаар сургуулийн зүүн жигүүрийн халаалтын систем засварлах ажлуудын тендер амжилтгүй болсон. Бусад ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан . Мөн “Болзошгүй аваарын зардал”-аар давхардсан тоогоор 61 сургалтын байгууллагад сантехникийн шугам, дээвэр, цонх, хаяавчны засварын ажлыг 15482.4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. | 100% |
| 53 | | 2.4.1.2.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангаж, интернэтийн дэд бүтцийг сайжруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 1852.9 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоо /тухайн жилээр/ | 17 сургууль 31 цэцэрлэг | 17 байгууллага | 352.9 | ОНТ-602.9 | БГ | БОНХОБТХ НБХ | 2025 онд орон нутгийн төсвийн 602.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 27 (давхардсан тоогоор) ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангасан. Үүнд:<br>1. Ерөнхий боловсролын сургуулиудад шинээр байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тоног төхөөрөмж худалдан авах-100.0 сая төгрөг<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах -232.9 сая төгрөг<br>3. Ерөнхий боловсролын 6-11 дүгээр | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | ангиудад 1000 ном төсөл уншлагын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай худалдан авалт хийх-250.0 сая төгрөг<br>13 дугаар сургуулийн Монгол хэлний кабинетад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах-20.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 54 | 2.4.1.3. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшлийг сайжруулж, эрх хамгаалал, аюулгүй байдлыг хангах, эх хэл, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сургуулийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 2.4.1.3.1. Сургалтын байгууллагын менежментийг сайжруулж, байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээг дээшлүүлэх. | 2025-2028 | - | - | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь | ЕБС 75.8%<br>СӨББ 87.8% | ЕБС 76.0%<br>СӨББ 88.0% | - | - | БГ | ЕБ<br>СӨББ | Сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран аймгийн хэмжээнд 2025 оны 4, 5 дугаар сард зохион байгуулж, төрийн өмчийн 31 цэцэрлэг, 17 сургууль хамрагдсан. Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн үнэлгээний дундаж 92.29 хувь байгаа нь улсын дунджаас 0.2 хувиар бага боловч өмнөх хичээлийн жилийн үнэлгээнээс 4.49 хувиар, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын дундаж 83.91 хувь байгаа нь улсын дунджаас 3 хувиар, өмнөх хичээлийн жилээс 8.11 хувиар тус тус өссөн байна. | 100% |
| 55 | | 2.4.1.3.2. Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, сурагчдын дугуйлан, секцэд хамрагдалтыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 70.0 | Төсөл арга хэмжээний тоо<br><br>Дугуйлан секцэд хамрагдалтын хувь | Төсөл арга хэмжээний тоо 1<br><br>Дугуйлан секцэд хамрагдалт 30.6% | Төсөл арга хэмжээний тоо 1<br><br>Дугуйлан секцэд хамрагдалт 32.6% | 10.0 | ОНТ-232.9 | БГ | НБХ<br>ЕБС<br>СӨББ-ууд | Тайлант хугацаанд төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 24 сургуулийн 9770 суралцагч буюу нийт суралцагчийн 34.9 хувь нь сургуулиуд дээр явагдаж буй 62 төрлийн 374 дугуйлан, секцэд хамрагдаж байгаа бол сургуулиас гадуурх дугуйлан, секцэд 2670 сурагч буюу буюу нийт сурагчдын 9.5 хувь нь хамрагдаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд нийт 12440 сурагч буюу нийт сурагчдын 44.5 хувь нь дугуйлан, секцэд хамрагдаж, авьяас, чадвараа хөгжүүлж байгаа ба энэ нь өмнөх оноос 13.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2025 оны орон нутгийн төсөвт “Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээг тусган орон нутгийн төсвийн 232.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн 1,3,5,8,16,18, “Ирээдүйн одод” сургуулиудад сургуулиудад бөхийн төрлийн спортуудын дэвжээ, татам зэрэг хэрэглэлүүдийг олгож, бөхийн секц хичээллүүлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 6-11 дүгээр ангийн сурагчдыг ном унших арга зүйг дэмжих “Оксфордын 1000 ном уншлагын хөтөлбөр”-ийг “Нэпко кидс” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн байна. | 100% |
| 56 | | 2.4.1.3.3. Сурагчдад эх оронч үзэл төлөвшүүлж, амьдрах ухаанд суралцуулах арга хэмжээг | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 130.0 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан сурагчдын тоо | - | 1500 | 10.0 | - | БГ | НБХ<br>Цэргийн штаб | Тайлант хугацаанд сурагчдад эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр “Түүхэн тэмдэглэлт өдөр” агуулгын хүрээнд хичээл сургалтын үйл ажиллагаатай холбож дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:<br>1. 1945 оны чөлөөлөх дайны ялалтын | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах. | | | | /Тухайн жилээр/ | | | | | | | түүхэн ач холбогдлыг таниулах сурталчлах зорилгоор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Боловсролын газраас чөлөөнд гарсан цэргийн бэлтгэл үүрэгтэн офицеруудтай хамтран “Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ой” хичээлийг ерөнхий 11 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 1620 сурагчийг хамруулллаа. Мөн тус ойн хүрээнд Батлан Хамгаалах яам болон Боловсролын Ерөнхий газраас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу “Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ой”-д зориулсан хичээлийг аймгийн түүх, нийгмийн ухааны багш нар 6-12 дугаар ангийн 12669 сурагчдад заасан байна. Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдын дунд “Чөлөөлөх дайны ялалтын ач холбогдол” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулж сургуулиудад хичээллэж буй мэтгэлцээний клубуудын 500 гаруй сурагчид оролцсон.<br>2. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийн хүрээнд “Цагаатгал” лекц, хичээлийг дунд, ахлах ангийн 3687 сурагчийг хамруулан зохион байгуулж улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор, хөнөөлийг таниулсан байна. | |
| 57 | | 2.4.1.3.4. Ерөнхий боловсролын сургуулийн нийгэм, сэтгэл зүйн албаны үйл ажиллагааг сайжруулах, чадавхжуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан эрсдэлт нөхцөлд байгаа сурагчдын эзлэх хувь /нийт сурагчдаас/ | 19.6% (2023) | 18.6% | 5.0 | - | БГ | НБХ ЕБС-иуд | Ерөнхий боловсролын сургуулиудын “Нийгэм сэтгэлзүйн алба”-ны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газартай хамтран “Гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалал”, “Хамтарсан багийн гишүүдийн үүрэг” сэдвүүдээр зохион байгуулж, нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйч, тусгай хэрэгцээт боловсролын багш зэрэг нийт 50 ажилтан, Орхон болон Дархан-Уул аймгийн сэтгэл зүйч нарыг чадавхжуулах “Өсвөрийн үеийнхний оролцоонд тулгуурлан сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”-ийг “Гүүд Нейборс” ОУБ-тай хамтран хэрэгжүүлж, 21 сэтгэл зүйчийг тус тус хамруулж гэрчилгээ олгосон. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын сувилалтай хамтран “Ажлын байран дахь сэтгэцийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгоё” сэтгэлзүйн тест оношилгооны сургалт, МУБИС-тай хамтран “Анги удирдсан багш нараар дамжуулан хүүхдийг төлөвшүүлэх” арга зүй болон хүүхдийн хөгжлийг дэмжсэн төсөл боловсруулах арга зүйн сургалтад 65 багш, ажилтныг хамруулсан байна. Сургуулиудын “Нийгэм сэтгэлзүйн алба”-наас жил бүр 4 чиглэл 38 асуулгаар эрсдэлийн судалгаа авдаг бөгөөд тайлант хугацаанд авсан судалгаагаар бага эрсдэлтэй хүүхэд 16394, дунд | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | эрсдэлтэй хүүхэд 2350, өндөр эрсдэлтэй 51 хүүхэд тус тус бүртгэгдсэн ба тус албаар үйлчлүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа сурагчдын нийт сурагчдад эзлэх хувь өмнөх оноос 7.2 пунктээр буурч 12.4 хувь болсон байна. | |
| 58 | | 2.4.1.3.5. Сургуулийн орчинд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж, үе тэнгийн дээрэлхэлт болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 сая | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны тоо | 2 сургалт нөлөөллийн арга хэмжээ | 2 | - | - | БГ | НБХ<br>ЦГ<br>ХГБХХГ<br>ЕБС-иуд | Сургалтын орчинд электрон болон утаат тамхи хэрэглэхийг хориглосон Боловсролын сайдын 2025 оны А/140 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хүн бүр хүүхэд хамгаалагч” уриатайгаар эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн “Утаат тамхины хор хөнөөл”, “Та хүүхдээ ажиглаарай” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 8616 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Аймгийн Цагдаагийн газрын алба хаагчидтай хамтран ахлах ангийн 2100 хүүхдэд сургуулийн орчинд үйлдэгддэг болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, 2100 сурагчийг хамруулсан байна. Мөн 2025 онд ерөнхий боловсролын сургуулиуд “Дээрэлхэж биш, дэмжиж нөхөрлөе” мэдээллийн самбарыг ажиллуулж хэвшсэн. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Боловсролын газраас “Гэр айлчлал” арга хэмжээг 2 дахь жилдээ зохион байгуулсан ба сургуулиудын “Хүүхэд хамгааллын баг”-ууд хагас, бүтэн өнчин, дотуур байранд амьдардаг, айлд амьдардаг, эрсдэлт бүлгийн 1192 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлж, 83 кейс илрүүлж 53 кейс дээр ажиллаж 63.8 хувийг шийдвэрлэсэн байна. | 100% |
| 59 | 2.4.1.4. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сургалтын чанарыг дээшлүүлж Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээнд хамруулж, боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэнэ. | 2.4.1.4.1. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж өмчийн бүх хэлбэрийн ЕБС, цэцэрлэгийн сургалтын чанарыг дээшлүүлэх. | 2025-2028 | - | - | 9-р ангийн сурагчдын унших чадвар, Математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж хувь<br><br>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний гүйцэтгэлийн хувь | Унших чадвар 41.1% Математик 33.7%<br><br>70.2% | Унших чадвар 52.0% Математик 35.0%<br><br>71.0% | - | - | БГ | ЕБС-иуд<br>СӨББ-ууд | Боловсролын сайдын 2025 оны “Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх, бэлтгэл хангах тухай” А/60 тоот тушаалын дагуу бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн сургалтад бага боловсролын сургалтын менежер 18, 1 дүгээр ангийн 71, 5 дугаар ангийн 66, нийт 155 багш, ажилтныг хамруулж, аймгийн хэмжээнд сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг нэвтрүүлэх бэлтгэлийг хангаж байна. Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн сургалтад хамрагдвал зохих хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтнуудыг бүрэн хамруулж, хөтөлбөрийн шинэчлэлийг 2025-2026 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхлээд байна. Тайлант хугацаанд 9 дүгээр ангийн сурагчдын унших чадвар, математикийн хичээлийн гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээ болон СӨБ-ын сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулаагүй | 0 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | байна. | |
| 60 | | 2.4.1.4.2. Элсэлтийн ерөнхий шалгалтын чанарыг ахиулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 95.0 | ЭЕШ-ын аймгийн дундаж оноо | 539.7 /сүүлийн 5 жилийн дундаж/ | 542.0 | 20.0 | ОНТ-5.0 | БГ | ЕБС-иуд | Аймгийн хэмжээнд ЭЕШ-ын чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2 удаагийн урьдчилсан сорилыг зохион байгуулж, “Хүн амын бүлэг, Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-өөс 5.0 сая төгрөг зарцуулсан. 2024-2025 хичээлийн жилд 12 дугаар ангийг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 22 сургуулийн 56 бүлгийн 1591 хүүхэд төгссөн бөгөөд нийт төгсөгчдийн 97.1 хувь нь элсэлтийн шалгалтад бүртгүүлж оролцсон. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахууны аймгийн дундаж 516.85 байгаа нь улсын дунджаас 16.4 пунктээр өндөр үзүүлэлт бөгөөд улсын хэмжээнд 4 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахуунаас 5 судлагдахуунаар 15 сурагч 800 оноо авч, 2 сурагч Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдсан байна. | 0<br>*(516.85-539.7/542-539.7)*100=(-22.9/2.3)*100=-993.5* |
| 61 | | 2.4.1.4.3. Багш, ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 60.0 | Тухайн жилд хамрагдвал зохих багш нарын хамрагдалтын хувь | 100% | 100% | 15.0 | ОНТ-150.0 | БГ | ЕБС СӨББ-ууд | Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3, 5 дугаар сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих “Хүүхдийн хөгжлийн танхим”-ыг байгуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд 11 сургуулийн “Хүүхдийн хөгжлийн танхим”-д 260 гаруй хүүхэд 220 багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна. Аймгийн “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-өөс бага ангийн багш болон цэцэрлэгийн багш нарт зориулсан “Портеж” хөтөлбөрийн судалгаа, үнэлгээ хийх аргачлал сургалтыг 170 багш, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний журам”, “Брайл бичиг” дадлага сургалт, “Портеж хөтөлбөрийн арга зүй” сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, бага ангийн багш, тусгай хэрэгцээт боловсролын 220 багш, ажилтан, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Хөдөлмөр засал”, “Сонсоё, хайрлаая, хүндэлье” өртөөчилсөн хэл, хөдөлгөөн заслын сургалтыг 160 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан тус тус зохион байгуулсан. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг багш нарын дунд “Сайн туршлага-2025” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахад нийт 71 багш оролцлоо. Мөн Улаанбаатар хотын 70 дугаар сургуулийн багш нар манай аймгийн биеийн тамирын багш нар болон дэмжлэгийн багийн гишүүдэд “Дасан зохицлын болон спорт тоглоомоор дамжуулан ялгаатай | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй” сэдвээр 1.5 өдрийн дадлага сургалтыг зохион байгуулсан. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, тусгай хэрэгцээт боловсролын 70 багшийг Улаанбаатар, Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв, хөгжлийн төв, тусгай 29, 83, 116 дугаар сургуулиудад туршлага судлах үйл ажиллагаанд хамруулсан. Тайлант хугацаанд ерөнхий боловсролын 3, 5, 8 дугаар сургуулиудад тусгай хэрэгцээт боловсролын багш ажиллаж эхэлсэн бөгөөд 2025 онд багш, ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх үйл ажиллагаанд хамрагдвал зохих багш нарыг 100 хувь хамруулсан байна. | |
| 62 | | 2.4.1.4.4. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургалтын орчин нөхцөлийг сайжруулж тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 400.0 | СӨБ, ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эзлэх жин | ЕБС 51.1%<br><br>СӨБ 85.4% | ЕБС 53.1%<br><br>СӨБ 86.4% | 100.0 | - | БГ | НБХ<br>ЕБС<br>СӨББ | Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3, 5 дугаар сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих “Хүүхдийн хөгжлийн танхим”-ыг байгуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд 11 сургуулийн “Хүүхдийн хөгжлийн танхим”-д 260 гаруй хүүхэд 220 багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна. Эдгээр танхимуудын үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлах, хамтарч ажиллах зорилгоор “Ойлгоё, хайрлая, дэмжье” өртөөчилсөн арга хэмжээг зохион байгуулж 60 гаруй эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан байна. 2025-2026 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 261, хүүхдийн цэцэрлэгт 88, нийт 349 хөгжлийн ялгаатай суралцагч хамрагдаж байгаагаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр 252 хүүхэд, эрүүл мэнд хөгжлийн онцлогоос шалтгаалж хүүхдийн цэцэрлэгт 6 настай 19 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад 1 дүгээр ангид элсэн суралцагчид 59.6 хувиар өссөн. Ялгаатай хэрэгцээтэй 1-5 насны 102 хүүхэд байгаагаас 88 хүүхэд буюу 86.6 хувь, 6-18 насны 490 хүүхэд байгаагаас 261 буюу 53.2 хувь нь боловсролд хамрагдаж байна. | 100% |
| 63 | 2.4.1.5. Бүх насны иргэдийг насан туршдаа суралцахуйн үйлчилгээнд хамруулах “Суралцагч сум, байгууллага” болох олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 2.4.1.5.1. Иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж, иргэдийг хамруулах. | 2025-2028 | - | - | Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх жин /өссөн дүнгээр/ | 14.9% | 15.0% | - | - | НТБТ | БГ | Аймгийн Насан туршийн суралцахуйн төв 100 гаруй төрийн байгууллага, 4 төрийн бус байгууллага, 2 олон улсын байгууллага, хувийн хэвшлийн 12 байгууллага, 10 иргэнтэй хамтарсан түншлэл, хамтын ажиллагаагаар иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд тус төвөөс 18 багц хөтөлбөрийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хүрээнд 19788 иргэнийг танхимын сургалтад хамруулсан нь нийт иргэдийн 18.02 хувийг эзэлж байна. Аймгийн Насан туршийн суралцахуйн төв "Суралцагч хот" хөтөлбөрийг Баян-Өндөр сумын ИТХ-тай хамтран 3 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа ба тайлант ЮНЕСКО-ийн Global Network of Learning Cities (GNLC) буюу Суралцагч хотуудын дэлхийн сүлжээний шалгуур үзүүлэлтийг хангаж дэлхийн 79 орны 356 хоттой Монгол улсыг төлөөлөн нэгдсэн байна. | |
| 64 | | 2.4.1.5.2. Насан туршийн боловсролын төвөөс иргэдийн насан туршдаа суралцахуйн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 90.0 | Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо /тухайн жилээр/ | - | - | - | | НТБТ | БГ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 65 | | 2.4.1.5.3. Үндэсний бичгийн хэрэглээг төрийн албан хаагчид, иргэд, хүүхэд залуучуудын дунд түгээн дэлгэрүүлж, иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 40.0 | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны тоо /тухайн жилд/<br><br>Хамрагдсан хүний тоо | 3<br><br>380 | 3<br><br>400 | 10.0 | - | НТБТ | НБХ<br>БГ<br>ХБСЗ | 2025 онд Монгол хэлний анги нийтийн чанарын уралдааныг Боловсролын газар, ерөнхий боловсролын 3 дугаар сургуулиуд хамтран 2 үе шаттай зохион байгуулж, 20 сургуулийн 6-12 дугаар ангийн давхардсан тоогоор 26157 сурагчид оролцсон. Уралдааны I шатны гүйцэтгэлийн дундаж 39.4 хувь, II шатны гүйцэтгэлийн дундаж 48.3 хувь, харьцуулахад 8.9 хувиар ахисан байна. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудсыг 100 хувь хос бичигт шилжүүлж, төрийн байгууллагуудын захиалгын дагуу 47 байгууллагын 800 гаруй албан хаагчийг үндэсний бичгийн сургалтад хамруулж анхан, дунд, шатны мэдлэг чадварыг олголоо. | 100% |
| 66 | 2.4.1.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд шаардлагатай шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг асран хамгаалагчтай хамтран хэрэгжүүлнэ. | 2.4.1.6.1. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын “Үдийн хоол” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах. | 2025-2028 | Улсын төсөв | 4700.0 | 1 хүүхдэд ногдох хоолны илчлэгийн хэмжээ /ккал/ | 550 /ккал/ | 580 /ккал/ | 4700.0 | УТ-3300.0 | БГ | ЕБС-иуд | 2025 онд төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургуульд бага бүлгийн 1-5 дугаар ангид 11600 сурагч үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. 2025 оны 5 дугаар сарын 01-ээс эхлэн “Нэгдсэн цэс-өнгөний систем” нэвтрүүлж 1 хүүхдэд ногдох үдийн хоолны зардлыг 2500 төгрөгт багтаан үндсэн 5 бүлэг хүнсийг зохистой харьцаагаар өгч хоолны дундаж илчлэг 550-610 ккал болсон. 5 өдрийн 4 өдөр халуун боловсруулалттай иж бүрдэл махан хоол, 1 өдөр халуун боловсруулалттай иж бүрдэл цагаан хоолоор үйлчилж байна.Үүний үр дүнд үдийн хоолны илчлэгийн нягт нэмэгдсэн. 5 бүлэг хүнсийг бага хэмжээтэй ч зохистой харьцаагаар өгөх боломжтой болж хоолны шим тэжээлийн байдал нэмэгдэж хүүхдийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | эрүүл мэнд, өсөлт хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна. | |
| 67 | | 2.4.1.6.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд “Өдөр бүр нэг аяга сүү “ арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 3193.6 | Тухайн жилд хамрагдвал зохих хүүхдийн хамрагдалт. хувь | - | 100% | 793.6 | ОНТ-793.6 | БГ | НБХ | Тайлант хугацаанд төрийн өмчийн 17 сургуулийн 6-9 дүгээр ангийн 8353 сурагчийг “Өдөр бүр нэг аяга сүү” арга хэмжээнд хамруулж өдөр бүр 180-200 гр сүүгээр сурагчдын хоногт авах сүүний хэмжээг 100 хувь хангасан. Төрийн өмчийн 31 цэцэрлэгийн 8500 хүүхдийн 5 хоногийн хоолны цэсэд 2-3 удаагийн сүү, цагаан идээ оруулсан байна. “Өдөр бүр нэг аяга сүү” арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 793.6 сая төгрөг зарцуулж, хамрагдвал зохих сурагчид 100 хувь бүрэн хамрагдсан байна. | 100% |
| 68 | | 2.4.1.6.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, хүүхдийн хоолны хангамж үйлчилгээг сайжруулах. | 2025-2028 | - | - | Зөвлөн туслах, хяналт үйлчилгээний тоо<br><br>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт. хувь /тухайн жилээр/ | 2 удаа<br><br>100% | 2<br><br>100% | - | | БГ | ЕБС-иуд СӨББ-ууд | Тайлант хугацаанд аймгийн ЭМГ, ХХААГ-ын улсын байцаагч нар хамтран ерөнхий боловсролын 17 сургууль, 31 цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, агуулах, хоол үйлдвэрлэлийн ажилтнуудын эрүүл ахуй халдвар хамгааллын үзлэг, шалгалтыг хийж 7 зөрчил илрүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг 100 хувь арилгасан байна. Боловсролын газрын зөвлөн туслах ажлын хүрээнд Боловсролын сайдын 2021 оны А/20 тушаалын дагуу байгуулсан “Орон тооны бус хяналтын зөвлөл”, “Дотоод хяналтын баг”-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын тайлан, хоол үйлдвэрлэлийн байр, ажилтнуудын эрүүл ахуй, халдвар хамгааллын бүртгэл, дээж авалтын бүртгэл, хоолны үлдэгдлийн бүртгэл, технологи карт, цэс төлөвлөлт, “Арта” систем ашиглалт, хүнсний түүхий эд худалдан авалтын аж ахуй нэгжтэй хийсэн гэрээнд хяналт тавьж, нөхцөл байдлын дагуу зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. | 50%<br><br>100%<br><br>дундаж 75% |
| 69 | 2.4.1.7 “Багшийн 3 тулгуурт бодлого”-ын хүрээнд багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэлийг сайжруулах “Сайн багшийг таны дэргэд” арга хэмжээг хэрэгжүүлж, Багшийн хөгжлийг дэмжих, урамшуулах, харилцан туршлага солилцох олон талт үйл ажиллагааг зохион | 2.4.1.7.1. Сургалтын чанар, ажлын үр дүнгээр шалгарсан болон улс, олон улсын олимпиад, уралдаан тэмцээн, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 165.0 | Амжилт гаргасан багш, сурагчдын урамшуулалд хамрагдалт. хувь /тухайн жилээр/ | Багш 4 сурагч 25 | 100% | 30.0 | ОНТ-30.1 | БГ | НБХ | Тайлант хугацаанд улсын төрөлжсөн олимпиадуудын багшийн төрөлд амжилттай оролцсон 4 багш, сурагчийн төрөлд амжилттай оролцсон 17 сурагч, сурагчдын бэлтгэсэн 13 багшийг аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 09-ний А/445 дугаар захирамжаар батлагдсан “Урлаг, спорт, сурлагын онцгой амжилт гаргасан уран бүтээлч, тамирчин, сурагч, тэдний багш, дасгалжуулагчдыг урамшуулах журам”-ын дагуу орон нутгийн төсвөөс нийт 7.6 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Мөн 2025 оны элсэлтийн шалгалтад амжилттай оролцож 800 оноо авсан 11 сурагчийн 15.0 сая төгрөгөөр, сурагчдыг бэлтгэсэн 11 багшийг 7.5 сая төгрөгөөр, нийт 22.5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. | 100% |
| 70 | | 2.4.1.7.2. “Оюунлаг хот-Хүн | 2025-2028 | Орон нутгийн | 410.0 | Хөтөлбөрийн хүрээнд | 93% | 100% | 50.0 | ОНТ-59.9 | БГ | НБХ | Тайлант хугацаанд “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд багшийн хөгжлийг дэмжих. | | төсөв | | төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт. хувь | | | | | | | хөгжлийн хөтөлбөр”-ийн 4 зорилтын хүрээнд багш ажилтнуудын хөгжлийг дэмжих, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлээр бага боловсрол, нийгмийн ухаан, монгол хэл, биологи, гадаад хэлний анги нийтийн чанарын уралдаан, эдгээр судлагдахууны багш нарыг чадавхжуулах сургалтууд, багш ажилтны эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйг дэмжих чиглэлээр “Хүүхэд бүрийн тэгш оролцоог хангах арга зүй, үр дүн”, “Анги удирдсан багш болон эцэг эхийн хамтын ажиллагааны үр дүн”, “Боловсролын хөгжил ба түншлэл, хамтын ажиллагааны үр дүн” сэдвүүдээр эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, “Сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн”, боловсролын 2 байгууллагад чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, ЭЕШ-ын урьдчилсан сорилыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, мэргэжлийн хөгжлийн бүлгийн арга зүйн уралдаан, “Монголын багш нарын 59 дэх өдөр”-ийн арга хэмжээ зэрэг 11 үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Дээрх арга хэмжээнүүдэд хөтөлбөрийн зардлаас нийт 59.9 сая төгрөг зарцуулсан байна. | |
| 71 | 2.4.1.8. Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгож, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургуулийг байгуулж, төгсөгчдийг гадаадын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ. | 2.4.1.8.1. ЕБС-иудын ахлах ангийн мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрөөр хичээллэх төрөлжсөн ахлах сургууль байгуулах. | 2025-2028 | - | - | Шинээр байгуулсан ахлах сургуулийн тоо | - | - | - | | БГ | НБХ | Аймгийн ХХҮГ-аас хийсэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа /2023/”, Орхон аймаг дахь Политехникийн коллежоос хийсэн “2021-2025 оны Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа”, сүүлийн 4 жилийн 9-12 дүгээр ангийн сурагчдын хичээл сонголтын судалгаанд тулгуурлан “Мэргэжлийн боловсрол олгох ахлах сургууль байгуулах төсөл”-ийг боловсруулсан. Ахлах сургуулийн хичээлийн байрны асуудлыг орон нутгийн бололцоонд тулгуурлан хэрхэн шийдвэрлэх талаар боломжийн хувилбаруудыг судалж байна. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд энэ арга хэмжээг бэлтгэл хангаж 2027 оноос хэрэгжүүлэхээр тусгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 72 | | 2.4.1.8.2. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг гадаадын, их дээд сургууль, коллежид суралцахад дэмжлэг үзүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 600.0 | Дэмжлэг авсан төгсөгчийн тоо | - | 20 төгсөгч | 300.0 | 84.0 | БГ | НБХ | Аймгийн Боловсролын газраас БНСУ-ын Сүнчон хотын үндэсний их сургуультай 2024 онд байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 оюутан, Сүнчон их сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу нэмэлт элсэлтийг зохион байгуулж 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс түргэвчилсэн хөтөлбөрөөр 11 оюутан | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | тус сургуулийн хэлний бэлтгэлд суралцаж байна. Тайлант хугацаанд нийт 23 оюутанд тус бүр 7.0 сая төгрөг, нийт 161.0 сая төгрөгийн тэтгэлгийг орон нутгийн төсвөөс олгосон байна. | |
| 73 | 2.4.1.9. Их, дээд сургууль, политехник коллежид хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн хөтөлбөрийг нэвтрүүлж, чадвартай хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2.4.1.9.1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, Политехник коллежид дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 60.0 | Дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | 2 | - | - | | БГ | ЭЦДС Политехник коллеж | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 74 | | 2.4.1.9.2. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | - | - | Хөтөлбөрийн тоо /тухайн жилээр/ | ЭЦДС 5 хөтөлбөр | ЭЦДС 1<br><br>Политехник коллеж 2 | - | - | БГ | ЭЦДС Политехник коллеж | Орхон аймаг дахь Политехник коллеж мэргэжлийн боловсролын 3 жилийн ангид 6 мэргэжлийн хөтөлбөр, 1 жилийн ангид 1 мэргэжлийн хөтөлбөр, техникийн боловсролд 3 мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.Тус коллежоос "Хоолны үйлчилгээ", "Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ" мэргэжлийн хөтөлбөрүүдийг магадлуулахаар БМИҮЗ-д материалыг илгээж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу хөтөлбөрүүдэд сайжруулалтыг хийж байна.<br>Тайлант хугацаанд "Эрдэнэт" цогцолбор дээд сургууль дээд боловсролын сургалтын байгууллагын IV шатны магадлал итгэмжлэлээр 2035 он хүртэл 10 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн ба "Мэдээллийн технологи", "Цахилгаан системийн автоматжуулалт", "Уул уурхайн ашиглалтын технологи", "Уул уурхайн машин тоног төхөөрөмж" бакалаврын 5 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн байна. Эдгээрээс 3 хөтөлбөр нь тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн хөтөлбөр байна. | 100% |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | | | | | | |
| 2.5.Аймгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт нэмэгдсэн байна. | | | | | | | | | | | | | | |
| *2.5.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх бэхжиж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулсан байна.* | | | | | | | | | | | | | | |
| 75 | 2.5.1.1. Иргэний эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | 2.5.1.1.1. Хүн амын урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | - | Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт хувиар /тухайн жилээр/ | 56.2 | 56.5 | - | ОНТ-50.0 | ЭМГ | НБХ Сумдын ЗДТГ | Нийгмийн эрүүл мэнд, эрт илрүүлэг үзлэгийн чиглэлээр гарсан холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтэд 19 удаагийн хяналтыг хийж, зөвлөмж өгч, тушаал шийдвэрийн хэрэгжилт дунджаар 86.5 хувьтай байна. 2025 онд нийт 728121 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 283573 буюу 35.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн байна.<br>Хүүхдийн илрүүлэг үзлэгт 33671 хүүхэд хамрагдаж 88.7 хувь, 18-аас дээш насны 26035 хүн хамрагдсан нь хамруулахаар төлөвлөсөн хүн амын 38.0 хувь нь хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд улс орон даяар | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зохион байгуулсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг” үзлэгт нийт хүн амын 67.7 хувь буюу 71542 иргэн хамрагдаж, улсын хэмжээнд 21 аймгаас тэргүүлж байна.<br>Тус үзлэгээр давхардсан тоогоор 83643 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдэн , 57287 хүнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 7414 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад, 11882 хүнийг лавлагаа шатлалын хяналтад авсан байна.Эрт илрүүлэг, үзлэгийн дүнд нийт 148 хавдрын тохиолдол илрүүлснээс 53.2 хувь нь эрт үедээ оношлогдсон байна<br>ЭМДЕГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний 05/2192 тоот албан бичиг, ЭМС-ын 2025 оны 1а/4450 дугаар албан бичгээр "Хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг "-ийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоох шийдвэрийг мэдэгдсэн тул эрт илрүүлгийн үзлэгийг зогсоосон. | |
| 76 | | 2.5.1.1.2. Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлж, халдварт өвчний тохиолдлыг бууруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | - | Товлолт дархлаажуулалтад хамрагдалт. хувь<br><br>Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд /тухайн жилээр/ | 99.3<br><br>101.7 | 99.4<br><br>101.5 | -<br><br>- | ОНТ-30.0 | ЭМГ | НБХ ЭМ-ийн байгууллагууд Сумдын ЗДТГ | Тайлант хугацаанд дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт өвчний хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсэг ажиллаж, 23.7 сая төгрөгийг шийдвэрлэн, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Дархлаажуулалтын талаар иргэдэд мэдээлэл түгээх 4 удаагийн аян, 2 өдөрлөг зохион байгуулж, 1 төсөл хэрэгжүүлэн ажилласан.<br>Дээрх арга хэмжээнд 70 гаруй байгууллага хамтран ажиллаж, давхардсан тоогоор 7000 гаруй сурагч, 6000 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан. Мөн нөлөөллийн уулзалт 1, сургагч багш бэлтгэх сургалтыг 3 удаа зохион байгуулж, орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагч, сурагчид, эцэг эх, асран хамгаалагч нарын төлөөлөл 260 хүн хамрагдсан.<br>Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдан хамралт 53.2 хувьд хүрлээ. Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 745 хүүхдийг хамруулж, 1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж оруулан нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2519 хүүхэд хамрагдаж, хамралт 69 хувьд хүрсэн нь 2025 оны | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | эхний хагас жилтэй харьцуулахад 37 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 971 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 91.3 продецмиль ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 202 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2025 онд товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 5973 хүүхдээс 5967 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99.8 хувьтай байна. | |
| 77 | | 2.5.1.1.3. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 320.0 | Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь /өссөн дүнгээр/<br><br>Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 88.4<br><br>35900 | 89.0<br><br>36400 | 80.0<br><br>- | ОНТ-80.0 | ЭМГ | НБХ ЭМ-ийн байгууллагууд Сумдын ЗДТГ | Аймгийн Засаг даргын 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтцэд байгаа Нийгмийн эрүүл мэндийн төвд 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх чиглэлээр удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Анхан шатлалд нийгмийн эрүүл мэндийн 9 ажилтан орон тоогоор ажиллаж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5-аар нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эрүүл чийрэг эр хүн, Сэтгэцийн эрүүл мэнд, Иргэний эрүүл мэндийн боловсрол гэх мэт 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2024 онд 88.4, 2025 онд 89.5 хувийн хэрэгжилттэй байгаа нь суурь үзүүлэлтээс 1.1 хувиар нэмэгдэж, нийт 32 удаагийн өдөрлөг, аян, форум, 324 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 36752 иргэнийг хамруулж, 29 төрлийн сурталчилгааны материалыг 7453 иргэнд түгээж, цахим хуудаст 842 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 101318 иргэний хандалттай байна.<br>Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 6 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 38 аж ахуйн нэгж, байгууллага, 36452 иргэнийг хамруулан мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлсэн.<br>Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.<br>Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, 22500 гаруй багш, хүүхдийг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хамруулсан байна. | |
| 78 | | 2.5.1.1.4. Эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | - | - | Мэдээлэл, сурталчил гаанд хамрагдсан иргэдийн тоо<br><br>ЭМД-ын хамрагдалт. хувь | 1500<br><br>94.0% | 1600<br><br>95.0% | - | - | ЭМДХ | ЭМГ | Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж,18 байгууллагын 1767 хүнийг хамруулан эрүүл мэндийн даатгалын хамралт 92.5 хувь байна.<br>Тайлант хугацаанд 4 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 1384 хүн, цэрэг татлагаар 1241 залуучуудыг сургалт сурталчилгаанд хамруулснаас 50 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан. Жаргалант суманд зохион байгуулсан малчид, тариаланчдын өдрөөр 106 хүнийг сургалтад хамруулан 30 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 74.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан.Үүнээс эрүүл мэндийн даатгалгүй зорилтот бүлгийн 176 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулсан.<br>Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагууд явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлсэн байна.<br>Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт 95 хувьтай байна. | 100%<br><br>0<br>(92.5-94/95-94)*100=(-1.5/1)*100=-150<br><br>Дундаж 50% |
| 79 | 2.5.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо эмчилгээний техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, төвлөрлийг сааруулах, орон нутагтаа оношлох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2.5.1.2.1. Анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийг нэвтрүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 90.0 | Мобайл технологид хамрагдсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хувь | 66.7 | 77.8 | 30.0 | ОНТ-30.0 | ЭМГ | НБХ Сумдын ЗДТГ Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд | 2019-2025 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мобайл технологийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр 2024 онд 3 өрхийн эрүүл мэндийн төвд, 2025 онд Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийн багцыг олгож, нийт аймгийн 7 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мобайл технологийг нэвтрүүлснээр өмнөх оны мөн үеэс мобайл технологийн хангалт 20.8 хувиар нэмэгдсэн байна. Мобайл технологийн зөөврийн эхо, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийг гэрийн эргэлт болон урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд ашиглаж байна. Тайлант хугацаанд мобайл технологиор 2025 онд 2360 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: хэвтрийн, байнгын асаргаа шаардлагатай 51 ахмадад давхардсан тоогоор 204 удаа зөөврийн эхо оношилгоо, зөөврийн зүрхний | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | цахилгаан бичлэгийн аппаратаар 2156 хүнд үзлэг оношилгоог хийсэн байна. | |
| 80 | | 2.5.1.2.2. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг бууруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 45.0 | Эхийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)<br><br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд) | -<br><br>10.2 | -<br><br>10.1 | 5.0<br><br>- | | ЭМГ | НБХ БОЭТ Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд | Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, нялхсын эндэгдлийг бууруулах 3 бүлэг, 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласнаар хэрэгжилт 90.2 хувьтай байна. Мөн ЭМС-ын 2025 оны А/219 дүгээр тушаалын дагуу батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт 94.6 хувьтай хэрэгжсэн байна. Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдэл,хүүхэд хамгааллын мэдээллийг урсгалын дагуу шуурхай солилцон хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллаж, эмнэл зүйн 3 конференц, салбар дундын 2 хэлэлцүүлэг хийгдэж, нялхсын эндэгдлийг бууруулах 4 зөвлөмжийг хүргүүлэн анхан болон 2 дахь шатлалын эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд 3 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан.<br>Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан танхимын 14 удаагийн сургалтад 395, ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах 10 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 83 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхэд, амьгүй төрөлт, гэрийн төрөлт, эхийн ноцтой хүндрэлийн тохиолдлыг магадлан хэлэлцэх зөвлөлөөр тайлант хугацаанд 4 удаа хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн хэрэгжилт 88.9 хувьтай байна.<br>Амьдралын алтан 1000 хоног сэдэвт 2 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг 234 иргэнд, төрөх тасгийн 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, 6 видео 7690, “Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” 4 постер бэлтгэж 25196 хандалт авсан байна.<br>2025 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 2.1 промилл, хүрэх түвшнөөс 1.9 промиллээр тус тус буурсан байна. | 100% |
| 81 | | 2.5.1.2.3. Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 1540.0 | 1-р зэргийн эрэмбээр яаралтай тусламжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 150 | 160 | 385.0 | ОНТ-465.0 | ЭМГ | НБХ Эрүүл мэндийн байгууллагууд | Тайлант хугацаанд 10429 түргэн тусламжийн дуудлага хүлээн авснаас 20 минутын дотор буюу 1 дүгээр зэргийн эрэмбээр яаралтай тусламжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо 8009 буюу 76.7 хувь, 21-40 минутад 2117 буюу 20.3 хувь, 41-60 минутад 251 буюу 2.4 хувь, 60 минутаас урт хугацаанд очсон 52 буюу 0.5 хувийг | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх. | | | | | | | | | | эзэлж байна. Түргэн тусламжид ашиглагдаж байгаа 11 автомашинаас 3 нь бүрэн, 6 нь хагас тоноглогдсон, эвдрэлтэй 2 автомашины сэлбэг хэрэгслийн судалгааг гаргасан. Яаралтай болон амилуулах суурь тусламж үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан ЭМБ-уудын хувь 90.5, амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавх 91.2 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар нэмэгдсэн байна.<br>БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолыг цахимжуулах үйл ажиллагааг орон нутгийн төсвийн 75.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлснээр хүлээгдлийг бууруулж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдэн, санал гомдол өнгөрсөн оны мөн үеэс 8.0 хувиар буурсан байна.<br>2025 онд амилуулах суурь тусламж үзүүлэх чадавхтай иргэд, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх 12 удаагийн сургалтад төрийн 48 байгууллагын 498 албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын 188 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах 8 сэдвийн хүрээнд 6 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1445 ажилтныг хамруулан чадавхжуулсан. Боловсролын салбарт ажиллаж байгаа эмч нарын яаралтай тусламжийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор дадлага, сургалтыг зохион байгуулж, сургалтын өмнөх болон дараах сорилоор мэдлэгийг үнэлэн 28 хувиар нэмэгдүүлсэн үр дүнд хүрсэн байна. | |
| 82 | | 2.5.1.2.4. Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын нөөц хангалтыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 165.0 | Хариу арга хэмжээний чадавх, хувиар | 95 | 95.2 | 30.0 | УТ-31.5 ОНТ-141.5 | ЭМГ | НБХ Сумдын ЗДТГ | Тайлант хугацаанд Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу томуу томуу тест өвчин, улаанбурхан өвчний дэгдэлтийн үед ЭМГ, ЭМБ-ууд нь Тохиолдол удирдлагын тогтолцоонд 2 удаа шилжин хариу арга хэмжээнд салбар дундын оролцоог хангаж, эрсдэлийн үнэлгээг 6 удаа хийн, өрхийн эрүүл мэндийн төвүүд уртасгасан цагаар ажиллаж, хүүхдийн тасгийн орыг 150-д хүргэж дэлгэн хариу арга хэмжээний хэрэгжилт 95.6 хувьд хүрсэнээр томуугийн тархалтын түвшнийг “Аймгийн” түвшнээс “Алаг цоог” түвшинд 14 хоногийн дотор бууруулсан байна.Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээ, эрсдэлийн харилцаа холбоог мэдээллийг идэвхжүүлэн ажилласан. 2025 онд улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэн, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьтлад тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 347/96.9 хувь/ хүнийг дархлаажуулалтад хамруулан хариу арга хэмжээг шуурхай авч ажилласнаар 2025 оны 9-р сараас хойш улаанбурхан өвчний сэжигтэй, батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна.<br>ЭМГ-ын гамшгийн нөөц 12 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байна. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91.7 хувь байгаа нь суурь түвшнээс 0.1 хувиар нэмэгдсэн байна.<br>"Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо" сургалтад аймгийн ЗДТГ, ОБГ, ЦГ-ын удирдлага, мэргэжилтнүүд, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллага, хүүхдийн байгууллагын эмч зэрэг нийт 145 хүнийг хамруулан чадавхжуулсан. | |
| 83 | | 2.5.1.2.6. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 1880.0 | Тоног төхөөрөмжийн хангалт. хувь | 95.5 | 95.6 | 708.5 | УТ-870.6 ОНТ-1459.5 | ЭМГ | НБХ Сумдын ЗДТГ | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувь, үүнээс дэвшилтэт технологийн тоног төхөөрөмж 20 хувийг эзэлж байгаа бөгөөд шаардлагатай 600 гаруй тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн 1145.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжийн нээлттэй тендер зарлагдаж 100 хувь нийлүүлэгдэн ашиглагдаж байна .Үүнд:<br>– Ариутгалын газ плазма аппарат - 150.0 сая төгрөг<br>– Эрчимт эмчилгээ,мэдээгүйжүүлгийн тасгийн унтуулгын аппарат- 500.0 сая төгрөг<br>– Түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад- 75.0 сая төгрөг<br>– Гемодиализийн CRRT аппарат- 130.0 сая төгрөг<br>– Бусад компьютер,техник хэрэгсэл–218.0 сая төгрөг, өөрийн хөрөнгөөс 72.0 сая төгрөгийг тоног төхөөрөмжийн шинэчлэлд | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зарцуулж тоног төхөөрөмжийн ашиглалт 100 хувьд хүрээд байна<br>-НҮБ-ын ХАС-аас нийлүүлсэн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх Sterilwave-100 бутлагч автоклавыг БОЭТ-ийн хог хаягдлын нэгжид суурилуулан ЭМБ-уудын аюултай хог хаягдлыг устгалд оруулж байна.<br>Улсын төсвөөс Эмгэг судлалын гистологи шинжилгээ хийх иж бүрэн тоног төхөөрөмж 738.8 сая төгрөг, ходоодны дурангийн оношилгоонд 100.3 сая төгрөгийн 2 ширхэг уян дурангаар хангагдан оношилгооны чадавх нэмэгдсэн байна.<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5092:2017 стандартын дагуу 8 багц 69 төрөл тоног төхөөрөмж байх шаардлагатайгаас хангалтын хувь 96.5 хувь, ашиглалтын хувь 96 хувьд хүрээд байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн лабораторийн шинжилгээнд бамбайн даавар, витамин Д, глюкозын гурван сарын дундаж үзэж, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.<br>2025 онд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, лабораторийн тусламж үйлчилгээний нэр төрлийг сайжруулах чиглэлээр нийт улс, орон нутгийн 173.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, машин олгосон байна. Үүнд :Орон нутгийн 141.5 сая төгрөгийн санхүүжилтээр:<br>o Шарлагын аппарат-Мөнхсүндрэл, Анхны Оч<br>o Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат -Анхны Оч<br>o Мобайл технологи-Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв<br>o Жаргалант суманд иммунологийн аппарат, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, поток, искра аппаратууд нийлүүлэгдсэн байна.<br>Улсын төсвийн 31.5 сая төгрөгийн өртөг бүхий ECG S120 эрт илрүүлэг хийх зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 9 сум, өрхийн эрүүл мэндийн төвд олгосон байна. | |
| 84 | 2.5.1.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна. | 2.5.1.3.1. Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан тогтвортой үйл ажиллагааг дэмжих. | 2025-2028 | | - | Нийтийн үйлчилгээт эмийн сангуудын стандарт хэрэгжилт. хувь | 95 | 95.2 | - | - | ЭМГ | НБХ<br>Эм холбоо | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн үйлчилгээтэй 74 эмийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 онд 1-р зэрэглэлийн эмийн сан 52, 2025 оны байдлаар 46 болж 11%-иар буурсан, 2-р зэрэглэлийн эмийн сан 25 -аас 28 болж 12%-иар нэмэгдсэн.Ингэснээр хотын төвд байрлалтай эмийн сангийн төвлөрөл буурч, гэр хороололд байрлах эмийн сангийн тоо өсөж, алслагдсан багийн иргэдэд хүргэх эм зүйн тусламж үйлчилгээ ойртсон байна.Эрүүл | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | мэндийн даатгалын сантай гэрээтэй хөнгөлөлттэй үнээр эм олгодог эмийн сан 2020 онд 28 байсан бол 2025 онд 53 болж 52,8%-аар нэмэгдсэн байна<br>“Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 95.2 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Тайлант хугацаанд стандартын шаардлага хангаагүй 3 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ирсэн албан тоотын дагуу Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжаар 2025 оны 09 дүгээр сарын 17-27-ны хооронд 10 хоногийн аян зохион байгуулж, эмийн зохистой хэрэглээтэй холбоотой иргэдэд хандсан 8 брошюр, цахимд 10 мэдээлэл хүргэсэн.<br>Сэтгэцэд нөлөөт эмийн 3786 ширхэг жорыг 13 байгууллагад, мансууруулах эмийн жорыг 3 байгууллагад 557 ширхгийг тус тус дугаарлан олгосон.<br>Анзаар-2 аяны хүрээнд ЭМГ, Тагнуулын газар, Цагдаагийн газар хамтран бүх нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад хяналт хийсэн байна. Хяналтаар 6 байгууллагад зөрчил шалган шийдвэрлэж, бүх эмийн сангуудад хяналтын дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн.<br>Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 95.2 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.2 хувиар нэмэгдсэн байна. | |
| 85 | | 2.5.1.3.2. Эмнэл зүйн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | - | Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хүний нөөцийн хангалт. хувь | 42% | 55% | - | - | ЭМГ | БОЭТ ХХЭМБ | .Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 136 эм зүйч, 110 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмнэл зүйн тусламж үйлчилгээний хүний нөөцийн хангалтаар эм зүйч 5 хувиар нэмэгдсэн байна. 2025 оны байдлаар эмнэл зүйн тусламж үйлчилгээний хүний нөөцийн хангалт 59.1 хувьтай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 6 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 12 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 хувиар нэмэгдсэн байна. БОЭТ-ийн эмчийн хангалт 98.6 хувь, сувилагчийн хангалт 96.7 хувьтай байна. Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 51.8-59.3 хувьд тарилгыг хийж, 40.7-48.2 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 3.1 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 7.1-10.3 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | удирдамжийн хэрэгжилт 88.1 хувь болж 2.3 хувиар нэмэгдэж, эмийн зохистой хэрэглээний алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буурсан байна.Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 85.6 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар нэмэгдсэн байна. | |
| 86 | 2.5.1.4. Иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ. | 2.5.1.4.1. Алсын зайн оношилгоо, телемедицин, хиймэл оюун ухааныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж, хүртээмжийг сайжруулах. | 2025-2028 | Улсын болонорон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 140.0 | Алсын зайн оношилгоо, телемедицин, хиймэл оюун ухааныг нэвтрүүлсэн байгууллагын тоо<br><br>Алсын зайн оношилгоо, телемедицин, хиймэл оюун ухаанаар оношлогдсон иргэдийн тоо | 6<br><br>20 | 7<br><br>25 | - | - | ЭМГ | НБХ | Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг erdenet.mn, or.mohs.gov.mn, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар иргэдэд хүргэж буй үйлчилгээг авч үзвэл:<br>-Засгийн газар, ЭМЯ-наас E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлтийг нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тус "E-Mongolia" системээс эрүүл мэндийн 19 төрлийн үйлчилгээг иргэд авч байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, эмийн жор бичилт зэрэг 7 үйлчилгээг "E-Mongolia" системээс авах боломжтой болсон.<br>-Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвд цаг товлох, түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл,цахим өвчний түүх хөтлөх ажиллагааг хялбаршуулан, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, кодыг олгох зориулалтаар ашиглах зөөврийн таблет ашиглаж хэвшсэн байна.<br>-2025 онд Засгийн газрын 100 хоногийн ажлын хүрээнд em.hdc.gov.mn сайтад улс даяарх бүх эмийн сангийн байршил болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн үнийн мэдээлэл байршсан үүнээс Орхон аймгийн 74 эмийн сангийн байршил, үнийн мэдээлэл орсон байна. 2025 оны байдлаар алсын зайн оношилгоо, телемедицин, хиймэл оюун ухааны техник тоног төхөөрөмж ашиглаж байгаа 11 байгууллага байна. Тайлант хугацаанд БОЭТ нь 26 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан 3 дахь шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна.<br>БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсанаар нийт 32 өвчтөнд зөвлөгөө авсан байна<br>Телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 62 хүний мэдээллийг оруулсан.<br>Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт 15 үйлчлүүлэгчид үзүүлсэн байна.<br>Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж байна<br>Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь цээжний зургийн рентген оношилгоо, эсийн ПАП шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглан оношилгооны хүлээгдлийг бууруулж байна.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад ДЭМБ-ын халдварт бус өвчин, зүрх судасны өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц арга хэмжээ (PEN/HEARTS)-ыг нэвтрүүлэх “МонПэн” санаачилга хэрэгжиж, Орхон аймагт 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр нээлтээ хийж, хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 352 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | |
| 87 | 2.5.1.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, дотоод болон гадаадад хүний нөөцийг бэлтгэн сургах, туршлага солилцох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2.5.1.5.1. “Оюунлаг хот-Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд эмч, эрүүл мэндийн ажилтны хөгжлийг дэмжих | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 260.0 | Эмч хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 97.8% | 100% | 50.0 | ОНТ-162.0 | ЭМГ | НБХ Эрүүл мэндийн байгууллагууд | “Эмч” хөтөлбөрийн 2021-2024 оны хэрэгжилт 97.8 хувьтай хэрэгжиж дууссан.<br>2025 онд Эрүүл мэндийн ажилтны сургалт хөгжлийн үйл ажиллагаанд Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2025-2028/-оос албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 120 сая, Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрөөс 3.5 сая төгрөг, Эрүүл мэндийн байгууллагуудын зардлаас 80.0 сая төгрөг нийт 203.5 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 2.4%-иар нэмэгдсэн байна.<br>Улсын төсвийн санхүүжилтээр 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, БОЭТ-ийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн яаралтай сувилахуй 17, эрчимтийн сувилахуйгаар 4 эмнэлгийн мэргэжилтэн, ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 275 мэргэжилтэн хамрагдаж, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 12.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0,4 хувиар | 100 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | өссөн үзүүлэлттэй байна.<br>Дэлхийн эмч, сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан бага хуралд 199 судлаач оролцож, 49 илтгэл хэлэлцүүлэн Эрдэм шинжилгээний бага хурлаас шалгарсан шилдэг илтгэлүүдээр “Анагаах увдис” сэтгүүлийн 9 дэх дугаарыг 300 ширхэг хэвлүүлсэн. БНСУ-д болсон Ази, Номхон далайн өрхийн эмч нарын чуулганд 8 төвийн 11 эмч, Австри, БНСУ-д нийт 12 эмч,эмнэлгийн мэргэжилтэн мэргэжил дээшлүүлсэн байна. 2025 онд Эмч, ажилчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Жаргалант сумын ЭМТ-ийн 2 их эмчийг орон сууцаар хангаж, орон сууцны урьдчилгаа 30%-ийг Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн жолоочид олгон, хувийн хэвшлийн байгууллагууд 92.4 сая төгрөгийг нийгмийн баталгаанд зарцуулсан бөгөөд нийгмийн дэмжлэгт хамрагдалт 17.0 хувьд хүрч, хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт 97.8 хувьтай байна Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрүүл мэндийн салбар байгууллагуудын 78.4% буюу 1639 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, 13.7 сая төгрөгийн аминдэмжүүлэлтэд хамруулан дэмжлэг үзүүлсэн байна.<br>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангасан байна. | |
| 88 | | 2.5.1.5.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг сайжруулж, нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь | 14 | 14.1 | - | ОНТ-73.0 | ЭМГ | НБХ | 2025 онд нийт эрүүл мэндийн салбарт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна.Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр нэмэгдсэн байна.<br>2025 онд улсын төсвийн санхүүжилтээр 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, БОЭТ-ийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн яаралтай сувилахуй 17, эрчимтийн сувилахуйгаар 4 эмнэлгийн мэргэжилтэн, ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 275 мэргэжилтэн хамрагдаж, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 17.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.<br>Төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалт, | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | нийгэмлэгийн хуралд давтагдсан тоогоор 1956 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж, ур чадвараа нэмэгдүүлсэн байна.Магистр, докторын сургалтад 14 мэргэжилтэн суралцаж байгаа бөгөөд үүнээс 5 нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр шинээр элссэн байна.<br>Тайлант хугацаанд 1 эмч БНСУ-д өвдөгний үений мэс заслын чиглэлээр, Япон, БНХАУ, Филиппин, Узбекстан, БНСУ зэрэг оронд эх барих, нярайн эмчилгээ, мэс засал, удирдлага, хараа зүй, бөөр, мэдрэл зэрэг чиглэлээр 11 эмч олон улсын сургалт, семинарт хамрагдан онол, дадлага хослуулан ур чадвараа дээшлүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлсэн.<br>Хүний папилома вирусийн эсрэг вакцины бүсийн сургалтад 42 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсаны үр дүнд хүний папилома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь 25 хувиар өсөж 53.2 хувьд хүрч, нярайн цогц скринингийн сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн мэдлэг 17 хувиар нэмэгдсэн байна. | |
| 89 | 2.5.1.6. Нийгмийн эрүүл мэндийн төв болон 2 -оос доошгүй өрхийн эрүүл мэндийн төвийг багийн нутаг дэвсгэрт нь ашиглалтад оруулан нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2.5.1.6.1. Нийгмийн эрүүл мэндийн төв болон 2-оос доошгүй өрхийн эрүүл мэндийн төвийг багийн нутаг дэвсгэрт нь ашиглалтад оруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 11596.0 | Ашиглалтад орсон барилга | - | Бэлтгэл ажил хангаг дана | 196.7 | ОНТ-100.0 | ЭМГ | НБХ | Улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсөвт Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв, магадлангийн саналыг ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>Бүрэнбүст, Уртбулаг багийн иргэдэд үйлчлэх хүрээг ойртуулан Уртбулаг багийн нутаг дэвсгэрт шинээр баригдах 1250 м2 талбайтай өрхийн эмнэлгийн барилгын газрыг шийдвэрлэж, холболтын зургийг хийлгэхээр 2026 оны төсвийн саналд тусгуулсан.<br>Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах саналыг ЭМЯ-нд хүргүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт 422.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн тусгуулаад байна. | 50% |
| **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | |
| **Хот төлөвлөлт, Газар зохион байгуулалт** | | | | | | | | | | | | | | |
| 3.1.Иргэдэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн “Төлөвлөлттэй хот”-ыг бий болгоно. | | | | | | | | | | | | | | |
| *3.1.1.Хот байгуулалтын норм дүрмийн хэрэгжилт хангагдана.* | | | | | | | | | | | | | | |
| 90 | 3.1.1.1. Эрдэнэт хотыг 2045 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж батлуулна. | 3.1.1.1.1. Ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлж эхлэх. | 2025-2028 | Улсын төсөв | 1300.0 | Гэрээний хэрэгжилтийн хувь | 0 | 30 | 1300.0 | УТ-1300.0 | БОНХОБТХ ГХБХБГ | ХББЗА | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12 дугаар тушаалаар "Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж 2024 онд Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан. “Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2045”-ийн ТЭЗҮ хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласнаар 2024 оны | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | 10 дугаар сарын 31-нд “Нью урбанизм” ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар хамгийн сайн үнэлэгдэн шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ба одоогийн ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авч, Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засаж шинэчлэн хийж, иргэдээс хотын газарзүйн ерөнхий байдлын судалгааг авч, 1 удаа олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн байна. Мөн бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах Дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдож дулааны станцын байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэрийг гаргаад байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болон бусад судалгааны ажил хийгдэж байна.<br>Ажил гүйцэтгэгч “Нью урбанизм” ХХК-иас 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр эхлэлийн тайланг хүлээлгэн өгөөд байна. | |
| 91 | 3.1.1.2. Ухаалаг хотын төлөвлөлтөд мөрдөгдөх жишиг зураг, төслийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ. | 3.1.1.2.1. Хотын хэмжээнд стандартад нийцсэн жишиг зураг, төслийг боловсруулж, мөрдөх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 400.0 | Жишиг зураг төслүүдийн боловсруулалтын хувь /Өссөн дүнгээр/ | 25% | 25% | 100.0 | ОНТ-1075.0 | БОНХОБТХ | ХЗА ГХБХБГ ХББЗА | 2025 онд Хотын захирагчийн албанаас боловсруулагдсан нийт 490.0 сая төгрөгөөр 106 зураг төслийг боловсруулахад барилгын салбарт шинээр нэвтрүүлж байгаа материал болон тоног төхөөрөмжийг тусган ашиглаж, Барилгын тухай хууль болон барилгын норм дүрмийн дагуу зураг төслийг боловсруулан ажилласнаар зураг төслийн төсвөөс 490.0 сая төгрөгийн хэмнэлтийг гаргасан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, болзошгүй аваарын зардлаар барилгын ажлын зураг төсвийг боловсруулахаас гадна фасадын дулаалгын ажил, авто машины 2 мөртэй зам, тоглоомын талбайн зураг төслийг Хотын захирагчийн алба, Хот байгуулалт барилга захиалагчийн алба болон зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлж, 585.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 39 зураг төсөл боловсруулахад | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | барилгын салбарт шинээр нэвтрүүлж байгаа материал, тоног төхөөрөмжийг тусгасан жишиг зураг төсөл болсон байна. Жишиг зураг төсөлд шинээр нэвтрүүлж буй хөнгөн цагаан металл хавтан, 3 давхар шилтэй цонх, Fit хавтан, техно стандарт базальт хөвөн зэргийг тусгасан. Тоног төхөөрөмжийн зураг төслийн тухайд гадна талбайн тохижилтын ажилд хүүхдийн аюулгүй байдлыг хангахуйц хагас резин бүрхүүлтэй хавтан, гадна зам талбайн өөр дээрээ рекламын самбар бүхий гэрэлтүүлгийг тус тус төлөвлөн боловсруулсан. Ингэснээр жишиг зураг төслийн боловсруулалт 36.7 хувьд хүрсэн. | |
| 92 | | 3.1.1.2.2. Хот байгуулалтын өндөржилтийг хянах, барилгажуулахад шаардлагатай JNNSS-ын байнгын ажиллагаатай суурин станцыг сумдад шинээр нэмж байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 400.0 | Нийт станцын тоо /өссөн дүнгээр/ | 1 | - | - | | БОНХОБТХ ГХБХБГ | ХЗА Сумдын ЗДТГ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2027 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 93 | | 3.1.1.2.3. Сургууль, цэцэрлэгийн ашиглалтын төлөв байдлыг тодорхойлж, паспортжуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 400.0 | Паспортжуулсан барилгын тоо /тухайн жилээр / | - | 2 | 100.0 | ОНТ-451.8 | БОНХОБТХ ГХБХБГ | ХЗА | 2025 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж 2 дугаар сургуулийн хичээлийн 1, 2 дугаар байр, 7 дугаар сургуулийн байр, 3, 16, 17, 18, 26 дугаар цэцэрлэгийн байрны барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулж, паспортжуулах зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтад Шинжлэх ухаан технологийн их сургуулийн барилгын материалын судалгааны төв шалгаран гэрээ байгуулж ажиллаж, барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдлыг тогтоож паспортжуулах ажлыг хийж хүлээлгэн өгсөн. Тус ажлыг орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн байна. Барилга байгууламжийн ашиглалтын төлөв дүгнэлтээр 2 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байр, 18 дугаар цэцэрлэгийн барилгыг ашиглах боломжгүй, 16, 17, 26 дугаар цэцэрлэгийн барилгын суурийн үндсэн хийц элементэд суулт өгч байгаа тул хүчитгэх арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэгдсэний дагуу болзошгүй аваарын зардлын 351.8 сая төгрөгийн санхүүжилтээр 26 дугаар цэцэрлэгийн барилгын дотор хамар ханын сууринд хүчитгэл хийх засварын ажлыг "Мөнгөн орхон сорт" ХХК-иар гүйцэтгүүлж хэвийн ажиллагаанд оруулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 94 | 3.1.1.3. Хотын гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг сайжруулан хаягийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 3.1.1.3.1. Хаягийн мэдээллийн системийг хөгжүүлж, хаягийн шинэчлэлийг хийх. | 2025-2028 | - | - | Хаягийн мэдээллийн системийн нэгж талбар /өссөн дүнгээр/ | 20000 | 22000 | - | - | ГХБХБГ | БОНХОБТХ Сумдын ЗДТГ | Хаягийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлтийн хүрээнд Газар зохион байгуулалт, газар зүйн ерөнхий газраас ирүүлсэн хаягийн мэдээллийн системд оруулах өгөгдөл, мэдээг зураглах аргачлалын дагуу 2025 онд 25842 нэгж талбарын орц гарц, 1394 гудамж, 2818 замын зураглалыг засварлан хүргүүлсэн.<br>Газрын мэдээллийн санд бүртгэлтэй 27808 нэгж талбар байгаагаас хаягийн мэдээллийн системээс 21900 нэгж талбарт хаяг олгосон байна. | 100% |
| 95 | | 3.1.1.3.2. Хотын гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг стандартын дагуу тэмдэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 181.9 | Нэгж талбарын тоо /тухайн жилээр/ | 2810 | - | - | - | Сумдын ЗДТГ | ГХБХБГ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 96 | 3.1.1.4.Иргэдийн орлогод нийцсэн болон ногоон амины орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ипотекийн, ногоон зээлийн бодлогоор дэмжиж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана. | 3.1.1.4.1. Хот дахин төлөвлөн барилгажуулах ажлыг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 480.0 | Судлагдсан байршлын тоо /Өссөн дүнгээр/ | 3 | 4 | 120.0 | | БОНХОБТХ ХББЗА | ГХБХБГ | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хэрэгжүүлэх талбайн хэмжээ байршил, хил зааг зориулалт батлах тухай" тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9га, Уурхайчин багт 1.3га газарт дахин төлөвлөлт хийж батлуулсан.<br>Их залуу багийн нутаг дэвсгэр орчмын 40.8 га талбайд дахин барилгажуулах ажлын хүрээнд "Инженер геодези" ХХК хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/02 дугаар тогтоолоор тус хэсгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.<br>2025 онд "Уурхайчин багт аймгийн биеийн тамир спортын хорооны Б заалны хойд талд Ус дулаан хуваарилах төв барих" ажлыг орон нутгийн төсвийн 1.2 тэрбумын хөрөнгө оруулалтаар "Мэжийн савдаг" ХХК нь 2024-2025 онд гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Тус багийн 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажилд “Таван хан энержи” ХХК шалгаран туслан гүйцэтгэгчээр "ЯБН" ХХК нь 168 айлын үйлчилгээтэй 3 блок орон сууцны барилгын эхний блокийн барилгын ажлыг эхлүүлж ажлын гүйцэтгэл 15 хувьтай үргэлжилж байна.<br>Цагаанчулуут багт 11.9га талбайд дахин төлөвлөн барилгажуулах хэсэгчилсэн төлөвлөлтийг "Инженер геодези" ХХК боловсруулан дуусгаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус байршилд Ус дулаан дамжуулах төвийг "Мэжийн савдаг" ХХК орон нутгийн төсвийн 1.5 тэрбум, Цахилгаан хуваарилах байгууламжийг "Оркон тех" ХХК нь орон нутгийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | төсвийн 427.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж ашиглалтад оруулла. Мөн “Эрчим хорооллын барилгажилтын төсөл” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Ди Ди Эй Жи" ХХК нь тендерт шалгаран Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 88.1 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, 4 га талбайд нам давхрын 89 айлын орон сууц төлөвлөн ажлыг бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. | |
| 97 | | 3.1.1.4.2. Дөмөг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 200.0 | Төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэл. хувь /өссөн дүнгээр/ | - | - | - | 88.1 | ГХБХБГ | БОНХОБТХ | Баян-Өндөр сумын Оюут баг, Дөмөг орчмын 25 га талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Ди Энд Жийс” ХХК боловсруулж байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний техникийн нөхцөлийн хурлыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хуралдуулж техникийн нөхцөл гаргахаар шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 98 | | 3.1.1.4.3. Залуус хорооллын инженерийн шугам сүлжээний зураг, төслийг боловсруулж батлуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 83.3 | Зураг төслийг боловсруулах ажлын гүйцэтгэл. хувь /өссөн дүнгээр/ | - | 50% | 83.3 | - | БОНХОБТХ | ГХБХБГ ХББЗА | Залуус хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг “ОТЗТ” ХХК 20 хувийн гүйцэтгэлтэй боловсруулж байна. Эрчим хүчний яамнаас тус хэсгийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажил техникийн нөхцөлийг олгох ажил удаашралтай байсан тул удаа дараа тус яаманд техникийн нөхцөл авах талаар хүсэлт гарган ажилласнаар 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр техникийн нөхцөлийг олгоод байна. Мөн Залуус хорооллын инженерийн шугам сүлжээг II хэсэгт барих ажлын хүрээнд цэвэр, бохир усан хангамж, цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-аас олгосон6 Залуус хорооллын инженерийн шугам сүлжээг II хэсэгт барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Ингэснээр нийт ажлын гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна. | 100% |
| 99 | | 3.1.1.4.4. Эрчим хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зураг төслийг боловсруулан дэд бүтцийг барих | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 3,180.0 | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 10% | 180.0 | 88.1 | БОНХОБТХ ГХБХБГ | ХЗА ХББЗА | “Эрчим хорооллын барилгажилтын төсөл” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Ди Ди Эй Жи" ХХК нь тендерт шалгаран Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 88.1 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, 4 га талбайд нам давхрын 89 айлын орон сууц төлөвлөн ажлыг бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. | 100% |
| 100 | | 3.1.1.4.5. Аймгийн хэмжээнд ногоон бүсчлэл тогтоох зураг төслийг боловсруулах. | 2025-2026 | Орон нутгийн төсөв | 50.0 | Зураг төслийн боловсруулах ажлын гүйцэтгэл. хувь | - | 70% | 50.0 | | БОНХОБТХ БОГ | ХЗА ГХБХБГ ХББЗА | Эрдэнэт хотын бүсчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ногоон бүсчлэл тогтоох судалгааг хийж, ногоон бүсийг тогтоосон. Эрдэнэт хотын хөгжлийн бүсчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй хамт ногоон бүсчлэл | 28.6% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | тогтоох зураг төслийг хийхээр хүлээгдэж байна. | |
| 101 | 3.1.1.5. Барилгын материалын чанар, хяналт, шинжилгээний лабораторийн хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, лабораторийн үйл ажиллагааг тогтворжуулна. | 3.1.1.5.1. Лабораторийн үйл ажиллагааг сайжруулан бэхжүүлж, шинжилгээнд хамруулах дээж, сорьцыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | ААНБ | 32.0 | Барилгын сорил шинжилгээний тоо | 800 | 900 | 8.0 | - | ГХБХБГ | БОНХОБТХ ААНБ-ууд | Барилгын материалын лаборатори нь Үндэсний Итгэмжлэлийн төвийн Зам, барилгын материалын сорилтын лабораторийн итгэмжлэлийн Техникийн хорооны 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар барилгын түүхий эд материалын 11 багц бүтээгдэхүүний 71 үзүүлэлтээр давтан итгэмжлэгдсэн.<br>2025 онд Бетон хийц, төрөл бүрийн бетоны цутгалтаас авсан бетон сорьцын 1703, дүүргэгч материал болох элсний 15, хайрга, дайргын 30, явган замын хавтангийн 18, тоосгоны 1, хөөсөн полистрол хавтангийн 3, нийт 1770 дээжид сорилт шинжилгээ хийн ажилласан. | 100% |
| 102 | | 3.1.1.5.2. Тохирлын гэрчилгээтэй аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх. | 2025-2028 | ААНБ | - | Тохирлын гэрчилгээ авсан ААН-ийн тоо /Тухайн жилээр/ | 2 | 2 | - | - | ГХБХБГ | БОНХОБТХ ААНБ-ууд | Орхон аймагт Бетон зуурмагийн 13 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас тохирлын гэрчилгээтэй 9, тохирлын гэрчилгээ сунгах 2, шинээр авах 2 үйлдвэр байгаа судалгааг гарган тохирлын гэрчилгээг авхуулах ажлыг зохион байгуулснаар 2025 онд бетон зуурмагийн 2 үйлдвэр тохирлын гэрчилгээ авсан байна. | 100% |
| 103 | | 3.1.1.5.3. ЭДЦС ТӨХК-иас гарч буй үнсэн сан болон Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын сангаас гарч буй нунтгийг барилгын материалд ашиглах боломжтой эсэх судалгаа хийх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 500.0 | Судалгааны ажлын гүйцэтгэл. хувь /өссөн дүнгээр/ | - | 25% | 125.0 | - | БОНХОБТХ | ГХБХБГ ТББ-ууд Мэргэжлийн холбоод | Орхон аймагт бетон зуурмагийн үйлдвэрүүдэд хэрэглэгдэж буй материал, орц нормд мониторинг хийх ажлын даалгавар, төсвийг боловсруулсан. Ажлын даалгавраар 40.0 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээний зардалд батлуулж, тендер сонгон шалгаруулалтыг зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна.<br>ЭДЦС ТӨХК-иас гарч буй үнсэн сан болон Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын сангаас гарч буй нунтгийг барилгын материалд ашиглах судалгааны төсвийг 2025 оны төсөвт тусгах саналыг оруулсан боловч батлагдаагүй тул 2026 оны орон нутгийн төсөвт зөвлөх үйлчилгээний зардлыг батлуулсан. . | 0 |
| 104 | 3.1.1.6. Аймгийн газар зохион байгуулалтын 2037 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 3.1.1.6.1.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үе шаттай боловсруулан хэрэгжүүлэх. | 2025-2028 | - | | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 82% /сүүлийн 5 жилийн дундаж/ | 82% | - | - | ГХБХБГ Сумдын ЗДТГ | БОНХОБТХ | Аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Баян-Өндөр, Жаргалант сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумдын ИТХ–аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2025 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу аймаг, сумдын Засаг даргын захирамжаар дуудлага худалдаагаар 13 байршилд 3.79 га, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 28 байршилд 16.53 га, малчдын хоршоонд 5 байршилд 23.13 га газрыг эзэмшүүлж газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд мэдээ мэдээллийг нэгтгэн бүртгэн газрыг эзэмшүүлэн цахим гэрээ гэрчилгээг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | олгоод байна. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн хэмжээнд 11 арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 90.7 хувьтай дүгнэгдсэн байна. | |
| 105 | 3.1.1.7. Газар ашиглалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг сайжруулна. | 3.1.1.7.1. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулж, гарсан дүгнэлтийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж өгөх. | 2025-2028 | Иргэд ААНБ | 320.0 | Хянан баталгаанд хамруулсан нэгж талбар /Өссөн дүнгээр/<br><br>Зөвлөмж өгсөн иргэн, ААНБ-ын тоо /Өссөн дүнгээр / | 571<br><br>571 | 971<br><br>971 | 80.0 | ААНБ-149.0 | БОНХОБТХ ГХБХБГ | Сумдын ЗДТГ Мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд | ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/1969 дугаар албан бичгээр 2025 онд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа зайлшгүй хийлгэх шаардлагатай 1122 иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад холбогдох эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэн дүгнэлтийг 2025 оны 11 дүгээр сард цахимаар илгээж газар эзэмших гэрээний үүргээ биелүүлэн хамтран ажиллах талаар https://erdenet.gazar.gov.mn/ байгууллагын сайтад байршуулан мэдэгдэл, мэдээлэл хүргүүлэн ажилласан. Энэ ажлын хүрээнд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаас газрын удирдлагын цахим системд илгээсэн хот тосгон, бусад суурин газар болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа нийт 797 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 249.18 га газрын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд нь баталгаажуулан ажилласан. Нийт өссөн дүнгээр 1368 нэгж талбарыг газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаанд хамруулсан.<br>Эдгээр захиалгат газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд хамрагдсан 1358 нэгж талбарын эздэд газрын хянан баталгааны дүгнэлтээр гарч буй нийтлэг алдаа, зөрчлийг арилгах талаар цаг тухайд нь заавар зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. | 100% |
| 106 | | 3.1.1.7.2. Хот, тосгон, бусад суурин газар, тариалан болон атаршсан газар, бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 407.0 | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамруулсан талбай, га /Тухайн жилээр/ | - | Хот суурин 4831.65 | 106.0 | - | БОНХОБТХ ГХБХБГ | Мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд | Орхон аймгийн Баян-Өндөр сумын хот тосгон, бусад суурин газрын нийт 4831.65 га талбайд “Газрын төлөв байдал, чанарын улсын төлөвлөгөөт хянан баталгааг” 106.0 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийлгэхээр ажлын даалгавар боловсруулан ГЗБГЗЗЕГ-аар хянуулж Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүргүүлсэн.<br>Баян-Өндөр сумын ЗДТГ-аас хот, тосгон, бусад суурины газарт газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх ажлыг гүйцэтгүүлэхээр нээлттэй тендерийн сонгон шалгаруулалт зарласан боловч Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар зарлагдсан тендер хүчингүй болсон. 2026 онд дахин орон нутгийн төсөвт тусгах саналыг Баян-өндөр сумын Засаг даргад 2025 оны 10 дугаар сарын | 10% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | 14-ний өдрийн 815 дугаар бичгээр хүргүүлэн ажилласан. | |
| 107 | 3.1.1.8. Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийн үйл ажиллагааг хангана. | 3.1.1.8.1. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, газрын төлбөрийг татварын системд хамруулж, газрын төлбөрийг 90-ээс дээш хувь төвлөрүүлэх. | 2025-2028 | - | - | Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, газрын төлбөр, татварыг системд хамруулсан нэгж талбарын тоо /Өссөн дүнгээр/<br><br>Төвлөрүүлсэн төлбөрийн гүйцэтгэлийн хувь | 24574<br><br>99.6 | 24874<br><br>99.6 | - | - | ГХБХБГ Сумдын ЗДТГ | ТГ | Газрын үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулах ажлын хүрээнд 2025 онд Баян-Өндөр суманд 16986 иргэнд 33.4 сая төгрөг, Жаргалант суманд 567 иргэнд 162.0 мянган төгрөгийн ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэсэн. Нийт аймгийн хэмжээнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй 25584 нэгж талбарт газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж татварын системд илгээсэн.<br>Газрын кадастрын системд бүртгэгдсэн Баян-Өндөр сумын 6683 нэгж талбарт 27957.4 сая төгрөгийн ногдуулалт хийж 7701 нэхэмжлэх, Жаргалант сумын 1348 нэгж талбарт 550.62 сая төгрөгийн ногдуулалт хийж 1412 нэхэмжлэхийг тус тус үүсгэн татварын нэгдсэн системд илгээсэн. Тайлант онд орон нутгийн төсөвт газрын төлбөрийн орлогоос 31505.1 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсан бөгөөд газрын төлбөрийн орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28914.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, гүйцэтгэл 91.8 хувьтай байна. | 100%<br><br>0<br><br>Дундаж 50% |
| 108 | | 3.1.1.8.2. Газрын биржийн үнийн судалгааг гаргаж цахим системд хамруулах | 2025-2028 | - | - | Нэгж талбарын тоо /Өссөн дүнгээр/ | 5480 | 6180 | - | - | ГХБХБГ | Сумдын ЗДТГ | Газрын биржийн www.mle.mn цахим системээс гэр бүлийн хэрэгцээ, худалдаа үйлчилгээ, ХАА-н үйлдвэрлэл, ХАА-аас бусад үйлдвэрлэлийн гэсэн газар ашиглалтын 4 зориулалтаар бүртгэгдсэн үнийн мэдээний тоо, дундаж үнэ, хамгийн бага үнэ, их үнэ, үнийн мэдээний эзлэх хувь, төрөл, эх сурвалж, эрхийн төрлийн тоон мэдээллүүдийг авах боломжтой. Мөн иргэд аж ахуйн нэгж байгууллагууд улсын хэмжээнд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаар мэдээ мэдээлэл авч, дуудлага худалдаанд цахим хэлбэрээр нээлттэй оролцож байна. Аймгийн хэмжээнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 1030, өссөн дүнгээр 6510 нэгж талбарын үнийн мэдээг газрын биржийн www.mle.mn цахим программд бүртгээд байна. Газрын биржийн цахим системийг www.erdenet.gazar.gov.mn болон олон нийтийн цахим сүлжээгээр болон нээлттэй хаалганы өдрөөр 630 гарын авлага бэлтгэн иргэдэд сурталчлан ажилласан байна. | 100% |
| **Үйлдвэрлэл, уул уурхай** | | | | | | | | | | | | | | |
| 3.2.Олон тулгуурт эдийн засагтай үйлдвэрлэгч хот болон хөгжинө. | | | | | | | | | | | | | | |
| *3.2.1.Уул уурхай, үйлдвэрлэлийн салбарыг хослуулан хөгжүүлж импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэл хөгжинө.* | | | | | | | | | | | | | | |
| 109 | 3.2.1.1. Оюутын орд болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, | 3.2.1.1.1. Оюут ордын талбайд нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж, | 2025-2028 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | 11006.1 | Хайгуулын ажлын гүйцэтгэлийн хувь | 20 | 80 | 10006.1 | 10006.1 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Оюутын ордын нарийвчилсан хайгуулын ажлыг 2023 онд эхлүүлж, газрын доорх усны ундарга, түвшин бууралтыг болон усны химийн найрлагын зарим үзүүлэлтийг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлж, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ. | нөөцийг өсгөх | | | | | | | | | | | газар дээр нь тогтоох хээрийн сорил туршилтын ажлууд хийгдсэн. Цооногуудад хийсэн хээрийн туршилт судалгааны ажлын үр дүнг AquiferTestPro13, Aqusolvi программ хангамжуудыг ашиглан хийсэн ба хайгуулын урьдчилсан үр дүнгээр 0.32 хувийн зэсийн агуулгатай 357.0 сая.тн хүдрийн нөөцтэйг тогтоогоод байна. Оюут ордыг түшиглэн жилд 5-10 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулж байгаа ба Энэ тооцооллоор авч үзвэл Оюут ордыг 30-35 жил ашиглана. Хайгуулын ажил 100 хувь хийгдэж дууссан байна. | |
| 110 | | 3.2.1.1.2. Стратегийн ордын талбайд хамаарах хэтийн төлөв бүхий хэсгүүдэд эрэл хайгуулын ажил гүйцэтгэх, эрэл хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх. | 2025-2028 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | 75000.0 | Эрэл хайгуулын ажлын гүйцэтгэлийн хувь | - | 10 | 12000.0 | 12000.0 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Эрдэнэтийн овоо ордын Баруун-Хойд, Төвийн хэсгүүдэд захын агуулгыг оновчлох, нөөцийг шинэчлэн тооцоолох, Оюутын хэсгийн нарийвчилсан хайгуулыг эцэслэн, ашиглалтад бэлтгэх, Эрдэнэтийн стратегийн ордын талбайн хүрээнд хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинэ нөөц тогтоох ажил үргэлжлэн хийгдэж байна. Одоогийн байдлаар хайгуулын ажил 10 хувьтай явагдаж байна.<br>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Стратегийн ордын талбайд хамаарах хэтийн төлөв бүхий хэсгүүдэд эрэл хайгуулын ажил гүйцэтгэх, эрэл хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх төслийн төсвийг батлуулан, худалдан авах ажиллагааны хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтыг 2026 онд зарлахаар төлөвлөсөн. | 100% |
| 111 | 3.2.1.2. Үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн машин үйлдвэрийн бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэл, тоног төхөөрөмж ба бусад | 3.2.1.2.1. Кабель утасны үйлдвэр барьж байгуулах. | 2025-2028 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ Гадаад, дотоод зээл тусламж | 75990.6 | Төслийн гүйцэтгэлийн хувь | - | 10 | 18331.2 | 18331.2 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Кабель утасны үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Техник, технологийн зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар, АҮЭБЯ-ны ЭБМЗ-ийн 2025 оны 08 дугаар 12-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, дэмжигдсэн. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийг тусгаж, журмын дагуу архивд хүлээлгэж өгөх ажил хийгдэж байна. Төслийн гүйцэтгэлийн хувь 10 хувьтай байна. | 100% |
| 112 | төрлийн металл, резин хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төслийг хэрэгжүүлнэ. | 3.2.1.2.2. "Эрдэнэт Машин" цогцолбор үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэх” (ЗМЗ-2) | 2025-2028 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ Гадаад, дотоод зээл тусламж | 708900.0 | Төслийн гүйцэтгэлийн хувь | - | 3 | 3216.0 | 3216.0 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн УТП-24-02-01 дугаартай дүгнэлтээр “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл дэмжигдэж ТЭЗҮ-ийг боловсруулж дуусгасан. Монгол улсын аж үйлдвэрийг хөгжүүлэх стратегийн хүрээнд машин үйлдвэрлэлийн кластер байгуулах | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | техник эдийн засгийн үндэслэл боловсруулах" төсөл буюу Засвар механикийн завод-II төслийн гүйцэтгэгчээр "Ди Ди Эй Жи" ХХК шалгаран графикт хугацааны дагуу төслийн эхлэлтийн болон явцын нэгдүгээр тайланг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн "Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах ажлын хэсэг байгуулах" шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэгт тайлан танилцуулж хүлээлгэн өгсөн. | |
| 113 | 3.2.1.3. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын шинэ сан байгуулах төслийг хэрэгжүүлнэ. | 3.2.1.3.1. Шинэ хаягдлын сан байгуулах төслийг хэрэгжүүлэх. | 2025-2028 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | 700000.0 | Төслийн гүйцэтгэлийн хувь | - | 1% | 5000.0 | 5000.0 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ | Баяжуулах үйлдвэрийн хаягдлын шинэ санг байгуулах 7048 га газрын асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн. Төслийн суурь судалгааны ажил 90 хувь, урьдчилсан ТЭЗҮ, зураг төслийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна | 100% |
| 114 | 3.2.1.4. Жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн чадавхыг сайжруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ. | 3.2.1.4.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 3800.0 | Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 13 | 15 | 600.0 | ЖДҮХС-1000.0 ХХС-422.7 ОНТ-1025.0 Арилжааны банк-1413.0 | БОНХОБТХ ХХААГ | - | 2025 онд ЖДҮХС-аас 10 төсөлд 1.3 тэрбум төгрөг, Атар-4 тариалангийн тогтвортой аяны хүрээнд 4 аж ахуйн нэгж, 4 иргэнд 884.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 хоршоонд 422.7 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 6 хоршооны 16 малчин өрхөд 529.0 сая төгрөгийн зээл олгосон. Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд ХААН, Капитрон банкнаас тайлант хугацаанд 12 иргэн, аж ахуйн нэгжид 725.0 сая, нийт 41 иргэн, аж ахуйн нэгж 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. | 100% |
| 115 | | 3.2.1.4.3.Ахуй үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 68.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /тухайн жилээр/ | 6 | 3 | 8.0 | ОНТ-8.0 | БОНХОБТХ ХХААГ | Сумдын ЗДТГ Мэргэжлийн холбоод | "Монголын Үсчин Гоо Сайхны Хөгжил – 2030" чуулганд 14 аймаг, орон нутгийн 10 гаруй холбоод, 250 гаруй мэргэжилтэн хамрагдаж, 2030 он хүртэлх тогтвортой хөгжих хөгжлийн стратегийг боловсруулан гишүүнчлэлээ нэмэгдүүлж, хамтран ажиллахаар болсон. Мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх 2 удаагийн сургалтад 64 хүн хамрагдаж "Бикини ваксны-ONE TOUCH" сургалт, дэлхийн аварга, Алтан цомын эзэн, Дэлхийн дасгалжуулагч МУ-ын мастер оролцож туршлагаасаа хуваалцсан. Ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүргэхээр "Явуулын ахуйн үйлчилгээ"-г Жаргалант сумын иргэдэд зохион байгуулж үс засах, хумс засал, сормуус суулгах, гутал засвар, цахилгаан бараа засварын чиглэлээр давхардсан тоогоор 100 гаруй хүнд үйлчилгээ үзүүлж 1.8 сая төгрөгийн орлого олсон. Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах холбоо, Оёдлын холбоотой хамтран "Баяр наадмын гангараа" үзэсгэлэн худалдааг 2 өдөр А.Амарын талбайд зохион байгуулж, үндэсний хувцас, гоёл чимэглэл, баяр наадамтай | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | холбогдуулан урласан урлаачдын бүтээлийг нэг дороос худалдан авах боломжийг бүрдүүлэн ажилласан.<br>“Уран гар-2025” уралдаанд давхардсан тоогоор 40 гаруй урлаач оролцож шилдгүүдээ шалгаруулж, хамтран ажилласан байна. | |
| 116 | | 3.2.1.4.4. Чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 100.0 | “Баталгааж сан бүтээгдэхүүн, үйлчилгээ”, “Аюулгүйн тэмдэг” авсан бүтээгдэхүүн ий нэр төрлийн тоо /тухайн жилээр/ | 7<br>-<br> | 8<br>3 | 25.0 | - | СХЗХ | БОНХОБТХ ХХААГ | 2025 онд талх, нарийн боовны 1, хэрчсэн гурилын 1, мал төхөөрөх болон мах боловсруулах 1, нийт 3 үйлдвэрийн бүтээгдэхүүнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэг хэрэглэх эрх олгосноор “Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэгтэй 16 байгууллагын 42 нэр төрлийн бүтээгдэхүүн бий болсон. “Баталгаажсан үйлчилгээ” тэмдгийг хүнсний чиглэлийн 8 аж ахуйн нэгжийн 9 үйлчилгээнд олгосноор аймгийн хэмжээнд "Баталгаажсан үйлчилгээ” тэмдэгтэй 16 аж ахуйн нэгжийн 19 үйлчилгээ бий болсон.<br>Засгийн газраас баталсан “Техникийн зохицуулалт”-ын шаардлагыг хангаж аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг бүхий мал төхөөрөх, боловсруулах 3, мах, махан бүтээгдэхүүний 6, сүүний 2, бялуун бүтээгдэхүүний 6, нийт 17 иргэн, аж ахуйн нэгжийн цех, үйлдвэр байгаагаас тохирлын үнэлгээнд хамрагдсан "Жүр үр" ХХК аюулгүйн тэмдгийг 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд, “Баяжуулагч-Одод" ХХК аюулгүйн тэмдгийг 7 нэрийн сүү, сүүн бүтээгдэхүүнд хэрэглэх эрх авч, нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 11.7 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна. | 100% |
| 117 | | 3.2.1.4.5.”Эрдэнэт эд үйлдвэрлэв” төвийн барилгыг ашиглалтад оруулж, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 4082.0 | Барилгын ажлын гүйцэтгэл. хувь<br><br>Дэмжсэн бизнес эрхлэгчийн тоо | 0<br><br>- | 50<br><br>- | 3582.0 | ОНТ-3582.0 | БОНХОБТХ ХХААГ | Сумдын ЗДТГ Мэргэжлийн холбоод | “Эрдэнэтэд үйлдвэрлэв” төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Сэнгүн констракшн” ХХК ажиллаж байгаа бөгөөд барилгын ажил 70 хувьтай хийгдэж байна. | 100% |
| 118 | 3.2.1.5. Бүсчилсэн болон орон нутагт хэрэгжүүлэх татварын бодлогыг сурталчлан, татвар төлөгчийн эрсдэлийн түвшнээс хамааруулан сегментийн стратегийг хэрэгжүүлж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжинэ. | 3.2.1.5.1. Татвар төлөгчдөд сегментийн стратегийн чиглэлээр сургалт явуулах | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 75.0 | Сургалт, мэдээллийн тоо | 50 | 60 | 15.0 | ОНТ-14.0 | ТГ | СТСХ | 2025 онд танхимаар 48, ажлын байранд 52, цахимаар 2 удаа, нийт 102 удаагийн сургалт зохион байгуулж, тус сургалтуудад давхардсан тоогоор дунд сегментийн 8, жижиг сегментийн 383, бичил сегментийн 911, хувь хүн 5190, нийт 6492 татвар төлөгчийг хамруулсан.<br>Татварын хууль тогтоомж, журам, заавруудыг олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор орон нутгийн “ETV”, “Тусгал” 2 телевизтэй хамтран давхардсан тоогоор 38 удаагийн тодруулга ярилцлага, цаг үеийн мэдээ, 3 удаагийн ярилцах цаг нэвтрүүлэгт оролцож, нийтэд түгээсэн. Гэрэгтв, Erdenetnews.mn, Баян-Өндөр сум, | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | Улсын тэргүүний Жаргалант сум, Орхон аймгийн татварын газар, Хойд бүсийн татвар төлөгчид пэйж хуудсаар 401 төрлийн мэдээг 1391 удаагийн давтамжтай сошиал орчинд түгээж, давхардсан тоогоор 381969 орчим хүнд хүргэсэн байна.<br>“Орхон аймгийн татварын газар”, “Хойд бүсийн татвар төлөгчид” пэйж хуудсанд татварын хууль тогтоомжийн агуулга бүхий 69 видео, 88 бичвэр, нийт 401 пост оруулж, мэдээллийг түгээсэн.<br>Орон нутгийн төсвөөс орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэлд 6.0 сая төгрөг, сургалт сурталчилгаа, тараах материалын эх бэлтгэл, хэвлэлийн зардалд 8.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. | |
| 119 | | 3.2.1.5.2. Сегментийн стратегийг хэрэгжүүлж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 65.0 | Татварт хамрагдалтын хувь | 73.6 | 76.0 | 15.0 | - | ТГ | СТСХ | Татвар төлөгчийг мэдээллээр хангах, Татварын хуульд заасан хариуцлагыг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант хугацаанд давхардсан тоогоор 26856 татвар төлөгчид масс мессеж илгээж, татварын тайлагнал, татварт хамралтыг дараах байдлаар нэмэгдүүлсэн. Үүнд:<br>Татварын ногдлын төлөлтийг жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 онд цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын хувьд 1487-аас 1386 буюу 93.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд 596-аас 489 буюу 82.0 хувь, үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 2488-оос 1894 буюу 76 хувь, төлбөр хураамжийн хувьд 14-өөс 14 буюу 100 хувь тус тус хамруулж, тайлант хугацааны байдлаар нийт гүйцэтгэл 87.8 хувьтай байна. | 100% |
| **Дэд бүтэц** | | | | | | | | | | | | | | |
| 3.3.Дэд бүтцийн хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдэнэ. | | | | | | | | | | | | | | |
| *3.3.1.Аймгийн хэмжээний эрчим хүч, инженерийн шугам сүлжээний 30-аас доошгүй хувийг шинэчилнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 120 | 3.3.1.1. Хотын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 3.3.1.1.1. Инженерийн шугам сүлжээг 2025-2028 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн тсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Батлагдсан төлөвлөгөө<br>Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт. хувь | - | Төлөвлөгөө батлагдсан байна. | | | ХЗА | БОНХОБТХ ГХБХБГ | Хотын инженерийн шугам сүлжээг 2024-2028 оны хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын саналыг хангагч байгууллагуудаас авч саналыг нэгтгэх ажил хийгдэж байна. Тус төлөвлөгөөг Эрдэнэт хотын 2045 он хүртэлх ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа боловсруулахаар ажиллаж байна. | 0 |
| 121 | | 3.3.1.1.2. Гэр хорооллын гудамж хооронд инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлэн айл өрхийг дулаанд холбох нөхцөлийг бүрдүүлэх | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 6000.0 | Инженерийн шугам сүлжээнд холбогдсон гэр хорооллын өрхийн эзлэх хувь | 2% | 3% | 1100.0 | УТ-1990.0 ОНТ-1100.0 | БОНХОБТХ ХЗА | ГХБХБГ ЭУДТС ОНӨХК ХББЗА | 2025 онд хангагч байгууллагууд болох "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК болон "ЭДЦС" ТӨХК нь дулааны 45, ус хангамж ариутгах, татуургын 35 техникийн нөхцөлийг олгосноор шинээр нийт 45 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага инженерийн шугам сүлжээнд холбогдсон байна. 2021 оноос он дамжин хэрэгжиж байгаа | 40.0% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | “Миний гэр-Бидний гудамж” төслийн хүрээнд Рашаант багт орон нутгийн төсвийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 УДТТ, дулаан, хэрэглээний халуун ус, цэвэр усны 5 хос, 503 метр шугам татах ажлыг гүйцэтгэж дууссан. 2025 онд орон нутгийн төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын 7 багт дулаан, цэвэр усны шугам барих ажлыг хийж, нийт 5.78 км урт төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Төслийн үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдсэн ч одоогийн байдлаар 308 айл өрх холбогдсон байна.<br>“Хайбрид гарден” амины орон сууцны жишиг төслийг хэрэгжүүлж Эрдэнэ багийн 3.4 га талбайд 37 айлын эрчим хүчний өндөр хэмнэлттэй амины орон сууцны анхны жишиг ногоон хотхон байгуулахаар орон нутгийн болон улсын төсвийн 1.99 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээний ажлыг “Хайбрид гарден” ХХК хийж гүйцэтгэлээ.<br>Мөн аймгийн хэмжээнд гэр хорооллын 1557 өрх цахилгаанаар, 24 өрх сэргээгдэх эрчим хүчээр халаалтаа шийдвэрлээд байна.<br>Ингэснээр одоогийн байдлаар гэр хорооллын нийт өрхийн 2.4 хувийг эзэлж байна. | |
| 122 | | 3.3.1.1.3. Ус дулаан хуваарилах төвүүдийг үл хамаарах схемд шилжүүлэх иж бүрэн ялтсан бойлер суурилуулах. | 2025-2026 | Орон нутгийн төсөв | 4200.0 | Шинэчлэлт хийгдсэн УДДТ-ийн тоо | 52ширхэг УДДТ-ийн тоноглол бүрэн шинэчлэгдсэн | 14 ширхэг УДДТ-ийн ялтсан бойлерыг шинэчилнэ. | 4200.0 | ОНТ-4200.0 | БОНХОБТХ ХЗА | ГХБХБГ ЭУДТС ОНӨХК ХББЗА | Орон нутгийн төсвийн 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5ш хамаарах схемтэй УДДТ-ийн тоноглол шинэчилж үл хамаарах схемтэй ялтсан бойлерыг суурилуулсан. | 35.7% |
| 123 | | 3.3.1.1.4. ЭДЦС ТӨХК-ний техникийн усны нөөц шугам шинээр барих. | 2025-2026 | Орон нутгийн төсөв | 5323.9 | 5.2км урттай ф320 мм ган хоолойг шинэчлэх | 5.2 км цэвэр усны шугамын ашиглалтын хугацаа дууссан | 5.2км ф320 мм ган хоолой шинээр суурилуулах | 5323.9 | ОНТ-4900.0 | БОНХОБТХ ХЗА | ГХБХБГ ЭДЦС ТӨХК ХББЗА | "ЭДЦС" ТӨХК-ийн техникийн усны нөөц шугам шинээр барих ажлыг 4.9 тэрбум төгрөгөөр 5.2км шугамыг гүйцэтгэж дууссан. Ингэснээр аваарын нөхцөл байдал үүссэн тохиолдолд дулааны тасалтгүй байх боломжийг бүрдүүллээ. | 100% |
| 124 | | 3.3.1.1.5. Орон сууцны УДДТ-ийн гадна инженерийн шугам сүлжээг шинэчлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 16000.0 | Инженерийн шугам сүлжээний хэмжээ /урт/ | 80.7км ИШСүлжээ | 14ш УДДТ-ийн 5718м | 9688.0 | ОНТ-27700.0 | БОНХОБТХ ХЗА | ГХБХБГ ЭУДТС ОНӨХК ХББЗА | Аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хийхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2025 онд аймгийн инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн ажлын хүрээнд нэн тэргүүнд хийхээр эрэмбэлэгдсэн, зайлшгүй шаардлагатай нийт 23 ажилд орон нутгийн төсвийн 27.7 тэрбум | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | төгрөгийг төсөвлөн ажилласнаар Баян-Өндөр сумын Зэст, Оюут, Уурхайчин, Бүрэнбүст, Хүрэнбулаг, Уртбулаг, Согоот, Рашаант, Шанд, Дэнж, Баянцагаан, Говил, Их залуу, Наран, Баянбулаг, Булаг, Жаргалант сумын Улаантолгой багт 14 нэр төрлийн ажил 100 хувь хийгдэж дууссан, 9 ажил 50-95 хувийн гүйцэтгэлтэй байна. Ингэснээр 2025 онд дулааны шугам 25.6км, бохир усны шугам 0.59км, цэвэр усны шугам 18.6км, холбооны 1.0км урт шугам шинэчлэгдсэн. | |
| 125 | 3.3.1.2. Хотын хэмжээнд үерийн хамгаалалтын далан сувгийн төлөвлөлтийг шинэчлэн боловсруулан шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж, ашиглалтыг сайжруулна. | 3.3.1.2.1. "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд үерийн сувгийг үе шаттай барьж ашиглалтад оруулах. | 2025-2028 | ЕСББанк | 10.3 сая доллар | Инженерийн хийцлэлтэй үерийн сувгийн урт, км /тухайн жилээр/ | 12.1 км суваг | 4 км | 3.5 сая доллар | 9.8 сая ам доллар Европын сэргээн босголтын банк | БОНХОБТХ Төслийн нэгж | ХЗА ОБГ ХТГ | Европын холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банкны 14.0 сая ам.долларын санхүүжилтээр /ЕСБХБ-ны 50 хувийн хөнгөлөлттэй зээл, Европын холбооны техникийн туслалцааны буцалтгүй тусламж 50 хувиар/ хэрэгжиж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн үйл ажиллагааг Үерийн эрсдэлийн менежментийг сайжруулах, 2025 оны 5 дугаар сарын 28-наас ажлыг эхлүүлж 2026 оны 9-р сард хийгдэж дуусхаар гэрээг байгуулсан.<br>Тус төслийн хүрээнд хүн амын суурьшлын дэд бүсэд борооны ус хадгалах 3, Эрдэнэт голын хөндийд 1, нийт 4 усан сан, 8 байршилд нийт 12.8 км-ын урттай төмөр бетон суваг бүхий үерийн даланг байгуулах ажлыг БНХАУ-ын төрийн өмчийн "Хунан Индастриал Экуйпмэнт Инсталэйшн компани" гүйцэтгэж байна.<br>Одоогийн байдлаар үерийн хамгаалалтын A сувгийн ажил 74.4%, B сувгийн ажил 95.8%, D сувгийн ажил 82%, E сугийн ажил 13%, H сувгийн ажил 70% - ийн гүйцэтгэгдэж нийт 3.8 км үерийн хамгаалалтын сугийг бариад байна. Мөн 1 усан сангийн ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна | 95,0% |
| 164 | | 3.6.1.1.3. Ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулж, техник технологийг шинэчлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 400.0 | Ургалтын хувь /өссөн дүнгээр/ | 88 | 89 | 100.0 | ОНТ-294.5 | БОГ | Сумдын ЗДТГ СДОА | Эрдэнэт голын эх, Эмнэлгийн арын зэрэг газруудад хийсэн ойжуулалт, Баян-Овоот уулын ойн зурвас зэрэгт хамгаалалтын хашаа барьж, Хүрэн булгийн амны хамгаалалтын хашаа сэргээн засварлаж, холбогдох газруудад нөхөн тарилтыг Сум дундын ойн анги, “Хөвөнтөн ой” ХХК-иар гүйцэтгүүлснээр дундаж ургалтыг 89 хувьд хүргэсэн байна. | 100% |
| 165 | 3.6.1.2. Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3.6.1.2.1. Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын */Гидрогеологи/* ажлыг хийж нөөцийг тогтоож, баталгаажуулах. | 2026-2028 | Орон нутгийн төсөв | 600.0 | Геологийн ажлын явц, хувь /өссөн дүнгээр/ | - | - | - | - | БОГ | БОНХОБТХ Сумдын ЗДТГ СГСГЗ | Газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын төслийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Шаардлагатай санхүүжилтийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөнд тусгуулсан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 166 | | 3.6.1.2.2. Газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 1700.0 | Байгуулсан хөв цөөрөм /өссөн дүнгээр/ | 2 | 3 | 350.0 | - | БОГ | Сумдын ЗДТГ СГСГЗ | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Арбулаг, Урт булаг, Ганц модтын аманд хөв цөөрөм байгуулах зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, холбогдох газруудаар баталгаажуулан аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн 3 удаа тендер сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан боловч оролцогч байхгүй тул 2026 оны төсөвт тусгуулан батлуулсан. | 0 |
| 167 | | 3.6.1.2.3. Газрын доорх усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох үүднээс газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 90.0 | Газрын доорх усны хяналтын бүрэн автомат багажны тоо /өссөн дүнгээр/ | 3 | 4 | 40.0 | ААНБ-ын хөрөнгө | БОГ | БОНХОБТХ ААНБ-ууд | Усны тухай хуулийн 6, 7 дугаар зүйлийн хэрэгжилтийн биелэлтийг хангаж газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, сүлжээг нягтруулах ажлын хүрээнд “Зэс Эрдэнийн хувь” ХХК-ийн үйлдвэрлэлийн талбайд байрлах газрын доорх усны хяналт-шинжилгээний 2 ш цооногт бүрэн автомат төхөөрөмж суурилуулан усны түвшин, температур, pH, эрдэсжилт, цахилгаан дамжуулалт, агаарын даралт зэргийг тогтмол хэмжиж байна. Ингэснээр Газрын доорх усны хяналтын бүрэн автомат 5 төхөөрөмж ажиллаж байна. | 100% |
| 168 | | 3.6.1.2.4. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Хувийн хэвшил | 159.8 | Усыг дахин ашиглаж буй байгууллагын тоо /өссөн дүнгээр/ | - | 2 | 39.8 | ОНТ-30.0 | БОНХОБТХ БОГ | Сумдын ЗДТГ СГСГЗ | Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй автомашин угаалгын газруудад Усны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгах, хаягдал ус дахин боловсруулах шийдлийг тодорхойлох судалгааны ажлыг аймгийн Байгаль орчны газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК хамтран зохион байгууллаа.<br>Хяналт шалгалт, судалгааны ажлын хүрээнд нийт 27 автомашин угаалгын газар хамрагдсан бөгөөд инженерийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 22, усны асуудлаа зөөврөөр шийдвэрлэдэг 5 газар ажиллаж байгаагаас 5 авто угаалгын газар 259тн саарал усыг гадна угаалгад дахин ашиглаж байна.<br>Хаягдал ус дахин боловсруулж хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг бодлогоор дэмжих ажлын хүрээнд катодын зэс боловсруулах "Гал сэнтий" ХХК, "Ачит-Ихт" ХХК-иуд ус цэвэршүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/893 дугаар захирамжаар Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн 6 аж ахуйн нэгж, байгууллагад 27.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |
| 169 | 3.6.1.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ. | 3.6.1.3.1. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлэх. | 2025-2028 | Хувийн хэвшил | - | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ /га/ | 43.9 | 49.9 | - | ААНБ-ын хөрөнгө | БОГ | Уул уурхайн ААНБ-ууд | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6 аж ахуйн нэгж, байгууллагын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг тусгуулан БОУАӨЯ-аар батлуулан ажиллаж, хавар, намрын бүх нийтээр мод тарих ажлаар Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-аар орон нутгийн тусгай хамгаалалтай Баян-Өндөр хайрхны зүүн талын энгэрт 10 га, Эрдмин ХХК-иар Хангал голын голдирол дагуу 2 га, Ачит-Ихт ХХК-иар Хангал голын голдирол дагуу 6 га, Зэс-Эрдэнийн хувь ХХК үйлдвэрийнхээ гадна талын сайжруулсан шороон авто зам дагуух ногоон зурваст 1.43 га, Гал-Сэнтий ХХК -иар гурван замын ногоон зурваст 0.5 га-д, Очир төв ХХК-иар Хангал голын голдирол дагуу 0.5 га, Сархиа уулын урд энгэрт 1 га талбайд тус тус биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлж 2025 онд 21.43 га, нийт өсөн дүнгээр 65.33 га талбайд мод бут сөөгийг тариулж, усалгаа арчилгааг тогтмол гүйцэтгүүлэн ажилласан. Нийт тарьсан модны ургалтын хувь 85 хувьтай ургаж байна. | 100% |
| 170 | 3.6.1.4. Орчны чанар, төлөв байдлыг тодорхойлж, “Цэвэр агаартай хот” төслийг хэрэгжүүлэн орчны бохирдлыг бууруулна. | 3.6.1.4.1. Агаар, ус, хөрсний чанарын судалгааг тогтмолжуулж, агаарын чанарын хяналтын цэг нэмж байгуулан цахимжуулах. | 2025-2028 | Улсын төсөв Төсөл хөтөлбөр | Батлагдсан төсвийн хүрээнд | Хяналт шинжилгээний давтамж.тоо /тухайн жилээр/<br><br>Хяналтын цэгийн тоо /Өссөн дүнгээр/ | -<br><br>2 | Агаар 1282 Ус 80<br><br>3 | Батлагдсан төсвийн хүрээнд | | УЦУОШТ | БОГ | 2025 онд агаарын хяналт шинжилгээ 2436 удаа, усны хяналт шинжилгээ 80 удаа, хөрсний хяналт шинжилгээ 33, агаар дахь PM10, PM2.5 тоосонцор 365 удаагийн давталттай тус тус хийгдсэн байна.<br>Монгол улсын Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, БНСУ-ын Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар 21 аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийг агаарын чанарын автомат станцтай болгох ажлын хүрээнд үргэлжилж байна. Уг автомат станц нь Орон нутагт агаарын чанарыг 2-3 үзүүлэлтээр үздэг бол Орхон аймагт анхны 6 үзүүлэлтээр үздэг автомат станцыг 2025 оны 05 дугаар сарын 27-нд шинээр суурилуулсан. Ингэснээр агаарын | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | чанарыг хэмжих 3 автомат станцтай болж, 3 цэгээс агаарын чанарын хяналтыг хийж байна. Тус автомат станц нь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрс төрөгчийн дутуу исэл, PM10 тоосонцор, PM2,5 тоосонцор, Озон гэх мэт байгаль орчны суурь үзүүлэлтүүдийг 24 цаг, 365 хоног тасралтгүй хэмжих хүчин чадалтай.<br>Хяналт шинжилгээний үр дүнг цахим сайтууд болон и-оффис системд тухай бүр оруулж иргэд, аж ахуйн нэгжид үйлчилж байна. | |
| 171 | | 3.6.1.4.2. Хүлэмжийн хийн ялгарлыг тооцож, эх мэдээллийг тогтмол шинэчлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Гадаад төсөл хөтөлбөр | - | Хүлэмжийн хийн ялгарлыг тооцох | - | 1 | - | | БОНХОБТХ | ХЗА<br>БОГ<br>ХХААГ<br>УЦУОШТ<br>Статистикийн хэлтэс | Байгаль орчны салбарын байгууллагуудын албан хаагчдад хүлэмжийн хий, карбон кредитийн зах зээлийн талаар НҮБХХ-тэй хамтран сургалт зохион байгуулсан.<br>Орхон аймгийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарал шингээлтийг тооцоолох зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. 2026 оны төсөвт тусган батлуулж зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж хүргүүлсэн. | 0 |
| 172 | | 3.6.1.4.3. Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах “Цэвэр агаартай хот” төсөл хэрэгжүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв Гадаад төсөл хөтөлбөр | 2200.0 | Төслийн хэрэгжилтийн хувь /өссөн дүнгээр/ | - | 25% | 1600.0 | ОНТ-23300.0 | БОНХОБТХ | ХЗА<br>БОГ | Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар “Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичсэн. Цэвэр агаартай хот төслийн хүрээнд эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн чип багц бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэр гэр хорооллын янданг 63-аар бууруулллаа.<br>“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багийн нийт 1245 өрх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдсэнээс 308 өрх холбогдсон. Төслийн хэрэгжилт 30 хувьтай байна. | 100% |
| 173 | | 3.6.1.4.4. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад хувийн хэвшилтэй | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшлийн | 90.0 | Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ /тн, өссөн дүнгээр/ | 1640 | 1840 | - | ААНБ-ын хөрөнгө | ХЗА<br>ХТГ | Сумдын ЗДТГ<br>БОГ<br>Иргэн, ААНБ-ууд | “Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" НҮТББ-тай хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 447 тн хог хаягдлыг цуглуулан төвлөрүүлж | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллах | | хөрөнгө оруулалт | | | | | | | | | Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан.<br>Мөн 10 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын 573.291 тн аюултай хог хаягдал, 533 ширхэг ашиглалтаас гарсан дугуй, ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэн өгч устгууллаа. | |
| 174 | | 3.6.1.4.5. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг сайжруулж, ландфиллын байгууламжийг үе шаттайгаар байгуулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөр | 1550.0 | Ажлын гүйцэтгэл. хувь /өссөн дүнгээр/ | 0 | 25% | 350.0 | | БОГ ХЗА | БОНХОБТХ Баян-Өндөр сумын ЗДТГ ХТГ | Төвлөрсөн суурин газрын хог хаягдлын нэгдсэн цэгт ландфилл байгуулах жишиг зураг төсвийг газар хөдлөлтийн 6 балл, 7-8 балл, 9 баллын ангиллаар БОУАӨЯ-ны зардлаар гүйцэтгүүлсэн бөгөөд жишиг зураг төсвийг орон нутгийн онцлогт тохируулан сайжруулж, ТЭЗҮ хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөнд тусгуулсан.<br>“Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийн хүрээнд иж бүрэн авто пүү суурилуулагдах бөгөөд ландфиллд булагдах хог хаягдлын хэмжээг бодитоор тогтоох боломж бүрдэнэ. Нийт ажлын гүйцэтгэл 25 хувьтай байна. | 100% |
| 175 | | 3.6.1.4.6. Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах . | 2025-2028 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 85% | 87% | - | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын зардал | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | БОНХОБТХ БОГ | Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг хүрээнд Хаягдлын аж ахуйн элстэй 1432 га хуурайшилттай талбайн 85 хувийг технологийн 4 төрлийн аргаар норголт хийж, тоосны дэгдэлтийг бууруулж байна. Шинэ хаягдлын аж ахуй байгуулах ажлын суурь судалгааны ажил 100 хувь, ТЭЗҮ, зураг төслийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Тоосны тархалтын зонхилох 3 чиглэлийн 121 га талбайд 5 төрлийн 1.8 сая.ш мод, бутыг тарьж, арчлан ургуулж байна.<br>Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд Говил, Баянцагаан багийн Вокзалын хэсэг, Гаалийн газар, Эрдэнэт өртөө, Жаргалант сумаас нийт 500 иргэнийг хамруулж, зөвлөгөө өгсөн байна.<br>Тоосны автомат 2 станцын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, дүнг www.agaar.mn сайтад оруулж байна.<br>Сургалт мэдээллийн хүрээнд ЕБС-ийн 120 сурагчдад сургалт, 35 иргэнд хаягдлын аж ахуйн танилцуулга, 2 удаа тайлангийн өдөрлөг, 6 удаа тоосжилттой бүсийн иргэдэд нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгуулан ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | Хөтөлбөрийн хэрэгжилт 2025 оны гүйцэтгэлээр 89.6 хувьтай байна. | |
| 176 | | 3.6.1.4.7. Хөрсний бохирдолыг бууруулах ажлыг зохион байгуулах | 2025-2028 | Орон нутгийн төсөв, хувийн хэвшил | 900.0 | Хөрс бохирдуулагч эх үүсвэрийн тоо | 14660 | 14560 | - | БХАХЗ-аас 350.0 | БОГ Сумдын ЗДТГ | БОНХОБТХ Статистикийн хэлтэс | Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого, судалгааны ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, нийт 14194 нүхэн жорлонг бүртгэлжүүлж, 2028 он хүртэл нүхэн жорлонгийн тоог 20 хувиар бууруулах төлөвлөгөө гарган баталгаажуулж, БОУАӨЯ-нд хүргүүллээ.<br>Тооллогоор бүртгэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эзэмшлийн 11 нүхэн жорлонг өөрчлүүлэхээр Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагуудыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн. “Гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэх” БОАЖЯ/202202080 тоот гэрээний дагуу Баян-Өндөр сумын Даваат, Шанд багт “Н ЭЙ БИ” ХХК-ийн хэрэгжүүлсэн 1000 эко ариун цэврийн байгууламж барих ажлын дутуу хийгдсэн 275 айлын бүхээгийн ажлыг гүйцэтгүүлж, хүлээн авлаа. Нийтийн эзэмшлийн талбайд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт голын голдирол дагуу Цэнгэлдэх хүрээлэнгийн ар талд нэг дор 6 хүн үйлчлүүлэх хүчин чадалтай нийтийн ариун цэврийн байгууламжийг барьж, ашиглалтад оруулсан байна. | 100% |
| 177 | | 3.6.1.4.8. Био хог хаягдлыг дэвшилтэт арга технологиор боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр | 3000.0 | Зураг төслийг боловсруулах<br><br>Үйлдвэрлэлийн ажлын гүйцэтгэл. хувь | -  | Судалгаа хийх<br><br>- | - | | МЭГ | Сумдын ЗДТГ ХХААГ БОГ ЭМГ ШУТП | Орхон аймагт жилд дунджаар 30000–35000 тонн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал үүсдэг бөгөөд үүний 60 орчим хувь нь органик гаралтай (хүнсний хаягдал, малын гаралтай хаягдал, модны үлдэгдэл) байна. Органик хог хаягдал нь бохир үнэр тархуулах, хөрс, ус, агаар бохирдуулах, нян, вирус, шимэгчийн голомтыг үүсгэх, хүлэмжийн хийн (метан) ялгарлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Биогазын станц байгуулах нь байгаль орчинд үзүүлэх нүүрстөрөгчийн ялгарлыг жилд 300–400 тн-оор бууруулж органик хог хаягдлын дахин боловсруулалтыг 30–40 хувьд хүргэх юм. Иймд био хог хаягдлыг дэвшилтэт технологиор боловсруулах биостанц байгуулах судалгаа хийж төсөл боловсруулан 2025 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан “Хойт бүс-Эрдэнэт 2025” эдийн засгийн форумын үеэр оролцогчдод танилцуулсан. | 0 |
| 178 | | 3.6.1.4.9. Хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэрийн туршилт тохируулгыг хийж, үйл ажиллагааг жигдрүүлэх. | 2025-2026 | Орон нутгийн төсөв | | Хог ангилан ялгах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл. хувь<br><br>Туршилт | 70% | 100% | - | - | ХЗА ХТГ | БОНХОБТХ Сумдын ЗДТГ ХББЗА | ППЭйч Мелиорекс компанийн гүйцэтгэж байгаа хатуу хог ангилах үйлдвэрийн барилгын угсралтын ажил дууссан, дотор заслын ажил 90 хувь, гадна тохижилт, зам талбайн ажил 90 хувь, халаалтын ажил 90 хувь, агаар сэлгэлтийн ажил 80 хувь, цэвэр бохир усны ажил 90 хувь, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлгийн ажил 90 хувь, | 66.7% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохируулга хийж, үйл ажиллагааг жигдрүүлэх | - | - | | | | | холбоо дохиоллын ажил 90 хувь, гадна цахилгаан хангамжийн ажил 90 хувь, гадна гэрэлтүүлгийн ажил 90 хувь, нийт гүйцэтгэл 90 хувьтай байна. | |
| 179 | 3.6.1.5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, байгальд ээлтэй хэмнэлттэй ногоон технологийг бодлогоор дэмжинэ. | 3.6.1.5.1. Уур амьсгалын өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар хүүхэд, өсвөр үе, залуучуудад чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 35.0 | Нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүүхэд залуучуудын тоо /Тухайн жилээр/ | - | 500 | 5.0 | - | БОГ | БГ СУАЖЗГ ТББ-ууд | Уур амьсгалын өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар иргэд олон нийтэд таниулах зорилгоор Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд байгаль орчны салбарын байгууллагуудын нэгдсэн өдөрлөгийг “Хүн бүр байгалиа хамгаалъя” уриан дор 2 удаа зохион байгуулж ажиллалаа. Нэгдсэн өдөрлөгт аймгийн БОГ, УЦУОШТ, СДОА, СГСГЗ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын байгаль орчин, ногоон хөгжлийн хэлтэс, Ачит-Ихт ХХК, Эрдмин ХХК, Зэс эрдэнийн хувь ХХК, Гал сэнтий ХХК, ойн санг гэрээгээр эзэмшиж буй ойн нөхөрлөлүүд оролцож, нийт 16 төрлийн 1600 орчим гарын авлага, ном товхимол, заавар зөвлөмж, тараах материалыг бэлтгэн 350 гаруй иргэд, 11 аж ахуйн нэгж, байгууллагуудад заавар, зөвлөгөө өгч, гарын авлага материалаар хангаж, сурталчлан ажилласан.<br>Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 7-10 хүртэлх, 8 ангийн нийт 180 сурагчид болон багш, удирдлагуудад “Ойн генетик нөөцийн төв”-ийн үйл ажиллагаа болон “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаарх танилцуулга, сургалт, мэдээлэл өгөх арга хэмжээг 2025 оны 05, 10 дугаар саруудад тус тус зохион байгуулан ажилласан байна. | 100% |
| 180 | | 3.6.1.5.2. Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлэхэд иргэд, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Гадаад төсөл, хөтөлбөр | 80.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /тухайн жилээр/<br><br>Хамтран ажилласан иргэн, ААН-ийн тоо /тухайн жилээр | 1<br><br>1 | 2<br><br>5 | 20.0 | | БОНХОБТХ ХЗА | Сумдын ЗДТГ БОГ ХББЗА | “Хойд бүс Эрдэнэт-2025” эдийн засгийн форум, “Ногоон технологи” гадна талбайн үзэсгэлэнг А.Амарын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэнд байгальд ээлтэй, ногоон технологийг дэмжих чиглэлээр “Ногоон” бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгож буй ногоон зээлийн үйлчилгээг үзүүлдэг 4 банк, 1 ББСБ-ыг оролцуулж, мэдээлэл өгч ажиллалаа.<br>Гадна талбайн ногоон технологийн үзэсгэлэнд нийт 26 байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд ногоон технологи, бүтээгдэхүүнээ танилцуулсан ба нийт 4238 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.<br>Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэх зорилгоор “Галсэнтий” ХХК-тай хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зохион байгуулсан.<br>2025 онд Орхон аймагт ХААН банк 15 иргэн, аж ахуйн нэгжид 2.6 тэрбум төгрөг, Төрийн банк 3 иргэн, аж ахуйн нэгжид 700 сая төгрөг, ХХБ 2 иргэнд цахилгаан автомашины 51.0 сая төгрөгийн ногоон зээлийг олгосон байна. | |
| 181 | | 3.6.1.5.4. Цахилгаан машины хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор цэнэглэх станцыг байгуулахад хувийн хэвшлийг дэмжих. | 2025-2028 | - | - | Цэнэглэх станцын тоо /Өссөн дүнгээр/ | 1 | - | - | | БОНХОБТХ | ХЗА ГХБХБГ АТТөв | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| **Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл** | | | | | | | | | | | | | | |
| 3.7.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, аялал жуулчлалаас орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөж нэмэгдэнэ. | | | | | | | | | | | | | | |
| *3.7.1.Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлал хөгжиж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 182 | 3.7.1.1.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэн сурталчлах ажлыг олон талын оролцоотой зохион байгуулна. | 3.7.1.1.1. Соёлын биет болон биет бус өв, ёс заншил, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 3 арга хэмжээ<br><br>216 | 4 арга хэмжээ<br><br>400 | 6.0 | ОНТ-8.5 | СУАЖЗГ | НБХ | Тайлант хугацаанд аймгийн СУАЖЗГ-аас "Өвөг Урианхай" ТББ, түүх судлалын "Өнөд оршихуйн бэлчир" ТББ-тай хамтран "Урианхай түмний түүх, өв соёл лекц, хэлэлцүүлэг"-ийг зохион байгуулж энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид, урианхай угсаатан 300 гаруй иргэд оролцож урианхай түмний соёлын өвийг сурталчлах олон нийтэд сурталчилсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор явагдсан "Монгол дархны уламжлал, шинэчлэл" анхдугаар чуулганд Орхон аймгаас 4 өвлөн уламжлагчийг оролцуулж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлсэн байна. Үндэсний их баярын наадмыг угтан "Дээлтэй Эрдэнэт-2025" өдөрлөгийг зохион байгуулж 350 гаруй иргэн оролцсон бөгөөд оролцогчдыг 11 төрлөөр шалгаруулж, Монголын үндэсний хувцасны соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчилсан. Тайлант хугацаанд үндэсний ёс заншил, өв соёлыг сурталчлах түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдыг сурталчлах чиглэлээр мөсөн шагайн харваа "Наурызын баяр", "Баян-Өндөр" хайрхны тахилга зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 4000 гаруй иргэнийг хамруулсан байна. | 100% |
| 183 | | 3.7.1.1.2. Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг олон нийтийн оролцоотой | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 40.0 | Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтын хувь | 100% | 100% | 10.0 | ОНТ-10.0 | СУАЖЗГ | Аймгийн Музей | Аймгийн нутаг дэвсгэрт орших 28 газрын 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хулгайн гэмт хэрэг зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн хяналт, оролцоог сайжруулах зорилгоор сумдын Засаг дарга нар, 20 малчин өрхтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гурвалсан гэрээ байгуулан ажиллаж, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүрэн хамгаалж | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулах. | | | | | | | | | | | байна. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалж буй өрхүүдийн урамшуулал болон дурсгалт газруудад мэргэжлийн байгууллагаас хяналт тавих зардалд 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. | |
| 184 | | 3.7.1.1.3 Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулах. | 2026-2028 | Орон нутгийн төсөв | 80.0 | Тухайн жилд хийгдсэн малтлагаас аймгийн Музейн сан хөмрөгийг баяжуулсан олдворын тоо | 3 олдвор | - | - | - | Аймгийн Музей | СУАЖЗГ НБХ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 185 | 3.7.1.2. Соёл, урлагийн байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 3.7.1.2.1. Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног, төхөөрөмж техник хэрэгсэл, эд хогшлоор хангах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 669.5 | Тухайн жилд шаардлагатай тоног, төхөөрөмж техник хэрэгслээр хангагдсан байгууллагын тоо | 4 байгууллага | 1 байгууллага | 69.5 | ОНТ-69.5 | СУАЖЗГ | НБХ БОНХОБТХ | Тайлант хугацаанд соёлын салбарын 8 байгууллагыг улсын төсвийн 256.1 сая төгрөг, орон нутгийн төсвийн 115.4 сая төгрөг, нийт 371.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлоор хангасан. Үүнд: Улсын төсвөөс:<br>• Аялгуу соёлын төв 108.6 сая<br>• Баянцагаан соёлын төв 34.0 сая<br>• Эгшиглэн соёлын төвд 27.4 сая<br>• Хэмнэл соёлын төв-25.9 сая<br>• Хүүхэд залуучуудын театр 27.4 сая<br>• Аймгийн Музей-32.8 сая;<br>Орон нутгийн төсвөөс:<br>• Аймгийн Музей 5.6 сая,<br>• “Эгшиглэн” соёлын төв 4.7 сая<br>• Хүүхэд залуучуудын театр 33.3 сая<br>•“Баян-Өндөр” хүүхэд, залуучуудын соёлын төв 6.8 сая<br>• Хэмнэл” соёлын төв 14.8 сая<br>• Аймгийн СУАЖЗГ-т 2.0 сая;<br>• “Жаргалант” соёл мэдээллийн төвд 48.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус тус техник, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлоор хангасан байна. | 100% |
| 186 | | 3.7.1.2.1. Соёлын байгууллагуудад шаардлагатай засвар үйлчилгээг хийж орчин нөхцөлийг сайжруулах. | 2026-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 500.0 | Тухайн жилд засвар хийгдсэн байгууллагын тоо | 1 байгууллага | - | - | | СУАЖЗГ | НБХ БОНХОБТХ | Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 480.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нийтийн номын сангийн хуучин барилгын дотор, гадна засварын ажлыг хийж дууссан. | 100% |
| 187 | | 3.7.1.2.1. Наран багийн Соёлын төвийг ашиглалтад оруулж, Эгшиглэн соёлын төв, аймгийн Музейн барилгын ажлыг эхлүүлэх. | 2027-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 17783.4 | Тухайн жилд ашиглалтад орсон барилгын тоо | 1 барилга | - | - | - | СУАЖЗГ | НБХ БОНХОБТХ | Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn системд Наран багийн 250 хүний суудалтай соёлын төвийн барилга, Говил багийн 200 хүний суудалтай Соёлын төвийн барилгуудын төсвийн тооцоолол, магадлалын ерөнхий дүгнэлт, газрын зөвшөөрөл, газрын кадастр, газрын гэрчилгээ болон холбогдох бусад баримт бичгийг бүрдлийг хангаан оруулж, 2026 оны улсын төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 188 | 3.7.1.3. Бүх | 3.7.1.3.1 | 2025- | Орон | 220.0 | Зохион | 5 | 10 | 40.0 | ОНТ-50.0 | СУАЖЗГ | НБХ | Тайлант хугацаанд "Урин хавар-2025" | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулна. | Нийгмийн амьдралд “Хотын соёл-Хамтын соёл”-ын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах. | 2028 | нутгийн төсөв | | байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан хүний тоо /тухайн жилээр/ | 20000 | 21000 | | | | | яруу найргийн наадам, “Үндэсний бичиг үсэг, номын баяр-2025”, соёлын төвүүдээс хэрэгжүүлсэн кино боловсрол олгох арга хэмжээ, музейн боловсрол олгох хөтөлбөр, “Эх хэлний өдөр”, “Үндэсний хувцасны өдөр” зэрэг бүх нийтийн соёлын боловсролын дээшлүүлэхэд чиглэсэн 68 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 14000 гаруй иргэд, хүүхэд, залуучууд хамрагдсан байна. Хүүхэд, өсвөр үеийнхэнд соёлын боловсрол олгох зорилгоор аймгийн Хүүхэд, залуучуудын театрын “Хөгжилтэй аялал” шинэ жүжигт “Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-өөс 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийгмийн амьдралд “Хотын соёл-Хамтын соёл”-ын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Соёлыг түгээе” аяныг 11 дүгээр сарын 11-нээс 12 дугаар 11-ний хооронд 1 сарын хугацаатай зохион байгуулсан.Мөн цахим орчинд эерэг хандлагыг түгээх зорилгоор “Урлаг+Лаг байя”, “Оюун+Лаг байя”, “We Love Culture” зэрэг цуврал рийлийг бэлтгэн түгээж цахим орчинд 8748 хүнд хүргэсэн байна. | |
| 189 | | 3.7.1.3.2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулах | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 150.0 | Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн тухайн жилд хийсэн борлуулалтын орлогын мөнгөн дүн | 37.7 | 60.0 | 20.0 | ОНТ-109.0 | СУАЖЗГ | НБХ | Тайлант хугацаанд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 5 үзэсгэлэн худалдаанд 129 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын чанартай 2 үзэсгэлэн худалдаанд 17 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, нийт 7 үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэд, аж ахуй нэгж, байгууллагууд 384.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнд:<br>○ “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 15 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож 45.0 сая төгрөг<br>○ “ITM-Mongolia-2025” аялал жуулчлалын үзэсгэлэнд 2 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож 3.7 сая төгрөг<br>○ “Зэс фестиваль” эвэнт арга хэмжээнд 18 иргэн, аж ахуй нэгж, байгууллага оролцож 300.0 сая төгрөг<br>○ “Баянцагаан” соёлын төвөөс зохион байгуулсан “Баянцагаан багийн брэнд бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож 0.9 сая төгрөг<br>○ “Аялгуу” соёлын төвөөс харьяалах | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | багуудын хэмжээнд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 30 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож 2.0 сая төгрөг<br>○ “Эгшиглэн” соёлын төвөөс зохион байгуулсан “Өвлөн урлая” үзэсгэлэн худалдаанд 11 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцон, 1.3 сая төгрөг<br>○ Аймгийн СУАЖЗГ-аас зохион байгуулсан “Эрдэнэт үйлдвэрлэв-2025” үзэсгэлэн худалдаанд 58 иргэн, аж ахуй нэгж, байгууллага оролцож 31.4 сая төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна. | |
| 190 | | 3.7.1.3.3. Орон нутгийн иргэдэд улсын хэмжээний уран бүтээлийг хүртээл болгох. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 280.0 | Уран бүтээлийн тоо /тухайн жилээр/ | 1 | 1 | 50.0 | ОНТ-50.0 | СУАЖЗГ | НБХ | Улсын Филармонийн Симфони оркестрын “Шилмэл бүтээл”-ийн 2 удаагийн тоглолтыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон. | 100% |
| 191 | 3.7.1.4. Соёл, урлагийн салбарын боловсон хүчнийг чадавхжуулж, гадаад, дотоодын соёлын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, соёл урлагийн байгууллага, иргэд, уран бүтээлчдээс гаргасан санал, санаачилгыг дэмжинэ. | 3.7.1.4.1. Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулж, гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 120.0 | Хамрагдсан албан хаагчдын тоо /тухайн жилээр/ | 41 | 10 | - | ОНТ-60.5 | СУАЖЗГ | НБХ | “Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд нийгмийн соёл, урлагийн салбарын албан хаагчдын чадавхжуулах чиглэлээр Соёлын өвийн үндэсний төв, СУИС, Үндэсний номын сан зэрэг байгууллагуудтай хамтран “Театрын уран бүтээлчдийн физикл хөдөлгөөний сургалт”, “Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэн баримтжуулалт”, “Эрдэм шинжилгээ судалгааны арга зүй” “Музейн тайлбар хийх арга зүй, Музейн ажилтны ёс зүй” , “Номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалт “<br>“Хөтлөгч бэлтгэх сургалт“ , “AI контент бүтээх, байгууллагын пэйж хуудас, вэб сайт хөгжүүлэлт “, “Хувь хүний хөгжил, манлайлал” сургалтуудыг зохион байгуулж 100 гаруй албан хаагчийг хамруулсан. Мөн соёл, урлагийн байгууллагын албан хаагчдыг Өмнөговь аймагт туршлага судлах, туршлага солилцох үйл ажиллагаанд хамруулах, аймгийн Нийтийн номын сан болон ерөнхий боловсролын сургуулиудын номын санчдын БНХАУ-ын Бээжин хотын номын сантай танилцуулах, туршлага судлуулах үйл ажиллагааг зохион байгуулж 31 албан хаагчийг хамруулсан. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан дээрх арга хэмжээнүүдэд хөтөлбөрийн зардлаас 41.0 сая төгрөг зарцуулсан байна. БНСУ-ын Жежү хотод зохион байгуулагдсан 64 дэх удаагийн “Тамна” олон улсын ардын урлагийн их наадамд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын уран бүтээлчдийг оролцох боломжоор хангаж орон нутгийн төсвөөс 24.5 сая дэмжлэг үзүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 192 | | 3.7.1.4.2. Олон улс, улс, бүсийн хэмжээнд зохион байгуулагдах соёлын уралдаан, тэмцээнд оролцох уран бүтээлчид, иргэд, хүүхэд залуучуудад дэмжлэг үзүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 60.0 | Тухайн жилд дэмжлэг үзүүлсэн иргэдийн тоо | 1 хамтлаг, 2 уран бүтээлч, 1 иргэн | 5 иргэн, уран бүтээлч | 15.0 | ОНТ-9.3 | СУАЖЗГ | НБХ | Тайлант хугацаанд АНУ-д төгөлдөр хуурын уралдаанд Орхон аймгаас оролцсон сурагч Л.Сарангуад 1.2 сая, АНУ-ын Бостон хотод зохион байгуулагдсан төгөлдөр хуурын олон улсын "А" зэрэглэлийн "Кришиндо" тэмцээнд Орхон аймгаас оролцсон 7 хүүхэд, 1 багшийн замын зардалд 4.0 сая, БНХАУ-д зохион байгуулагдсан “Цэнхэр гарагийн хүүхдүүд” олон улсын уралдаанд оролцох 21 хүүхдийн замын зардалд 2.1 сая, дуучин Д.Дагвадоржийн Польш улсад зохион байгуулагдсан “Great tenor tournament” уралдаанд оролцох зардалд 2.0 сая, нийт 9.3 сая төгрөгийн дэмжлэгийг 31 иргэнд үзүүлсэн байна. | 100% |
| 193 | | 3.7.1.4.3. Төрийн болон хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдээс гаргасан санал, санаачилга, шинэ уран бүтээлд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 95.0 | Дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо<br><br>Иргэд, уран бүтээлчдийн тоо | 4<br><br>12 иргэн, уран бүтээлч | 2<br><br>5 иргэн, уран бүтээлч | 20.0<br><br>15.0 | ОНТ-58.7 | СУАЖЗГ | НБХ | Тайлант хугацаанд “Үндэсний бичиг үсэг, номын баяр-2025” арга хэмжээнд 4.0 сая төгрөг, "Уран бийр" сургалтын төвийн багш Д.Цэгмидийн ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд явагдах гар зургийн уралдаан болон Улаанбаатар хотод зохион байгуулах уран зургийн үзэсгэлэнгийн зардалд 3.1 сая төгрөг, "Дэнжийн цуурай" төрийн бус байгууллагаас Улаанбаатар хот болон Хөвсгөл аймгийн уран бүтээлчидтэй хамтран зохион байгуулсан "Тэнгэрийн аялгуу" үндэсний хөгжмийн тоглолтын зардалд 500.0 мянган төгрөг, Дуу бүжгийн "Эрдэнэт" чуулгын уран бүтээлч С.Ариун-Эрдэнэ, Х.Мөнхбаяр, Н.Нямсүрэн нарын "Дэлхий аргадах ижий" уран бүтээлийн тоглолтын зардалд 3.0 сая төгрөг, Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор төрийн ордонд зохион байгуулагдсан "Монгол дархны уламжлал, шинэчлэл" сэдэвт үндэсний анхдугаар чуулганд Орхон аймгаас оролцох иргэдийн замын зардалд 0.6 сая төгрөг, Баян-Өндөр сумын Даваат багийн "Аялгуу" соёлын төвөөс аймгийн соёл, урлагийн байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд явуулсан "Соёлынхон" нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулах зардалд 2.9 сая төгрөг, дэлхийн яруу найргийн өдрийн хүрээнд иргэдийн дунд явагдсан "Урин хавар-2025" нээлттэй уралдаанд шаардагдах зардалд 2.1 сая төгрөг, Жаргалант соёл, мэдээллийн төвийн Орон нутаг судлах танхимын ажилтан Б.Нэмэхнямын 2025 оны "Эрдэнэт хотын болон Анхдагч, илгээлтийн эздийн өдөр"-өөр зохион байгуулагдах "Эрдэнэсийн өнгө" үзэсгэлэнд 17.8 сая төгрөг, аймгийн насан туршийн суралцахуйн төвөөс “Наурызын баяр”-ын хүрээнд Казах үндэстний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан гар зураг, ханын сонины уралдааны шагналын зардалд 1.5 сая төгрөг, Эрдэнэт хотоос төрөн гарсан “Outlaw” хамтлагийн 20 жилийн ойн тоглолтын зардалд 10.0 сая төгрөг, аймгийн СУАЖЗГ-аас зохион байгуулсан “Дээлтэй Монгол-2025” арга хэмжээнд 7.9 сая төгрөг, “Эрдэнэт үйлдвэрлэв-2025” үзэсгэлэн худалдаанд 5.0 сая төгрөг, ахмад уран бүтээлч Н.Цэцэгсүрэнгийн “Өлгий нутгаа магтан дуулъя” аялан тоглолтын зардалд 1.2 сая төгрөг, "Чөлөөлөх дайны ялалтад Монголчуудын оруулсан хувь нэмэр" марк, гэрэл зургийн үзэсгэлэнгийн зардалд 1.5 сая төгрөг, 4 дүгээр сургуулийн багш, хөгжмийн зохиолч Б.Дамбадаржаагийн уран бүтээлийн зардалд 1.5 сая төгрөг, нийт 5 байгууллага, 8 иргэнийг хүсэлтийг шийдвэрлэж 58.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | |
| 194 | 3.7.1.5 Аялал жуулчлалыг бүс орон нутгийн онцлогт түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ. | 3.7.1.5.1. “Эрдэнэт хаалга”-ны дэргэд аялал жуулчлалын мэдээлэл авах, түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулж, гадаад дотоодын аялагч, жуулчдын ая тухтай, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв Хувийн хэвшил | 250.0 | Тохижилтын ажлын гүйцэтгэл. хувь | - | 20% | 50.0 | - | СУАЖЗГ | БОНХОБТХ Баян-Өндөр сумын ЗДТГ ХББЗА | Аялал жуулчлалын мэдээлэл авах, түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулж, гадаад дотоодын аялагч, жуулчдын ая тухтай, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Эрдэнэт хаалганы урд талд “Welcome to Erdenet” цогцолборыг байгуулахаар ажлын даалгаврыг боловсруулж, эхний бүтээн байгуулалтын ажил болох MNS5924:2015 стандартын шаардлага хангасан 6 хүний хүчин чадалтай эко ариун цэврийн байгууламж баригдаж байна. Мөн 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Эрдэнэт угтах хаалганы урд ариун цэврийн байгууламжийн зориулалтаар 150 м.кв газрыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03/08 дугаар тогтоолоор батлуулж Жаргалант сумын ЗДТГ-т 2025 оны А303 дугаар захирамжаар эзэмшүүлсэн. “Эрдэнэт хаалга”-ны дэргэд Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг байршуулан бүх нийтэд мэдээллийг хүргэж байна. | 50% |
| 195 | | 3.7.1.5.2. Орон нутгийн онцлогыг илэрхийлсэн эвэнт арга хэмжээг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 190.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /өссөн д | 12 | 15 | 40.0 | ОНТ-90.0 | СУАЖЗГ | БОНХОБТХ ААНБ Аялал жуулчлалын холбоо | 1. Орхон аймаг, Эрдэнэт хотын онцлогийг илэрхийлсэн, уул уурхайн салбарын хөгжил, хувь нэмрийг олон нийтэд сурталчлах зорилгоор “ЗЭС ФЕСТИВАЛЬ” арга хэмжээг 3 дахь удаагаа аймгийн хэмжээнд хоёр өдрийн турш зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр уул уурхайн 5 үйлдвэрээ сурталчлах, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний худалдаа, зэс, зэсэн эдлэлийн гэр музейн үзэсгэлэн, байгальд ээлтэй цахилгаан машины үзэсгэлэнг зохион байгуулж, 18 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | оролцсон. Үзэсгэлэн худалдаанд нийт 200 гаруй нэр төрлийн зэсэн бүтээгдэхүүн дэлгэгдэж 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдаж 300.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>2. Монголын аялал жуулчлалын холбооноос зохион байгуулагддаг олон улсын "ITM-Mongolia-2025" үзэсгэлэнд орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ 2 өдрийн турш сурталчлан оролцож, 3.7 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийсэн.<br>3. "Наадмын гангараа" үзэсгэлэн худалдааг, "Уран гар - 2025" хойд бүсийн гар урлаачдын уралдааныг Орхон, Булган, Хөвсгөл, Дархан, Сэлэнгэ аймгуудын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, гар урлаачдыг хамруулж 2025 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 58 иргэн аж ахуй нэгж, байгууллага оролцож 31.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн. | |
| 196 | | 3.7.1.5.3. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, зочид буудлуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 30.0 | Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо<br><br>Зэрэглэлтэй зочид буудлын тоо /Өссөн дүнгээр/ | 80<br><br>5 | -<br><br>- | - | | СУАЖЗГ | БОНХОБТХ | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Хойд бүсийн аймгуудын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газар, Биеийн тамир спортын газар дарга, холбогдох мэргэжилтнүүд нийт 100 гаруй албан хаагчид хамрагдсан.<br>Зочид буудлуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, аймгийн ЗДТГ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран "Зочид буудлын үйлчилгээний стандартын онол, практик" хосолсон 10 цагийн сургалтыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, 100 гаруй хүнийг хамруулж гэрчилгээ олгосон. 2025 онд Баян-Өндөр сум Баянцагаан баг авто вокзалын дэргэд "Дорнын чимэг" ХХК-ийн Эрхт 888 зочид буудал шинээр ашиглалтад орсон.<br>ССАЖЗЯ-наас аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам Засгийн газрын хуралдаанаар орох бэлтгэл ажлыг хийж байгаатай холбогдуулан шинээр | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зэрэглэл авсан зочид буудал байхгүй байна. | |
| **Шинжлэх ухаан, инновацид суурилсан Ухаалаг хот** | | | | | | | | | | | | | | |
| 3.8.Орон нутгийн хэмжээнд шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан эдийн засаг хөгжинө. | | | | | | | | | | | | | | |
| *3.8.1.Орон нутагт шинээр бий болох инновац, бүтээгдэхүүний нэр төрөл, ажлын байр нэмэгдэнэ.* | | | | | | | | | | | | | | |
| 197 | 3.8.1.1. Бүс, орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, кластер хөгжүүлэх инновацын төсөл, гарааны компанийг инкубатор, технологи дамжуулах үйлчилгээгээр дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 3.8.1.1.1. Инновацыг олон нийтэд сурталчлан зөвлөх үйлчилгээг үзүүлж, гарааны компанийг хөгжүүлэх. | 2025-2028 | ШУТП-ийн хөрөнгө оруулалт | 80.0 | Бүртгэгдсэн гарааны компаний тоо /тухайн жилээр/ | 9 | 3 | 20.0 | ШУТП-20.0 | ШУТП | БОНХОБТХ | “Ухаалаг хот”, “Цэвэр агаартай хот” төслийн хүрээнд 12 гарааны компанид дамжуулах технологийг боловсруулж, 3 гарааны компани бүртгэсэн. | 100% |
| 198 | 3.8.1.2. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн ашиглаж буй импортыг орлох бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн судалгааг хийж, бүс нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологи дамжуулах ажлыг зохион байгуулна. | 3.8.1.2.1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн импортоор авч буй бараа, бүтээгдэхүүнээс орон нутагт үйлдвэрлэх боломжийн судалгааг хийж, бүтээгдхүүн үйлдвэрлэлийн технологи, төсөл боловсруулан бизнес эрхлэгчдэд дамжуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв ШУТП-ийн хөрөнгө оруулалт | 160.0 | Боловсруулсан технологи, төсөл | - | 2 | 40.0 | ШУТП-5.0 | ШУТП | БОНХОБТХ | ШУТП-аас “Бөбөр” ХХК-д катодын зэс үйлдвэрлэлийн дамжуулагчийн тусгаарлагч материал үйлдвэрлэх технологи дамжуулж, инкубаторт үйлдвэр байгуулагдсан. Мөн “Хард стийл” ХХК-д өнгөт металл хайлах цутгуурын хамгаалалтын түрхлэг үйлдвэрлэх судалгаа, технологийг дамжуулсан. | 100% |
| 199 | 3.8.1.3. Ухаалаг хотын стандартад нийцсэн дэд системүүдийг нэмэгдүүлж, инновац нэвтрүүлэн дэд бүтцийг өргөтгөх ажлыг зохион байгуулна. | 3.8.1.3.1. Олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний машин, тоног төхөөрөмжийг мэдээллийн дэд бүтцэд холбож, цахим хяналт, төлбөрийн системийг нэвтрүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр | 1550.0 | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | 50.0 | ОНТ-30.0 | БОНХОБТХ<br>ШУТП | ТЗУХ<br>ТЦҮХ<br>ЭУДТС<br>ОНӨХК<br>АТТ<br>ХТГ | Иргэдийг ухаалаг төхөөрөмж ашиглан лавлагаа, үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 10 байршилд "Хурдан" киоск машиныг байршуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахимаар төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. 2025 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Баян-Өндөр сумын Чингэл багийн байр, Говил багийн байр, Баян-Өндөр сумын гэр хорооллын эцсийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Цагдаагийн газар зэрэг нийт 6 киоск машин нэмж байршуулан төр хувийн хэвшлийн 60 гаруй байгууллагын 600 гаруй үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран төрийн байгууллагуудыг өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох | 50% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүйгээр цахим лавлагааны систем (lavlagaa.e-mongolia.mn), төлбөрийн нэхэмжлэхийн систем (tulbur.gov.mn)- үүдийг ашиглахаар төрийн байгууллагуудаас саналыг авч эрх нээлгэхээр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Мөн Ухаалаг хот төслийн хүрээнд мобайл аппликейшн, хөгжлийн интикатор - математик симуляц, хиймэл оюуны хөтөч зэргээс бүрдэх Нээлттэй Эрдэнэт өгөгдлийн сан үүсгэх буюу үндсэн суурь системийг хөгжүүлж байна. Ингэснээр ухаалаг хот төслийн хүрээнд хэрэгжих системийн суурь нэг систем бий болсон. | |
| 200 | 3.8.1.4. Мэдээллийн технологийн сургалт, үйлдвэрлэлийн “Технополис” төслийн I үе шатны ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангана. | 3.8.1.4.1. “Технополис” төслийн барилгын нэгдсэн зураг, төсвийг боловсруулж батлуулах. | 2025-2027 | Орон нутгийн төсөв | 3000.0 | Магадлал хийгдсэн иж бүрэн зураг, төсөв | - | - | - | - | БОНХОБТХ | ШУТП | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 201 | | 3.8.1.4.2. Төсөл хэрэгжих байршилд инженерийн шугам сүлжээ, авто замын дэд бүтцийн судалгааг хийж, зураг төсвийг боловсруулах | 2027-2028 | Орон нутгийн төсөв | 10000.0 | Цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, шилэн кабель, авто замын нэгдсэн зураг, төсвийн гүйцэтгэл хувь /тухайн жилээр/ | - | - | - | - | БОНХОБТХ ХЗА | ШУТП | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2027 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ** | | | | | | | | | | | | | | |
| **Хүний эрх, эрх чөлөө** | | | | | | | | | | | | | | |
| 4.1. Аймгийн хэмжээнд бүх талаар хүний эрх хангагдана. | | | | | | | | | | | | | | |
| *4.1.1. Төрийн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэн, хүний эрхийн зөрчил буурсан байна.* | | | | | | | | | | | | | | |
| 202 | 4.1.1.1. Хүний эрхийн үндэсний комисс болон бусад байгууллагуудтай хүний эрхийг хангах чиглэлээрх хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 4.1.1.1.1. Хүний эрхийг хангах чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллага, иргэдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүний тоо /тухайн жилээр/ | 880 | 1400 | 5.0 | ОНТ-4.0 | ХЭЗХ | ХЭҮК Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд | Хүний эрхийн үндэсний комисс болон бусад байгууллагуудтай хамтран хүний эрхийг хангах чиглэлээр 5 төрлийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 1121 хүнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөг зарцуулсан. Үүнд:<br>○ 2025 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг таниулах” үйл ажиллагааны талаарх сургалт хэлэлцүүлгийг 2 өдөр зохион байгуулсан. Тус сургалт хэлэлцүүлэгт ЕБС-ийн 250 сурагч, их дээд сургууль, коллежийн 28 оюутан, 110 иргэн, захиргааны байгууллагын 34 төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэгтэй 26 албан хаагч, ТББ-ын төлөөлөл болон үйлдвэрчний эвлэлийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хорооны 40 гишүүд, нийт 488 хүн хамрагдсан.<br>○ Цагдаагийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран “Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэлт" сэдэвт өглөөний уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад 10 байгууллагын 20 гаруй албан хаагч оролцсоноор албан хаагчдын хүний эрхийг хамгаалагчийн талаарх мэдлэг мэдээлэл дээшилсэн.<br>○ 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран “Хүний эрх ба цахим технологи” сэдэвт сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалтад төрийн захиргааны болон төрийн тусгай байгууллагын 80 гаруй албан хаагч хамрагдсан.<br>○ Хүний эрх хамгаалагчийг хамгаалах болон хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар цахим нөлөөллийн 1 шторк, 1 нэвтрүүлэг, 14 постер мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд мэдээлсэн ба давхардсан тоогоор 20000 гаруй хандалт авсан байна.<br>○ Олон Улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан 12 дугаар сарын 10-ний өдөр хүүхдийн эрүүл мэндийн эрхийн хүрээнд “Электрон тамхины хор хөнөөл” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулсан. Уралдаанд аймгийн ЕБС-ийн 6-9-р ангийн нийт 533 сурагч оролцож бүтээл ирүүлж, шагналт байруудыг тодруулсан. Тус бүтээлийг Орхон хууль эрх зүйн хэлтэс пейж хуудасд байршуулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 70000 гаруй хандалт авсан байна. | |
| 203 | | 4.1.1.1.2. Хүний эрхийн Үндэсний комиссоос ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /тухайн жилээр/<br><br>Хамтран ажилласан байгууллагын тоо /тухайн жилээр/ | 100%<br><br>20 | 100%<br><br>50 | - | - | ХЭЗХ | Төрийн байгууллагууд ХЭҮК-ийн мэргэжилтэн | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос тайлант хугацаанд 3 зөвлөмж, 1 албан шаардлага ирсэн. Тус зөвлөмж, шаардлагын хүрээнд хийсэн үйл ажиллагаа, зарцуулсан төсөв болон төлөвлөсөн арга хэмжээ, хийсэн ажлын талаарх мэдээллийг хуулийн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газарт хүргүүлж ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.<br>Мөн Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагатай хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх чиглэлээр гэрч хохирогчийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудыг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хөгжүүлэх, сэргээн засах, байнгын асаргаа шаардлагатай иргэдийг сувилах, ээжүүдийг чадавхжуулах, залуучуудыг дэмжих, сэтгэл зүйн цогц боловсрол олгох хүрээнд төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр аймгийн ЗДТГ-аас 26 төрийн бус байгууллага, давхардсан тоогоор 30 хэвлэл мэдээллийн байгууллага, бусад 40 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, үр дүнг тооцон ажилласан. | |
| 204 | 4.1.1.2. Аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаандаа хүний эрхийг дээдлэх, иргэд эрхээ эдлэх нөхцөлийг хангаж байгаа эсэхэд төрөөс тавих хяналтыг сайжруулна. | 4.1.1.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаандаа хууль тогтоомж болон хүний эрх зөрчиж буй эсэхэд хяналт шалгалт хийх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 12.0 | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br><br>Илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь /тухайн жилээр/ | 92<br><br>100% | 92<br><br>100% | 3.0 | | ХЭЗХ | Төрийн байгууллагууд ХЭҮК-ийн мэргэжилтэн | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажилласан ба ажлын хэсэгтэй хамтран хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр нийт 6 байгууллагын үйл ажиллагаатай танилцан хяналт шалгалт хийсэн. Шалгалтын урьдчилсан дүнгээр аймгийн БОЭТ-д эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгахтай холбоотой зөрчил илэрсэн. Тус зөрчлийн дагуу салбар дундын хурлыг зохион байгуулж 10 дугаар сард 4667.2 кг халдвартай хог хаягдал, 941.3 кг хурц үзүүртэй хог хаягдлыг автоклавд халдваргүйжүүлэн ландфиллын аргаар устган зөрчлийг бүрэн арилгасан байна. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/05 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хугацаа сунгах журам”-ын дагуу 3 удаа сүм хийдүүдэд хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.Үүнд:<br>• 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд хийсэн хяналт шалгалтаар буддын шашны хийд 10, христийн шашны сүм 16 сламын шашны 1 сүмд хяналт шалгалт хийсэн.<br>• 2025 оны 09 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 5 сүмд хяналт шалгалт хийсэн.<br>• 2025 оны 11 дүгээр сарын 05-11-ний өдрүүдэд 16 хүний бүрэлдэхүүнтэй хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 18 сүм, хийдэд хяналт шалгалт хийж давхардсан тоогоор 50 сүм, хийдэд хяналт шалгалт хийсэн.<br>Аймгийн Засаг даргын А/931 дүгээр захирамжийн дагуу аймгийн нутаг дэвсгэрт байрлах оршуулгын газруудад | 71.7%<br><br>100%<br><br>Дундаж 85.9% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж нийт 10 оршуулгын газарт хяналт шалгалт, хэмжилт боловсруулалт хийж, оршуулга түүнд хамаарах үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй 7 аж ахуйн нэгж байгаагаас 3 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийсэн. Тус байгууллагуудад холбогдох байгууллагууд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан. | |
| 205 | 4.1.1.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар бүх нийтийн жендэрийн талаарх боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 4.1.1.3.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд олон нийтэд сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 110.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/ | 25<br><br>5590 | 28<br><br>6050 | 20.0 | ОНТ-20.0 | НБХ ХГБХХГ | Сумдын ЗДТГ ТББ-ууд | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын талаар 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг байгууллагуудаас авч, нэгтгэн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 10 төрлийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 9863 иргэн хамруулж орон нутгийн төсвөөс 20.0 төгрөг зарцуулсан. Үүнд: Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк хамтран зохион байгуулсан "Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр", баруун болон хойд бүсийн семинарт орон нутгаас 6 эмэгтэйг хамруулсан байна.<br>Иргэд олон нийтэд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр "Жендэрийн ерөнхий ойлголт", "Жендэрт суурилсан хүчирхийлэл"-ийн тухай 5 сургалтыг зохион байгуулж байгууллагын 152 албан хаагч хамрагдаж, тэдний жендэрийн тухай мэдлэг ойлголт нэмэгдсэн. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Ажлын байран дахь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт" сургалтад 92 удирдах ажилтныг онлайнаар хамруулж тэдний ажлын байран дахь жендэрийн тухай мэдлэг ойлголт сайжирсан. Өсвөр үе хүүхэд багачуудад хөгжил хамгааллын өдрийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 2 ТББ-тай гэрээ хийж, 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Орон нутгийн жендэрийн сургагч багштай хамтран эрсдэлийн программд бүртгэлтэй 20 өрхийн 43 эрэгтэйтэй амьдралын эерэг дадал, эрүүл хооллолт, амьдрах ухааны сургалтыг 6 удаа үе шаттай зохион байгуулснаар тэд эрүүл хооллолт, эерэг дадал зуршлын талаар ойлголт нэмэгдсэн. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд сургалт, цахим хичээл, контент, жендэрийн талаарх ойлголтыг тодорхойлох тест зэрэг арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3983 гаруй иргэдийг хамруулж, орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 206 | 4.1.1.4. Цагдан хорих, баривчлах байрны | 4.1.1.4.1. Цагдан хорих, баривчлах | 2025-2028 | Улсын болон орон нутгийн | 2641.0 | Засварын ажлын гүйцэтгэл. | Хорих ангийн 3 | Хорих байрны дээвэр | 111.0 | ОНТ-111.0 | ШШГГ | ХЭЗХ | 2025 онд ШШГГ-ын хорих ангийн дээврийн засвар, гадна пасад болон цагдан хорих байрны хорих өрөөнүүдэд | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | байранд засвар хийж, шинээр 120 хүний багтаамж бүхий цагдан хорих, баривчлах байр барих ажлыг эхлүүлэх. | | төсөв | | хувь<br><br>Цагдан хорих, баривчлах байрны ажлын гүйцэтгэл. хувь /Өссөн дүнгээр/ | дугаар дав харт 40 хүний баг таамж бүхий 22 өрөө<br><br>- | болон өрөөнүүдийн засварыг хийх<br><br>- | | | | | засвар, үйлчилгээ хийх, хоригдол, хоригдогч нарын орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд барилга, засварын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материал худалдан авахад орон нутгийн төсвөөс 111.8 сая төгрөгийг шийдвэрлэж, бараа материал авах гэрээний дагуу хорих ангийн дээврийн засвар, хорих өрөөнүүдийн засварын нийт 38 нэр төлийн бараа, материалыг бүрэн хүлээн авч дээврийн засвар, гадна пасадны ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Мөн уг ажлын хүрээнд нийт 24 хорих өрөөнд угаалтуур, суултуур, цэвэр болон бохир усны шугам, бохирын хоолой, халуун усны өрөөг шинэчлэн засварласнаар хүний эрхийг хангаж, цагдан хорих байрны эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн. | |
| 207 | 4.1.1.5. Зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна. | 4.1.1.5.1. Цагдаагийн газрын уулзалт, мэдүүлгийн болон таньж олуулах ажиллагааны өрөөг нэмэгдүүлж, стандартад нийцүүлэн тохижуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 32.0 | Нэмэгдүүлэх уулзалт, мэдүүлэг болон таньж олуулах өрөөний тоо /тухайн жилээр/ | 8 | 2 | 8.0 | ОНТ-402.6 | ХЭЗХ | ЦГ | Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/01 дугаартай тушаалаар баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ын дагуу уулзалт, мэдүүлгийн 1 өрөөг 2025 онд стандартад нийцүүлэн тохижуулж, нийт 9 өрөөг үйл ажиллагаандаа ашиглаж байна.Үүнд:<br>Цагдаагийн газрын 1 дүгээр байрны уулзалт, мэдүүлгийн 101, 102, 103, 205, 206, 211, 305 тоот, Жаргалант сумын хэсгийн төлөөлөгчийн уулзалт, мэдүүлгийн 01 тоот өрөө, Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн Цагдан хорих байрны уулзалт, мэдүүлгийн 01 тоот өрөөнүүд багтаж байна.<br>Мөн Цагдаагийн газрын хэмжээнд ашиглаж байгаа уулзалт, мэдүүлгийн өрөөний хяналтын камерын тусгалыг өөрчилж, 1 хяналтын камерыг мөрдөгч руу харуулж суурилуулсан. Цагдаагийн газрын уулзалт мэдүүлгийн 206, 211 тоот 2 өрөөг 1.6 сая төгрөгөөр засвар тохижилтын ажил хийсэн. Аймгийн болзошгүй аваарын зардлын 401.0 сая төгрөгийн санхүүжилтээр Цагдаагийн газрын төв байрны хажуу талын 1 давхарт агуулахын байрны зориулалтыг өөрчилж уулзалт мэдүүлгийн 10 өрөөг шинээр байгуулж, засварын ажил явагдаж байна. | 100% |
| 208 | 4.1.1.6. Хууль тогтоомжийг сурталчлан бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион | 4.1.1.6.2. Хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 108.0 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүний тоо /тухайн жилээр/ | 76238 | 79000 | ОНТ-27.0 | ОНТ-30.0 | ХЭЗХ | Төрийн болон төрийн бус байгуул лагууд | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулсан. Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн сургалт зохион байгуулах ажлын зардалд орон нутгийн төсөвт 30.0 сая төгрөг батлуулж тайлант хугацаанд шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон болон хүчин | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | | | | | | | | | төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эсрэг гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд залуучууд холбогдохоос урьдчилан сэргийлэх, Хүний эрх хамгаалагчийн механизмыг таниулах, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль зэрэг 15 сэдвээр 30 удаагийн сургалтыг төрийн 12 байгууллагын 1200 орчим албан хаагч болон 23 багийн иргэдийг хамруулан зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2703 хүн хамрагдаж, 860 иргэнд утсаар, биечлэн, чатбот хариугаар тус тус хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг үнэ төлбөргүй өгч ажилласан.Хууль тогтоомжийг сурталчлах ажилд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг зарцуулсан байна.<br>Шинээр батлагдсан хууль тогтоомжуудын хүрээнд 10 сэдвээр 340 сэрэмжлүүлэг, хуулийн постер, 43 төрлийн зурагт хуудас, гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, “Номин” телевизтэй хамтран “Хуулийн цаг” 17 удаагийн нэвтрүүлэг, богино хэмжээний видео 36, нийт 53 нэвтрүүлэг, видео бэлтгэж телевиз болон цахим хэлбэрээр иргэдэд сурталчилж ажилласан. Сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээ /цахим болон танхим/-нд нийт давхардсан тоогоор 2020.9 мянган хүн хамрагдсан байна. | |
| 209 | 4.1.1.7. Нутгийн захиргааны байгууллагаас шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллана. | 4.1.1.7.1. Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон шийдвэрийн төслийг боловсруулж, эрх ашиг нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулан хуульд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Хэлэлцүүлэгт хамрагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/<br><br>Батлагдсан захиргааны хэм хэмжээний актын тоо /өссөн дүнгээр/ | 172<br><br>7 | 180<br><br>8 | - | - | ХЭЗХ | Сумдын ЗДТГ Төрийн байгуул лагууд | Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны шийдвэр гаргахад эрдэмтэн судлаачид болон иргэд, олон нийтийн байгууллагуудаас санал авч, эрх ашиг нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Жаргалант суманд шинээр баригдсан 30 айлын болон 15 дугаар байрны орон сууцыг түрээслээд өмчлөх журмын төслийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулж, 180 иргэн нээлттэй сонсголд оролцсоноос 35 иргэнээс санал хүсэлт ирүүлсэн. Сонсголыг 2 үе шаттай зохион байгуулж иргэдийн саналыг тусган Жаргалант сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/04 дүгээр тогтоолоор “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам" батлагдсан.<br>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу Засаг даргын захирамжаар батлахаар төлөвлөж буй “Хотын доторх замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | журам", МУЗЗНДНТУтХ-ийн 35 дугаар зүйлд заасан "Амьтны хүрээлэн ажиллуулах журам", "Мал нэвтрэхийг хориглосон бүсчлэлд мөрдөх журам"-ын төслүүдийг тус тус www.erdenet.mn сайтад 30 хоногийн турш байршуулан иргэдээс цахимаар санал авч, иргэдийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан ба хэлэлцүүлгээс гарсан саналуудыг журмын төсөлд тусгасан.<br>Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/888 дугаар захирамжаар "Хотын доторх замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттай оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/55 дугаартай тогтоолоор "Орхон аймгийн Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай" захиргааны хэм хэмжээний актуудыг баталсан. | |
| **Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал** | | | | | | | | | | | | | | |
| *4.2.* Төрийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдан, орон нутгийн өмчит байгууллагын алдагдал буурна. | | | | | | | | | | | | | | |
| *4.2.1. Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо сайжирч, орон нутгийн өмчит байгууллагуудын оновчтой бүтэц бий болж, зохион байгуулалт сайжирна.* | | | | | | | | | | | | | | |
| 210 | 4.2.1.1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, хуулиар хориглосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно. | 4.2.1.1.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд заасан мэдээллийг shilen.gov.mn системд технологийн шийдлээр холбон нийтэд ил тод мэдээлэх. | 2025-2028 | - | - | shilen.gov.mn системд байршуулсан мэдээллийн үнэлгээний хувь | 80% | 85% | - | - | ТЗУХ ТЦҮХ | Нийт төрийн болон төрийн өмчит байгууллагууд | Нийтийн мэдээллийн ил тод байдлын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээ, мэдээллийг аймгийн албан ёсны веб сайт www.erdenet.mn болон И-Монгол академиас хөгжүүлсэн Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас www.gov.mn, e-mongolia.mn/org/orkhongovern-д тухай бүр эх сурвалжийн хамт байршуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн "5Ш" ажиллагааны Шилэн ажиллагааны хүрээнд хөгжүүлсэн www.shilen.gov.mn системд мэдээ, мэдээллийн холбоос, линкнүүдийг оруулан улирал бүр үнэлүүлэн ажиллаж байна. Тухайлбал:<br>1. 2024 оны IV улиралд 94.7 хувь<br>4. 2025 оны I улиралд 83.9 хувь<br>5. 2025 оны II улиралд 77.8 хувь<br>6. 2025 оны III улиралд 76.2 хувьтай тус тус үнэлэгдсэн. 2025 оны IV улирлын үнэлгээ системд ороогүй байна. | 64.0% |
| 211 | | 4.2.1.1.2. Мэдээлэл хариуцагч байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөвлөн туслах | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо /тухайн жилээр/<br><br>Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт. | -<br><br>100% | 15<br><br>100% | - | - | ХЭЗХ ТЦҮХ | Төрийн болон төрийн өмчит байгууллагууд | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага болон төрийн өмчийн оролцоо бүхий 47 байгууллагад "Нийтийн мэдээллийн ил тод, байдлыг хангах" тухай шалгалтыг хийж мэдээлэл хариуцагч байгууллагуудад мэргэжлийн боловсон хүчин дутмаг, мэргэжилтний ажил үүргийн хуваарь тодорхой бус зэрэг зөрчлүүдийг | 100%<br><br>95%<br><br>Дундаж 97.5% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь | | | | | | | арилгахыг зөвлөсөн. Мөн Орхон аймгийн хэмжээнд ашиглагддаг дотоод системээр дамжуулан бүх байгууллагуудад дотоод мэдээ, файлын сан, аудио видео цэсүүдэд нээлттэй байдлаар хяналт шалгалтын тухай зөвлөмж, мэдээ мэдээллийг байршуулсан. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хуулийг сурталчлах рийл нь тайлант хугацаанд давхардсан тоогоор 2700 орчим иргэдэд хүрсэн. Зөрчлийн шийдвэрлэлт 95 хувь байна. | |
| 212 | 4.2.1.2. Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжих бодлогыг баримтлан төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 4.2.1.2.1. Төрийн бус байгууллагууд тай гэрээ байгуулан хамтран ажиллаж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | | Хамтран ажилласан Төрийн бус байгууллагын тоо /тухайн жилээр/ | 14 | 14 | 60.0 | ОНТ-60.0 | ТЗУХ | БОНХОБТХ<br>НБХ<br>ХЭЗХ<br>СТСХ<br>ХШҮХ<br>ТББ-ууд | Төрийн зарим үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд ТББ-уудтай гэрээ байгуулан ажиллахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс тус бүрээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 онд нийт 18 ТББ-тай гэрээ байгуулж хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хувь хүний хөгжил, мониторинг, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг зэрэг 5 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллахад нийт 60.0 сая төгрөг зарцуулаад байна. | 100% |
| 213 | 4.2.1.3. Орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, шинэчлэн зохион байгуулна. | 4.2.1.3.1. Орон нутгийн өмчит байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, шинэчлэх. | 2025-2028 | - | - | Өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн байгууллагын тоо /тухайн жилээр/ | 11 | 10 | - | - | ОНӨГ | Орон нутгийн өмчит байгууллагууд | “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ, Хотын захирагчийн алба 2-ын чиг үүрэгт шинжилгээ хийж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 02/21 дүгээр тогтоолоор “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын ангиллыг өөрчлөх, дүрэм, орон тоо, цалингийн нийтлэг жишиг”-ийг батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус 5 дугаар хуралдаанаар “Мэдээлэл шуурхай удирдлагын төв” УТҮГ-ыг татан буулгах тухай” асуудлыг хэлэлцүүлэн 03/29 дүгээр тогтоолоор татан буулгаж, нэршлийг өөрчлөн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төв”-ийг байгуулсан.<br>Ажлын чиг үүрэг давхардаж байгаа Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж” УТҮГ-ын нэгтгэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/710 дугаар захирамжаар байгуулсан ажилласнаар “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” | 50% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | ашиглалтын өмнөх захиргаа, “Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж” УТҮГ-ын бүтэц орон тоог өөрчлөн, давхардлыг арилгах асуудлаар 4 удаа хуралдаж "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж"-ийн газрыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хот тохижуулах газартай нэгтгэх, “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” ашиглалтын өмнөх захиргааны зүүн талын хэсгийн тохижилтын ажлыг яаралтай дуусгаж, үйл ажиллагааг жигдрүүлсний дараа татан буулгаж орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэсэн. | |
| 214 | | 4.2.1.3.2. Орон нутгийн өмчит байгууллагуудын төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж, төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулж, дүрмийг батлуулан хэрэгжүүлэх. | 2025-2027 | - | - | ТУЗ-ийг шинэчлэн байгуулсан байгууллагын тоо<br><br>Дүрмийг шинэчилсэн байгууллагын тоо | <br><br><br>11 | 2<br><br><br>10 | - | - | ОНӨГ | Орон нутгийн өмчит байгууллагууд | Орон нутгийн өмчит “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, “Жаргалант ус ДТС” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг тус бүр 9 гишүүнтэйгээр байгуулж, ТУЗ-ийн гишүүдийн хувийн ашиг, сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаартай тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр Хотын захирагчийн албаны дарга Б.Одгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Даваадорж, аймгийн ИТХ-ын Бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Тунгалаг, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттүвшин, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч С.Энхтүвшин, Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Эрдэнэчимэг, EBS телевиз, TV-9 инфо сүлжээ, Монголын радиогийн Орхон аймаг дахь сурвалжлагч Ж.Баяртогтох, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн, Татварын мэргэшсэн нягтлан бодогч В.Хандмаа нарыг, “Жаргалант ус ДТС” ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга Б.Золоо, аймгийн СТСХ-ийн дарга Л.Ганлсансайнхувьт, Жаргалант сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ц.Ганбаяр, Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баттөр, Хотын захирагчийн албаны Барилгын инженер, ахлах мэргэжилтэн Г.Тулгабаатар, “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн Дулааны инженер Ц.Одбаяр, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн Ё.Пэрэнлиймаа, “Холл” ХХК-ийн Санхүүгийн зөвлөх Д.Наранмандах нарыг сонгон | 50% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | шалгаруулах зар мэдээ, сонгон шалгаруулалтын үр дүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон шийдвэр болон бусад холбогдох мэдээллүүдийг http://www.erdenet-us.gov.mn, http://www.erdenet.mn, http://www.umch-erdenet.mn сайтуудад байршуулж ажилласан.<br>Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, компанийн засаглалыг сайжруулах сургалтыг 2025 он 12 дугаар сард “Жаргалт хаан хайрхан консалтинг” ХХК-тай зохион байгуулан ажилласан. | |
| **Цахим засаглал, төрийн үйлчилгээ** | | | | | | | | | | | | | | |
| 4.3. Цахим засаглалыг хөгжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангана. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, сайжирч, төрийн байгууллага болон үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. | | | | | | | | | | | | | | |
| *4.3.1. Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана.* | | | | | | | | | | | | | | |
| 215 | 4.3.1.1. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасган, шуурхай байдлыг хانган ажиллана. | 4.3.1.1.1. Цахим төвийг ажиллуулж, төрийн цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | - | - | Цахим үйлчилгээний тоо /өссөн дүнгээр/ | 102 | 105 | - | - | ТЗУХ | ТЦҮХ Төрийн байгууллагууд | Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж аймгийн ЗДТГ-ын дэргэд "Цахим төв"-ийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"-Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээг үзүүлж байна. Тус төвөөр тайланд онд давхардсан тоогоор 78550 иргэн үйлчлүүлж үйлчилгээ авсан. Төрийн үйлчилгээг олон шат дамжлагагүй, хүнд сурталгүйгээр иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Баян-Өндөр сумын алслагдсан гэр хорооллын багийн төрийн үйлчилгээний нэгдсэн байр болон Захиргааны IY байранд, Жаргалант суманд ЗДТГ-ын байранд тус тус "Хурдан" төвийг ажиллуулж байна.<br>"Хурдан" төвөөр дамжуулан 86 байгууллагын 1173 төрлийн лавлагаа тодорхойлолтыг холбогдох Төрийн байгууллага дээр очихгүйгээр хурдан шуурхай чирэгдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэн ажилласнаар 2025 онд давхардсан тоогоор 35030 иргэн үйлчлүүлж үйлчилгээ авсан байна.<br>Тайлант онд хүн ам ихээр төвлөрдөг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын АБК цех, аймгийн Авто тээврийн төв болон Баян-Өндөр сумын Дэнж, Оюут багт шинээр багийн байр ашиглалтад орсонтой холбогдуулан төрийн цахим үйлчилгээний машинуудыг шинээр 10 цэгт нэмж байршуулан ажиллуулан төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна. | 100% |
| 216 | | 4.3.1.1.2. Төрөөс үзүүлж байгаа | 2025-2028 | Орон нутгийн | 92.0 | Ашиглалтад орсон | - | 2 | - | | ТЗУХ | Төрийн байгуул | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас үзүүлж байгаа | 33.0% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээнүүдэд шинжилгээ хийж, үйл ажиллагааг цахимжуулах, процессыг хялбаршуулах талаар судлан хэрэгжүүлэх. | | төсөв | | системийн тоо<br><br>Ашиглалтын хувь<br><br>Хялбаршуулсан үйлчилгээний тоо /тухайн жилээр/ | -<br><br>- | 92.0%<br><br>1 | -<br><br>- | | | лагууд | үйлчилгээнүүдээс цахимжуулан e-mongolia системд холбох боломжтой үйлчилгээнүүдийн судалгааг авч нэгтгэн 3 байгууллагын 10 төрийн үйлчилгээг цахимжуулах саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03/2687 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хөгжүүлсэн lavlagaa.e-mongolia.mn, tulbur.gov.mn системүүдийг ашиглах эрх авахаар хүсэлтийг ТЦҮЗГ-т хүргүүлсэн. Одоогийн байдлаар ашиглах эрхийг өгөөгүй байна. | |
| 217 | | 4.3.1.1.3. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах irgen.erdenet.mn вэб системийг өргөжүүлж ашиглалтыг нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 55.0 | Систем өргөжүүлэлтийн гүйцэтгэл. хувь<br><br>Системд хандсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | <br><br>240 | -<br><br>250 | - | - | ТЗУХ | Төрийн байгууллагууд | Цахим булангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдийн санал хүсэлтийг цахимаар гаргадаг irgen.erdenet.mn программын ашиглалтын талаар Баян-Өндөр сумын цахим хуудас болон 26 багийн цахим хуудас, багуудын хөршийн холбооны ахлагч нар, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн самбар, ус түгээх байр зэрэг хүн олноор цуглардаг газарт байршуулж, 2 удаа давхардсан тоогоор 30800 иргэнд сурталчилсан. 2025 онд багуудын цахим булангаар irgen.erdenet.mn системээр дамжуулан 214 өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагуудтай хамтран 100 хувь шийдвэрлэсэн. Тус системээр дамжуулан өргөдөл гомдлуудыг Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн иргэдэд нээлттэй хүргэн ажилласан. Ингэснээр иргэд гаргасан өргөдөл гомдлоо ямар шатанд, хэрхэн шийдвэрлэгдсэнийг харах боломжтой болсон. Багуудын цахим булангаас давхардсан тоогоор 642 иргэн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт авч үйлчлүүлсэн байна. | 100% |
| 218 | | 4.3.1.1.4. Алслагдсан багуудад төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2026-2027 | Орон нутгийн төсөв | 68.0 | Цахим үйлчилгээ үзүүлэх киоск машины тоо /өссөн дүнгээр/ | 5 | - | - | - | ТЗУХ | Сумдын ЗДТГ | Аймгийн хэмжээнд нийт 10 байршилд "Хурдан" киоск машиныг байршуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахимаар төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Үүнээс өмнөх онд буюу 2024 онд Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн тамгын газарт, Авто тээврийн төв, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх "Цахим төв" зэрэг 4 байршилд байршуулсан бол 2025 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Баян-Өндөр сумын Чингэл багийн байр, Говил багийн байр, Баян-Өндөр сумын гэр хорооллын эцсийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Цагдаагийн газар зэрэг нийт 6 киоск машин нэмж байршуулан төр хувийн хэвшлийн 60 гаруй байгууллагын 600 гаруй | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | үйлчилгээг киоск машинаар иргэдэд хүргэх боломжийг нэмэгдүүлж, тайлант онд нийт 1683 иргэн үйлчилгээ авсан байна. Ингэснээр алслагдсан багуудын иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах төдийгүй цаг хугацааны хязгаарлалтгүйгээр үйлчилгээг авч эдийн засгийн болон цаг хугацааны хэмнэлтийг бий болгосон ач холбогдолтой байна. | |
| 219 | 4.3.1.2. Төрийн байгууллагын цахим дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг нэвтрүүлж, шийдвэр гаргах үйл явцыг шуурхай, ил тод болгоно. | 4.3.1.2.1. Харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээнд холбогдоогүй алслагдсан багуудад байрлах төрийн байгууллагуудыг өндөр хурдны интернэтэд холбох шилэн кабелийн худаг сувагчлалд өргөтгөл хийж, нэгдсэн сүлжээнд холбох. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 492.0 | Шилэн кабелийн урт /тухайн жилээр/<br><br>Холбогдсон байгууллагын тоо /өссөн дүнгээр/ | Алслагдсан багуудад татагдсан шилэн кабел 5км<br><br>5 | Их залуу багт 1 км<br><br>6 | 192.0<br><br>- | | МХС ТӨХК | БОНХОБТХ ХЭЗХ | 2025 онд Их залуу багт “Хот спот” ХХК орон нутгийн төсвийн 185.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 км худаг сувагчлалын өргөтгөл хийж, 7.8 км шилэн кабель татсан. Шинээр байгуулсан шилэн кабелын сүлжээнд Их залуу багийн байр, 15 дугаар сургуулийг нэмж холбосон. Цаашид Их залуу багт баригдах төр, орон нутгийн байгууллагуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох техникийн боломж бүрэн бүрдээд байна. | 100% |
| 220 | | 4.3.1.2.2. Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон ISO 27001:2023 стандартын баталгаажуулалт хийх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 120.0 | Аудитын дүгнэлт<br><br>Баталгаажуулалтад хамрагдах | - | Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх | 35.0 | | ТЗУХ | МХС ТӨХК | Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх техникийн тодорхойлолтыг боловсруулан Худалдан авах ажиллагааны газарт Тендер шалгаруулалт зарлуулах саналыг хүргүүлсэн болovч хугацаандаа зарлагдаагүй шалтгаанаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу төсөв татагдсан. Тус ажлыг 2026 онд гүйцэтгэхээр орон нутгийн төсөвт 35.0 сая төгрөгийг тусган батлуулсан. | 0 |
| 221 | 4.3.1.3. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 3-аас доошгүй багийн нэгдсэн байрыг шинээр барьж ашиглалтад оруулна. | 4.3.1.3.1. Багийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 780.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт. хувь /тухайн жилээр/ | 100% | 100% | 180.0 | ОНТ-926.5 | ТЗУХ | Сумдын ЗДТГ | Багийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2025 онд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн 100 хувь ажилласан. Үүнд:<br>○ Багуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор багийн байр болон иргэний танхимын урсгал засвар, тохижилтод сумын төсвөөс 303.0 сая төгрөг, шаардлагатай техник тоног төхөөрөмж, эд хогшлуудаар хангахад 185.0 сая төгрөг зарцуулсан.<br>○ Багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь 30 гаруй удаагийн сургалтуудыг зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор багийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, буцалтгүй тусламж олгох, иж бүрэн гэр олгох, | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | бичгийн хэрэгсэл, албаны жигд хувцсаар хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлыг сайжруулахад зориулж сум, орон нутгийн төсвөөс нийт 373.5 сая төгрөг зарцуулсан.<br>○ Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх "Иргэний цахим булан"-гийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд 65.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>○ Багийн үйл ажиллагааг сурталчлах, иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор нийт багууд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан байна. | |
| 222 | | 4.3.1.3.2. Багийн нэгдсэн байрыг шинээр барьж ашиглалтад оруулах. | 2025-2028 | Улсын төсөв | 7000.0 | Шинээр ашиглалтад оруулсан байрны тоо /Тухайн жилээр/ | 5 | - | - | УТ-7200.0 | ТЗУХ | Баян-Өндөр сумын ЗДТГ ГХБХБХ ХББЗА | 2025 онд улсын төсвийн 7.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Оюут, Дэнж багийн цогцолбор төвийг шинээр барьж ашиглалтад оруулаа. Ингэснээр 2020 оноос хойш нийт 8 баг шинээр баригдсан цогцолбор төвүүдэд үйл ажиллагаа явуулж байна. | 100% |
| 223 | 4.3.1.4. Төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын нэгдсэн байрыг барих ажлыг эхлүүлнэ. | 4.3.1.4.1. Төрийн байгууллагуудын нэгдсэн байр барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх. | 2025-2028 | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Барилгын ажлын гүйцэтгэл. хувь | - | - | - | - | ТЗУХ БОНХОБТХ | ХББЗА ХААГ | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 224 | 4.3.1.5. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургаж | 4.3.1.5.1. Төрийн байгууллагууд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөр, төлөвлөгөө | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөө батлан хэрэгжүүлж буй байгууллагын тоо<br><br>Хамрагдсан албан | 28<br><br>290 | 28<br><br>295 | Батлагдсан төсвийн хүрээнд | УТ- 2624.7 | ТЗУХ | Бүх төрийн байгууллагууд | Төрийн байгууллагууд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөрийг 4 жилээр бүх албан хаагчдын саналыг авч боловсруулан баталж, 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. Төрийн албаны Салбар зөвлөл нь тайланд хугацаанд 96 төрийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна. | гарган хэрэгжүүлэх. | | | | хаагчдын тоо /тухайн жилээр/ | | | | | | | байгууллагын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд 2 удаа хяналт үнэлгээ хийж, мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч ажилласан.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны талаар дараах нөхөн төлбөрийг олгосон байна. Үүнд:<br>1. Албан ажил үүргээ гүйцэтгэж байгаа 626 төрийн албан хаагчдад албан томилолтыг зардалд 48.3 сая төгрөг<br>2. Албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн зардалд 50 төрийн албан хаагчдад 19.3 сая төгрөг<br>3. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодод нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөгжлийн бэрхшээлтэй болж, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлын тодорхой хэсгийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх, зөрүүг улсын төсвөөс нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зардалд 3 албан хаагчдад 8.1 сая төгрөг<br>4. Төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн 32 албан хаагчдад үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож 1714.4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж<br>5. Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэхэд 9 албан хаагчдад 81.0 сая төгрөг<br>6. Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авахад 21 албан хаагчдад 93.7 сая төгрөг<br>7. Хууль тогтоомжид заасан бусад нөхөн төлбөрт 295 төрийн албан хаагчдад 659.9 сая төгрөг тус тус олгосон байна. | |
| 225 | | 4.3.1.5.2. Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийг | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 1300.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт. хувь | 100% | 100% | 300.0 | ОНТ-299.5 | ТЗУХ | Төрийн байгууллагууд | “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөг шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах. | | | | Хамрагдсан албан хаагчдын тоо /тухайн жилээр/ | 97 | 95 | | | | | Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны А/365 дугаар захирамжаар батлуулан төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.<br>Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдад нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх дэмжлэгийг 9 байгууллагын 11 албан хаагчдад 85.6 сая төгрөг, төрийн албанд тогтвор суурьшилтай болон үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг Орхон аймагт амины орон сууц барих, орон сууц худалдан авах болон орон сууцны нөхцөл сайжруулахад зохих дэмжлэг 9 байгууллагын 11 албан хаагчдад 83.9 сая төгрөг, шууд харилцаатай гадаад улсын хотуудад туршлага судлуулахад дэмжлэг 10 байгууллагын 12 албан хаагчдад 70.8 сая төгрөг, өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжих дэмжлэг 4 байгууллагын 4 албан хаагчдад 8.0 сая төгрөг, эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж амжилт гаргасан, төрийн албан хаагчдыг урамшуулахад 3 байгууллагын 3 албан хаагчдад 6.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр түүний гэр бүлийн гишүүд эс, эд, эрхтэн солиулах, шилжүүлэн суулгах эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэхэд 3 байгууллагын 3 албан хаагчдад 19.0 сая төгрөг, нийт 44 албан хаагчдад 279.4 төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн.<br>Мөн төрийн хаагчийг мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх албан хаагчдыг сургалтад хамрагдахад Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн их эмч М.Алтанбек нь Солонгос Улсын Дэгү хотын Кеймюнь их сургуулийн Донан эмнэлэгт үе солих мэс заслын дараах хүндрэлийг эргэн засах чиглэлээр суралцахад 7.1 сая төгрөг, Удирдлагын академитай хамтран захиалгат 60 албан хаагчдад “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | өөрчлөлт” сэдэвт 16 цагийн танхимын сургалтын зардалд 3.6 сая төгрөг, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын төрийн албан хаагчдын “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” хойд бүсийн зөвлөгөөг 450 төрийн албан хаагчдад зохион байгуулахад 9.5 сая төгрөг, нийт сургалтад 20.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлэснээр төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. 2025 онд нийт 299.5 сая төгрөг зарцуулсан. | |
| 226 | 4.3.1.6. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг дээшлүүлнэ. | 4.3.1.6.1. Төрийн албан хаагчдыг богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх, сургалтуудад үе шаттайгаар хамруулах. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 70.0 | Албан хаагчдын тоо | 53 | 60 | 10.0 | УТ-24.7 ОН-3.6 | ТЗУХ | Төрийн байгууллагууд | Аймгийн ЗДТГ, аймгийн Төрийн албаны Салбар зөвлөл, Удирдлагын академитай хамтран 2025 оны 5 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд "Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй" сургалтыг зохион байгуулж, аймгийн ИТХ, ЗДТГ болон Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газрын 30 албан хаагч хамрагдсан.<br>Мөн Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран “Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй” богино хугацааны захиалгат сургалтад 4 байгууллагын 25 албан хаагч хамрагдсан б ба “Сэтгэлгээний өөрчлөлт” сургагч багш бэлтгэх сургалтад 3 албан хаагч хамрагдан сургагч багшаар бэлтгэгдэн орон нутагт нутгийн захиргааны 12 байгууллагын 57 албан хаагчийг хамруулан “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт 16 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, сургалтын зардалд орон нутгийн төсвөөс 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад төрийн албан хаагчдыг хамруулахаар гэрээ байгуулан ажилласнаар нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 10 байгууллагын 29, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 11 байгууллагын 13, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 4 байгууллагын 4, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулж суралцах явцад хяналт тавин ажилласан. Үүнээс орон нутгийн төсвөөс 24.7 сая төгрөгийг сургалтын төлбөрт зарцуулан мэргэшүүлэх дунд хугацааны болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтуудад нийт 14 байгууллагын 32 албан хаагчийг | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | хамруулсан байна.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг сахиу лах, соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Тайлант онд 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос тус бүр 2-12 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж бүх албан хаагчдыг хамруулсан байна. | |
| 227 | | 4.3.1.6.2. Үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг гадаад улс орнуудад хэлний болон ахисан түвшний сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх. | 2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв | 50.0 | Төрийн албанд 5-аас доошгүй жил ажиллаж сүүлийн 3 жилд нь "маш сайн" үнэлэгдэж сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо /өссөн дүнгээр/ | - | 1 | 5.0 | ОН-7.1 | ТЗУХ | Төрийн байгууллагууд | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж буй их эмч М.Алтанбекийг Солонгос Улсын Дэгү хотын Кеймюнь их сургуулийн Донан эмнэлэгт үе солих мэс заслын дараах хүндрэлийг эргэн засах чиглэлээр суралцахад "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-өөс 7.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100% |
| 228 | 4.3.1.7. Олон улсын байгууллагууд болон харилцаа, хамтын ажиллагаат гадаад орнуудын муж, хотуудтай нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 4.3.1.7.1. Хамтын ажиллагаат улсуудын хот, мужуудтай санамж бичгийн хүрээнд олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 470.0 | Санамж бичгийн хэрэгжилт, хувь /тухайн жилээр/ | 90% | 90% | 90.0 | ОНТ-170.0 | ТЗУХ | Төрийн болон ААН байгууллагууд | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Бугат хоттой хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд боловсролын салбарын хүрээнд цахим уулзалт зохион байгуулж ажилласан.<br>Орхон аймагт Бүгд Найрамдах Чех Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын ЭСЯ-дын ажилтнууд ирж ажиллах үед нь аймгийн Засаг дарга, удирдлагуудад холбогдох уулзалтыг зохион байгуулсан.<br>НҮБ-ын Хүүхдийн сантай харилцан ойлголцлын санамж бичиг шинэчлэн байгуулсан байна. Мөн Бүгд Найрамдах Киргиз улстай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.<br>ОХУ-ын "Улаан-Үд хотын эдийн засаг, соёлын өдөр" арга хэмжээг зохион байгуулан ажилласан.<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайд Шэнь Миньжуань, НҮБ-ийн Хүн Амын Сангийн тэргүүн ХалидШарифи тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзалт хийж ерөнхий боловсролын 30 сурагчид Элчин сайдын нэрэмжит тэтгэлэг олгосон.<br>2025 оны байдлаар санамж бичгийн хэрэгжилт 90 хувийн хэрэгжилттэй байна. | 100% |
| 229 | 4.3.1.8. Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй удирдлагын баримтын 60 хувийг цахимжуулж, | 4.3.1.8.1. Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй удирдлагын баримтын цахимжуулал | 42 | 45 | - | ОНТ-57.0 | ХЭЗХ | Архивын хэлтэс | Орон нутгийн төсөвт 57.0 сая төгрөгийг тусган батлуулж, цахимжуулалт хариуцсан 2 ажилтныг гэрээгээр ажиллуулж байна.<br>2025 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн шинээр ашиглалтад орж буй архивын CAMS системд хөмрөгийн бүртгэлийг үүсгэх ажлыг эхлүүлж 153 | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна. | | | | | тын хувь /өссөн днгээр/ | | | | | | | хөмрөг үүсгэгчийн хөмрөгийн хэрэг болон дансны бүрдлийн мэдээллийг бүртгэх ажил хийгдсэн. Мөн 726 хадгаламжийн нэгжийн 67660 хуудас баримтыг иж бүрэн нягтлан шалгаж, цахим хувь үүсгэж системд холбоход бэлэн болгосон. Ингэснээр нийт удирдлагын баримтын 45.7 хувийг цахимжуулсан байна. | |
| 230 | 4.3.1.9. Санхүүгийн төлбөр тооцооны суурь болох төлбөрийн баримтын хэрэглээ, үр нөлөөг сайжруулж, цахим татварын тогтолцооны хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 4.3.1.9.1. Татвар төлөгчийг мэдээллээр хангах зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 35.0 | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 4500 | 4600 | 5.0 | ОНТ-5.0 | ТГ | СТСХ | Татвар төлөгчийн зан хандлага, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг 2025 оны 01, 04, 10 дугаар сард хуулийн этгээдүүдийн цахим хаягаар болон сургалтад хамрагдсан нийт 688 татвар төлөгчдөөс авч нэгтгэсэн.<br>Судалгаагаар ирүүлсэн хамгийн их саналд үндэслэн татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 9 удаа зохион байгуулж 310 татвар төлөгч, ХХОАТ-ын тайлагнал, хөнгөлөлт, чөлөөлөлт сэдвээр 12 удаа зохион байгуулж 3817 гаруй иргэн, ААНОАТ-ын тайлагнал сэдвээр 13 удаа зохион байгуулж 486 татвар төлөгч, НӨАТ-ын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиар 12 удаа зохион байгуулж 357 татвар төлөгч, малчин, тариалан эрхлэгчдэд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж 345 татвар төлөгч, нийт 51 удаагийн сургалтад 5315 татвар төлөгч, иргэнийг хамруулсан. Мөн Татварын багц хуулиар 72 удаагийн сургалт зохион байгуулж 4426 татвар төлөгчийг танхимын сургалтад хамруулсан байна.<br>А.Амарын талбайд 2 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг, мөн багуудын өдөрлөгт 7, нийт 9 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан оролцож давхардсан тоогоор 1100 гаруй иргэнд татварын хууль тогтоомжийн зөвлөгөө, мэдээллийг өгсөн байна. Дээрх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 231 | | 4.3.1.9.2. Цахим татварын тогтолцооны хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2025-2028 | - | - | НӨАТ-ын буцаан олголтоор татвараа төлсөн татвар төлөгчийн тоо<br><br>НӨАТ-ын баримт гаргалтын сарын дундаж тоо | 6029<br><br>950000 | 6500<br><br>110000 | - | - | ТГ | СТСХ | Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшуулал болох буцаан олголтоороо хөрөнгийн татвараа төлөх боломж болон и-баримт системийг ашиглан хүсэлтээ гаргах талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст улирал бүр дунджаар 5 удаагийн давтамжтай байршуулж түгээсэн.<br>Орхон аймаг руу ордог улсын чанартай 1001 замын дагуу “Худалдан авалт бүрд төлбөрийн баримтаа авч хэвшицгээе” салбарыг байршуулсан.<br>2025 онд 6587 татвар төлөгч нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтоороо 70.5 сая төгрөгийн хөрөнгийн татварыг төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь жилийн хугацаанд буцаан олголтоороо татвараа төлөх тухайн хугацааны | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зорилтот түвшинтэй харьцуулахад 101.3 хувийг эзэлж байна.<br>Бичил болон жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг, Захиргаа хуулийн тасаг, Хяналт шалгалтын тасгийн нийт 38 байцаагч нар удирдамж болон чиглэлийн дагуу Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийн бүртгэлийг шинэчлэн, төлбөрийн баримт гаргалтыг хянан давхардсан тоогоор нийт 20 удаагийн хяналт шалгалтыг хийн зөвлөн тусалж ажилласан. 2025 онд цахим төлбөрийн баримт гаргалт өмнөх оны мөн үеийнхээс 6.64 хувийн өсөлттэй буюу сард дунджаар 1132501 баримт гаргасан байна. | |
| **Амар тайван, аюулгүй хот** | | | | | | | | | | | | | | |
| 4.4.Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ. | | | | | | | | | | | | | | |
| *4.4.1.Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил буурна.* | | | | | | | | | | | | | | |
| 232 | 4.4.1.1. Олон нийтийг авлигаас ангид байлгах, шударга ёсыг шаардах, авлигыг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг иргэн бүрд төлөвшүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | 4.4.1.1.1. Олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үзэл, шударга байдлыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг төлөвлөн зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 32.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үзэл, шударга байдлыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 98%<br><br>884 | 100%<br><br>900 | 8.0 | ОНТ-8.0 | ХЭЗХ | Төрийн байгууллагууд | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор өмгөөллийн “Миранда Партнерс” хуулийн фирмтэй хамтран Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын ажлын албаны нийт 250 албан хаагчид Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас 2025 оны 06 дугаар сард зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дарга, албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо" байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган аймгийн хэмжээнд байгаа нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчдадаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | 98%<br><br>100%<br><br>Дундаж 99.0% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалт зохион байгуулах хуваарь гарган ХЭЗХ-ийн даргаар батлуулж, хуваарийн дагуу 11 байгууллагын 148 албан хаагчид сургалт зохион байгуулсан.<br>Мөн олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр постер мэдээллийг тогтмол бэлтгэн Орхон хууль эрх зүйн хэлтэс пэйж хуудсаар дамжуулан тархааж иргэдийн хандалт давхардсан тоогоор 2000 орчим байна.<br>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай дүгнэгдсэн. | |
| 233 | 4.4.1.2.Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор дэвшилтэт технологи бүхий камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын бүсийн 80 хувьд хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 4.4.1.2.1. Хотын гудамж, зам талбайн тусгай зориулалтын болон энгийн камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 4065.0 | Суурьшлын бүсийн камержуу лалт. хувь /өссөн дүнгээр/ | 1287<br>49% | 1500<br>57% | 1065.0 | ОНТ<br>1300.0 | МШУТ | ХЭЗХ | 2025 онд орон нутгийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ, Шанд, Их залуу, Булаг багуудад тусгай зориулалтын камер 51 ширхэг, 360 градусын эргэлттэй камер 17, нэг чиглэлийн камер 120, нийтдээ 188 ширхэг хяналтын камерыг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан.<br>Ингэснээр аймгийн хэмжээнд 26 багт нийтийн эзэмшлийн зам талбайд өссөн дүнгээр чанарын стандартад нийцсэн нийт 1475 ширхэг камер Теле камерын хяналтын дэд төвд холбогдсоноос нэг чиглэлийн 1186 ширхэг, PTZ хөдөлгөөнт 196 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 41 ширхэг, царай таних 50 ширхэг камер суурилуулан ажиллуулж байна. Камержуулалтын засвар үйлчилгээний зардалд нийт 50.0 сая төгрөг тусгагдсан бөгөөд үүнээс 30.0 сая төгрөгөөр Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газартай хамтран NX Witness видео 60 лизенц авч аж ахуйн нэгж, байгууллагын гадна камер болон Жаргалант сумын 30 камерыг дэд төвд нэгтгэхээр ажиллаж байна. Мөн Дахуа системийн AI-д суурилсан Smart City системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү систем нэвтэрснээр хүний гадна төрх болон царайгаар, автомашиныг зөвхөн дугаараар бус өнгө, хэлбэр хэмжээгээр хайх, явсан замын маршрут гаргах зэрэг давуу байдал бий болсон.<br>“Тайлант хугацаанд 407 иргэн, ААНБ-ын камер шүүх хүсэлтийг хүлээн авч хяналтын камерын тусламжтайгаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 153.0 сая төгрөгийн хохирлоос 68.0 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон, хохирлыг барагдуулсан. Мөн сураггүй алга болсон 14 иргэнийг олж тогтоон ар гэрт нь хүлээлгэн өгсөн. | 88.3% |
| 234 | | 4.4.1.2.2. Авто замын хөдөлгөөнийг | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 549.9 | Ухаалаг системд холбогдсон | - | Төвийн хэсгийн авто | 354.5 | - | ХЭЗХ | БОНХОБТХ<br>ЦГ<br>МШУТ | Замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хотын төвийн 7 уулзварын гэрлэн дохиог | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хиймэл оюун ухаанаар зохицуулах ухаалаг гэрлэн дохио, гарцыг шинээр байгуулах. | | | | уулзвар, явган хүний гарцын тоо /тухайн жилээр/ | | замын 7 уулзвар, 3 гарц | | | | | автоматжуулах, алсын удирдлагад шилжүүлэх ажлыг "Прожект деволопмент солюшин" ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Эдгээр 7 уулзварын гэрлэн дохиог “Теле камерын хяналтын дэд төв”-ийн инженерүүд болон Замын цагдаагийн тасгаас 1 албан хаагч тогтмол ажиллаж, замын хөдөлгөөний нөхцөл байдлыг камераар хянан хөдөлгөөний ачаалал ихэссэн үед гэрлэн дохиог камерын тусламжтайгаар зохицуулан ажиллаж байна. Мөн хотын төвийн 19 байршилд явган хүний гэрэлтдэг гарцыг байршуулсан. | |
| 235 | 4.4.1.3. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 4.4.1.3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган, хэрэгжилтийг зохион байгуулах. | 2025-2027 | Орон нутгийн төсөв | 40.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт. хувь /өссөн дүнгээр/ | 94.3 | 96 | 13.0 | | ХЭЗХ ЦГ | Нийт төрийн байгууллагууд | Аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ, аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2025 оны төлөвлөгөө зэргийг үндэслэн “Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөг аймгийн төрийн байгууллагуудад хүргүүлж байгууллага тус бүрийг дотооддоо тусдаа төлөвлөгөө гарган ажиллах талаар чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг хагас жил тутам авч, хяналт тавин, хэрэгжилтийг зохион байгуулж ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 94 хувийн биелэлттэй байна. | 0<br>*(94-94.3/96-94.3)*100=(-0.3/1.7)*100=-17.6* |
| 236 | | 4.4.1.3.2. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цахим+Залилан” нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br><br>Цахим хандалт /тухайн жилээр/ | 500<br><br>5000 | 600<br><br>20000 | 5.0 | ОНТ-5.0 | ХЭЗХ ЦГ | Хууль, хяналтын байгууллагууд | Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны А/12 дугаар захирамжаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн даргаар ахлуулсан Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд ажлын хэсгээс 2025 онд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:<br>○ Аймгийн Цагдаагийн газартай хамтран энэ оны 1 дүгээр сард залилах гэмт хэрэг, хүний нэр төр, алдар хүндийг цахим орчинд гутаах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон 14 сошиал группийн админуудтай “Гурвалсан хариуцлагын гэрээ” байгуулан, гэрээнд хуурамч аккаунт, цахим | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | залилангийн шинжтэй мэдээ, мэдээлэл, хүний нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээллийг түгээхгүй байх тухай заалтуудыг тусган, хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг дүгнэсэн.<br>○ ЕБС-иудын ахлах ангийн сурагчдын хүрээнд “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт богино хэмжээний видео бичлэгийн уралдаан зарлан уралдаанд 5 сургуулийн 7 багийн 60 гаруй хүүхэд бүтээлээ ирүүлж, шагналт байруудыг тодруулсан.<br>○ Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 оны 05 дугаар сарын 05-30-ны хооронд хэрэгжүүлэх сургалт, нөлөөллийн ажлын удирдамжийг баталж, аймгийн Цагдаагийн газартай хамтран иргэд, оюутан, сурагчдад энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт өгөх, цахимаар залилах гэмт хэргийн үйлдэгдэж буй арга, фэйсбүүк цахим хуудас, интернэт банкны нууцлал зэрэг хувийн мэдээллээ хамгаалах талаарх сургалтыг 22 багийн нийт 545 иргэнд танхимын хэлбэрээр зохион байгуулж, сургалтад оролцогчдод залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн гарын авлага тараасан.<br>○ Мөн аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн албан ёсны “Орхон Хууль эрх зүйн хэлтэс” нэртэй фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд зориулсан зөвлөмж, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн мэдээлэл, гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд хаана хандах, хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах, телеграмм, онлайн бараа захиалга, хуурамч аккаунт, вирустэй линк зэрэг цахим залилангаас сэрэмжлэх талаар утга, агуулга бүхий постер мэдээллүүдийг тухай бүр бэлтгэж түгээсэн. Дээрх мэдээллүүд нь давхардсан тоогоор 54327 иргэнд хүрсэн байна.<br>○ ГХУСАЗСЗ, ЦГ-тай хамтран залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Хэт ашигтай саналуудын ард хохирол нуугддаг” сэдэвт нөлөөллийн аяныг 2025 оны турш зохион байгуулж, иргэд, олон нийт, төрийн байгууллагуудад чиглэсэн сургалт, сэрэмжлүүлэх мэдээллийг мэдээлэл түгээх боломжит бүх чиглэлээр түгээн ажилласан. | |
| 237 | | 4.4.1.3.3. | 2025- | Орон | 32.0 | Энэ төрлийн | 8 | 10 | 8.0 | ОНТ-8.0 | ЦГ | ХЭЗХ | 2025 оны 05 дугаар сарын 20-21-ний | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих. | 2028 | нутгийн төсөв | | гэмт хэргийн илрүүлэлт, тоо /тухайн жилээр/ | | | | | | | өдрүүдэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг хэлэлцэж устгал арга хэмжээ явуулах газартай танилцсан. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран Анзаар арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС, цэцэрлэгийн багш, ажилтан хүүхдүүдийн ар гэр, төрийн албан хаагчид, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдад урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. 2025 оны 06 дугаар сард аймгийн хэмжээнд олсны /канабис/ ургамлыг Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт устгах ажлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Тагнуулын газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газартай хамтран 60га талбайд устгах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 09 дүгээр сард “Тархцын хяналт-2025” арга хэмжээг зохион байгуулж, Дархан, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгаас Орхон аймагт орох гарах хөдөлгөөнд алба хаагчдыг 24 цагийн постод гаргаж хяналт тавьж ажилласан. 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс Гаалийн газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад хяналт тавьж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар худалдаа борлуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.<br>Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийж ажилласнаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах 3 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 238 | 4.4.1.4. Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | 4.4.1.4.1. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, хяналт, шалгалт хийх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 30.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /тухайн жилээр/ | 2 | 3 | 7.0 | ОНТ-7.0 | ЦГ | Холбогдох төрийн болон ТББ | Баян-Өндөр, Жаргалант сумдын багуудын нутаг дэвсгэрт архины хамааралтай, орон гэргүй тэнэмэл иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх согтуурах, мансуурах донтой 55 иргэний судалгааг шинэчлэн гаргаж эрүүл мэндийн нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндээрээ тэнцсэн 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулах зорилгоор “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | 12 дугаар сарын 20-ны өдөр 34 иргэнийг материалын хамт хүргүүлэн шийдвэр гаргуулж Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 437 дугаар ангид 34 иргэнийг хүлээлгэн өгсөн. Мөн ХХҮГ-тай хамтарч “Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй” төрийн бус байгууллагын нийгэмшүүлэх байранд орон гэргүй тэнэмэл 32 иргэнийг байршуулсан ба байнгын амьдарч байгаа 35 иргэн байна. Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй иргэдэд хяналт тавин ажиллаж байна. Мөн “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дотоодын цэргийн 816 дугаар анги, Дотоодын цэргийн 821 дүгээр тусгай салбар, Баян-Өндөр сумын ажлын албадтай хамтран 25 багийн нутаг дэвсгэрт хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүл шалгалтыг зохион байгуулж архины хамааралтай айл өрхийн судалгааг гарган хяналт тавьж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаагаа мэдэхгүй, унтсан, хэвтсэн 23 иргэнийг ар гэрт нь болон “Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй” төрийн бус байгууллагын нийгэмшүүлэх байранд хүлээлгэн өгсөн. | |
| 239 | | 4.4.1.4.2. Архины хамааралтай, орон гэргүй иргэдийг нийгэмшүүлэх, сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 104.0 | Нийгэмшүүлэх болон эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /тухайн жилээр/ | 55 | 50 | 26.0 | - | ЦГ | Холбогдох төрийн болон ТББ | Баян-Өндөр, Жаргалант сумдын багуудын нутаг дэвсгэрт архины хамааралтай, орон гэргүй тэнэмэл иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх согтуурах, мансуурах донтой 55 иргэний судалгааг шинэчлэн гаргаж эрүүл мэндийн нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндээрээ тэнцсэн 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулах зорилгоор “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 34 иргэнийг материалын хамт хүргүүлэн шийдвэр гаргуулж Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 437 дугаар ангид 34 иргэнийг хүлээлгэн өгч, эмчилгээнд хамруулсан. | 100% |
| 240 | 4.4.1.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 4.4.1.5.5. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 20.0 | Мал хулгайлах гэмт хэргийн тоо /тухайн жилээр/ | 10 /сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт/ | 9 | 5.0 | ОНТ-7.0 | ЦГ | Холбогдох төрийн болон ТББ | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2025 оны А/40 дугаар тушаалаар баталсан “Мал, мах-2025” хэсэгчилсэн арга хэмжээний батлагдсан удирдамжийн дагуу аймгийн нутаг | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулах. | | | | | | | | | | | дэвсгэрт уг арга хэмжээг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Цагдаагийн газрын дарга, Мал эмнэлгийн газрын дарга нараар батлуулж, хэрэгжилтийг хангах холбогдох хэлтэс, тасаг болон мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>Удирдамжийн дагуу 21 хоногийн хугацаатай 2 чиглэлд 2 тээврийн хэрэгсэлтэй 4 алба хаагч, мал эмнэлгийн газрын 2 алба хаагч нийт 6 алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж 2 зөрчил илрүүлж Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу 300000 төгрөгийн шийтгэл оногдуулж ажилласан.<br>Аймгийн хэмжээнд мал, мах худалдан борлуулдаг “Таван-Эрдэнэ” бөөний цэг, Хүлэг хүнсний зах, “Энх” худалдааны төв, гадаад орнуудад мах экспортолдог “Мон-Гема” ХХК, “Эрдэнэт мах маркет” ХХК, “Эрдмийт” ХХК, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Идэрбаялаг” ХХК, “Хатан-Оюу”, “Орхон-Энхбүтэмж” ХХК зэрэг 3 хиаман аж ахуйн нэгж, мал мах, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 200 гаруй ченж, нийтийн хоолны үйлчилгээ явуулдаг 34 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан. Хяналтаар стандартад нийцэхгүй камер суурилуулсан, хадгалах хугацаа хэт богино, үзэгдэх орчныг бүрэн хянах боломжгүй зэрэг зөрчил илэрсэн 16 аж ахуйн нэгж, байгууллагаас 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаатай 12 мэдэгдэл өгч үр дүнг тооцож ажилласан.<br>Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн судалгаанд баяжилт хийж шинээр 2 сэжигтэй этгээдийг Цагдаагийн байгууллагын судалгаа, хяналтын Patrol2.police.gov программд оруулж бүртгэлжүүлсэн.<br>Тайлант хугацаанд мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байгаа нь өмнөх оноос 100 хувь буурсан үзүүлэлттэй байна. | |
| 241 | 4.4.1.6. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны | 4.4.1.6.1. Иргэдийг эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, хэргийн оролцогчдод үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 32.0 | Өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн хүний тоо /тухайн жилээр/ | 43 | 45 | 8.0 | ОНТ-8.0 | Хууль зүйн туслалцааны төв | ХЭЗХ | Тайлант хугацаанд 45 эрүүгийн хэрэг хүлээн авснаас насанд хүрээгүй бэлгийн хүчирхийллийн 4, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 1, эрүүгийн 40 холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 28 хэргийг прокурорын болон шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлүүлж дууссан ба 2 үйлчлүүлэгч ажиллагааны явцад татгалзаж, 15 хэрэг ажиллагаанд үргэлжилж байна. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэргийн оролцогчдод хууль зүйн туслалцаа үзүүлнэ. | | | | | | | | | | | | Хууль, эрх зүйн зөвлөгөөг нийт 244 иргэнд өгч, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эхийг 27 иргэнд боловсруулан өгсөн.<br>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны 37 хүүхэд, тэдгээрийн асран хамгаалагч 36 иргэнд эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулсан. | |
| 242 | 4.4.1.7. Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 4.4.1.7.1. Хуулийн байгууллагуудад хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 6400.0 | Дэмжлэг үзүүлсэн хөрөнгө оруулалт /тухайн жилээр/ | 1582.9 | Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | 1600.0 | ОНТ 2586.5 | ХЭЗХ | Хууль хяналтын байгууллагууд | 2025 онд Цагдаагийн газрын дээвэр, гадна фасадны засвар, гэрэлтүүлгийн ажилд 109.5 сая төгрөг, энгэрийн камер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авахад 350.0 сая төгрөг, олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардалд 390.0 сая төгрөг, Хөдөлгөөнт эргүүлийн машины шатахууны зардалд 20.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлэж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон.<br>ШШГГ-т алба хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдийн амьдрах, хүмүүжих орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвийн 111.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын материал худалдан авч засвар, үйлчилгээ хийсэн.<br>ШШХ-ийн үйл ажиллагаанд олон улсын стандартыг төлөвшүүлж, магадлан итгэмжлэгдсэн лабораторид үзлэг, шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх, алба хаагчдын ажиллах, орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд орон нутгийн төсвөөс 142.4 сая төгрөгийн их засварын ажлыг 2025 оны I улиралд хийж дуусгасан.<br>Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 46.5 сая төгрөгийн өртөг бүхий гистологийн шинжилгээний OPLENIC брэндийн A16.2253 загварын дижитал микроскоп, 3.2 сая төгрөгийн өртөг бүхий хөлийн мөр илрүүлж, бэхжүүлэх A091 загварын иж бүрэн цүнх, нийт 49.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээлгэн өгсөн.<br>Архивын хэлтэст баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 57.7 сая төгрөгөөр 2 гэрээт ажилтныг ажиллуулж байна.<br>Орон нутгийн төсвийн 30.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сан хөмрөгийн өрөөний чийгшлийг хянах автомат чийгшүүлэгч, баримтын цахим нөөц хувь хадгалах зориулалт бүхий дотоод сүлжээний орчинд ажиллах файл хадгалах сан (16 TB багтаамж бүхий 2 ширхэг Seagate Nas хаардтай), олон үйлдэлт хэвлэгч, сканнерийг (A3, A5) тус тус худалдаж авч өгсөн.<br>Мөн хэлтсийн орон тоо нэмэгдсэнтэй | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | холбоотойгоор 36.3 сая төгрөгөөр 5 ширхэг иж бүрэн компьютер, 5 ажилтны ширээ сандал, шүүгээг шинээр худалдан авч ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Теле камерын хяналтын дэд төвд шинээр камер суурилуулах ажлын зардалд орон нутгийн төсвөөс 1300.0 сая төгрөгийг шийдвэрлэж, Эрдэнэ, Шанд, Их залуу, Булаг багуудад тусгай зориулалтын камер 51 ширхэг, 360 градусын эргэлттэй камер 13, нэг чиглэлийн камер 113, нийтдээ 177 ширхэг хяналтын камерыг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан. | |
| 243 | 4.4.1.8. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна. | 4.4.1.8.1. Орхон аймагт оршин суугаа гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулж, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | - | Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт. хувь /тухайн жилээр/ | 100% | 100% | - | - | ХЭЗХ ГИХГ | Сумдын ЗДТГ | Тайлант хугацаанд давхардсан тоогоор Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын иргэнийг урьж ажиллуулдаг нийт 17 аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж, амьдарч буй 24 орны 985 гадаадын иргэний баримт бичигт хяналт тавьж ажилласан.<br>Төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 4 удаагийн шалгалтыг холбогдох хууль, хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Шалгалтын дагуу зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, илэрсэн зарим зөрчлийг газар дээр нь 100 хувь бүрэн арилгуулсан. Хуульд заасан хариуцлага тооцох зөрчил илрээгүй. | 100% |
| **Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал** | | | | | | | | | | | | | | |
| 4.5.Аймгийн сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдэнэ. | | | | | | | | | | | | | | |
| *4.5.1.Аймгийн батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавх бэхжиж, гамшгийн бэлэн байдал хангагдана.* | | | | | | | | | | | | | | |
| 244 | 4.5.1.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | 4.5.1.1.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 100.0 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдал. хувь /өссөн дүнгээр/ | 5% | 7.5% | 10.0 | ОНТ-74.1 | Цэргийн штаб | Зэвсэгт хүчний 186 дугаар анги | Аймгийн Засаг даргын 2025 оны А/1004 дүгээр захирамжийг тус тус үндэслэн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг “Баян-Өндөр, Жаргалант сумдын багийн ажлын албатай харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 17-ноос 19-ний өдрүүдэд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын сургалтын танхимд зохион байгуулсан. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлын хангахын тулд аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар нийт 74.1 сая төгрөгийн нөөц бүрдүүлэх худалдан авалт хийж орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг 8 хувьд хүргээд байна. | 100% |
| 245 | | 4.5.1.1.2. Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 160,0 | Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээнд хамрагдсан иргэд.хувь | 20% | 22% | 40.0 | ОНТ-40.0 | Цэргийн штаб | Төрийн байгууллагууд | Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний заалтын дагуу нийт 30 арга хэмжээг хэрэгжүүлж батлан хамгаалах салбарын мэдээ мэдээллийг ил тод хүргэж, сурталчилгааны ажлуудыг зохион явуулж аймгийн ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээлэл, Цэргийн | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчлах талаар олон талт арга хэмжээг зохион байгуулах. | | | | /Өссөн дүнгээр/ | | | | | | | штабын цахим хуудсанд байршуулж нийт 23.5 мянган хүн буюу 22.0 хувьд нь мэдээ мэдээллийг хүргээд байна. | |
| 246 | 4.5.1.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана. | 4.5.1.2.1. Аймгийн хэмжээнд газар хөдлөлтийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх, үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах үйл ажиллагаар төлөвлөн хэрэгжилтийг хангах. | 2026-2028 | Орон нутгийн төсөв | 50.0 | Эрсдэлийн үнэлгээний тайлан<br><br>Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт. хувь /өссөн дүнгээр/ | - | -<br><br>100% | - | | ОБГ | ТЗУХ БОНХОБТХ | 2025 онд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий 3 байгууллагаас 5 аж ахуйн нэгж, байгууллага болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 8 цех, нийт 13 нэгж тайлан хянаж, мэргэжлийн зөвлөлөөр хянуулахаар 14 тайланг хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн даргаар 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр 18 заалт бүхий "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай байна. | 95% |
| 247 | | 4.5.1.2.2. Эрүүл мэндийн тусламжийн шуурхай үйлчилгээг хангах, агаараас эрэн хайх аврах ажиллагааны үед шаардагдах нисдэг тэрэг хөөрөх, буух талбайг шинээр байгуулах. | 2025-2026 | Улс, орон нутгийн төсөв | 30.0 | Нисдэг тэрэг хөөрөх, буух талбай байгуулах ажлын гүйцэтгэл. хувь | - | 50% | 20.0 | - | ОБГ БОНХОБТХ | ТЗУХ ГХБХБГ | Гал түймэр унтраах аврах 68 дугаар ангийн байрлалд баригдах Эрэн хайх аврах цогцолборт нисдэг тэрэг хөөрөх, буух талбай байгуулагдах аар төлөвлөж бөгөөд энэхүү цогцолборт баригдах 7 объектын ажлын зургийг “ЭМ, ЭС, ЭЛ” ХХК хариуцан зураг төслүүдийг боловсруулан Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар баталгаажуулсан. | 20% |
| 248 | | 4.5.1.2.3. Иргэд, олон нийтийн гамшгийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах. | 2025-2028 | Үйл ажиллагааны зардлаар | - | Гамшгийн талаарх мэдлэг ойлголт, эрсдэлийг бууруулах чиглэлээр сургалтад хамрагдсан иргэдийн тоо /өссөн дүнгээр/ | 8071 | 8200 | - | | ОБГ | БГ Мэргэжлийн ангиуд | Иргэд, олон нийтийн гамшгийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ авах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор<br>○ Удирдах албан тушаалтны сургалтыг 2 удаа<br>○ Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалтыг 85 удаа<br>○ Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтыг 134 удаа,<br>○ Иргэний сургалтыг 21 удаа<br>○ Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтыг 12 удаа,<br>○ Их дээд сургууль, оюутан сурагчдад зориулсан сургалтыг 22 удаа,<br>○ ЕБС-ийн ахлах ангийн 19, дунд ангийн 9, бага ангийн сурагчдад зориулсан сургалтыг 4 удаа,<br>○ Цэргийн дүйцүүлэх албанд 2 удаа,<br>○ Сайн дурын иргэнд 10 удаа,<br>○ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 3 удаа, нийт 321 удаагийн сургалтыг 2025 онд зохион байгуулж, 14074 иргэнийг хамруулсан байна. | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 249 | 4.5.1.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ. | 4.5.1.3.1. ЕБС-ийн сурагчид болон Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах дадлага сургууль, уралдаан тэмцээн зохион байгуулах. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | 80.0 | ЕБС, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага сургууль, уралдаан тэмцээнд хамрагдалт. хувь /тухайн жилээр/ | 40 | 65% | 20.0 | | ОБГ | БГ Мэргэжлийн ангиуд | Аймгийн Гамшгаас хамгаалах 16 алба, 22 мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ авах, анхны тусламж үзүүлэх ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилготой төр, хувийн хэвшлийн байгууллагуудын анхны тусламжийн нөхөрлөлүүдийн дунд "Аврагч-2025" тэмцээнд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 18 байгууллагын 144 алба хаагчид хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан “Өсвөрийн аврагч-2025” тэмцээнд 7 багийн 49 сурагч оролцсон. Хамрагдалтын хувь 53.2 хувьтай байна. Багш нарын ажил хаялт зарласан хугацаа давхацсан учраас багуудын оролцоо буурах шалтгаан болсон. | 52.8% |
| | Дундаж үнэлгээ | | | | | | | | | | | | | 88.5% |

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР